

ЛИФТИЙГ ТӨХӨӨРӨМЖЛӨХ, АЮУЛГҮЙ АШИГЛАХ ДҮРЭМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Бүх төрлийн 100 кг ба түүнээс дээш даацтай лифтийг үйлдвэрлэх, угсрах, хийцийн өөрчлөлт хийх болон ашиглах үеийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Энэхүү дүрэмд уулын үйлдвэр, гүний уурхай, нисэх онгоц, усан замын хөлөг болон бусад хөвөгч байгууламжид төхөөрөмжлөгдсөн лифт хамаарахгүй.

1.3. Энэхүү дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр харгалзахгүйгээр лифт ашиглагч бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө.

1.4. Дүрэмд зөвхөн лифтийн төхөөрөмжийн онцлогтой холбогдох техникийн шаардлагуудыг тусгасан бөгөөд бусад дүрмээр зохицуулагддаг цахилгаан, механик болон барилгын хийцийн талаар мөрдөгддөг техникийн шаардлагуудыг давтан тусгаагүй болно.

1.5. Энэхүү дүрмээр лифтийг ашиглах түүнд засвар, үйлчилгээ, хяналт, туршилт, магадлал хийх, лифтээр зорчих үеийн болон лифтийн орчинд байх хүмүүс, лифт суурилуулсан объектын аюулгүйн шаардлагыг хангана.

1.6. Шинээр үйлдвэрлэгдсэн болон нийлүүлэгдэж байгаа лифт бүр дараах бичиг баримтын бүрдэлтэй байна:

1.6.1. Техникийн паспортод / 2 дугаар хавсралтын дагуу/:

- Лифтийг угсрах ажлын зураг.
- Элементүүдийн тайлбар бүхий цахилгааны зарчмын болон холболтын схем.
- Үйлдвэрлэсний дараа зайлшгүй туршигддаг агрегат, зангилаа, эд ангийн туршилтын акт.
- Лифтийг хэрэглэж болох зөвшөөрөл.

Үрэгдсэн паспортыг дүрмийн хавсралтад байгаа загварын дагуу шинээр бүрдүүлэх нөхцөлд түүнийг лифтэнд хяналт тавих эрх бүхий байгууллага баталгаажуулсан байна.

1.6.2. Лифтийн ашиглалтын зааварт дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- Лифтийн хийц, бүтэц, ажиллах зарчим.
- Лифтийг аюулгүй ашиглах нөхцөл, тавигдах шаардлага, засварлах, оношлох, техникийн үйлчилгээ хийх заавар.
- Лифтийг гацсан үед бүхээгнээс хүмүүсийг гаргах заавар.
- Түргэн элэгддэг эд ангийн жагсаалт.

1.6.3. Лифтийг угсрах технологийн заавар.

1.6.4. Лифтийг дагалдан ирэх сэлбэг, багаж хэрэгсэл, үйлдвэрлэгчээс ашиглалтын явцад ашиглахыг зөвлөсөн тослох болон бусад материалын тухай мэдээлэл.

Эдгээрийг захиалагч /хөрөнгө оруулагч/-ийн хүсэлтээр өөрчлөн тогтоох ба захиалагч нь лифт нийлүүлэх гэрээнд тусгасан байна.

1.6.5. Лифтийн иж бүрдэлд ордог, түүний туршилт тохируулгын үед хэрэглэх багаж, тоноглолын жагсаалт.

1.6.6. Лифттэй хамт нийлүүлэгдэх бичиг баримтын жагсаалт.

Лифтийн техникийн болон бичиг баримтын иж бүрдлийг лифт нийлүүлэгч бүрэн хариуцна.

1.7. Лифтийг угсрах түүнд засвар үйлчилгээ хийх ажил эрхлэх мэргэжлийн байгууллага нь /лифтийн паспортын үзүүлэлтүүд болон эргүүлэг /өргүүр/-ийн

байрлалыг өөрчлөхөөс бусад /энэ дүрмийн шаардлагыг биелүүлэх үүднээс лифтийг төхөөрөмжлөх зураг төсөлд өөрчлөлт хийхийг зөвшөөрнө.

Эргүүлэг /өргүүр, лебёдка/-ийн тухайн байдлаас шалтгаалж байрлалыг 180 градус эргүүлж тавьж болно.

Зураг төсөлд өөрчлөлт оруулсан тухай бичиг баримтад өөрчлөлт хийсэн мэргэжилтний гарын үсэг, байгууллагын тамга тэмдэгтэй байх ёстой.

1.8. Лифт төхөөрөмжлөх /угсрах/ үед болон ашиглалтын явцад лифтийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхүйц хийцийн ба үйлдвэрлэлийн холбогдолтой гэмтэл, согог гарвал бэлтгэн нийлүүлэгч гэмтлийг арилгах арга хэмжээ авах үүрэгтэй.

1.9. Гадаад оронд үйлдвэрлэгдсэн лифтийн техникийн бичиг баримт нь Монгол хэлэнд орчуулагдсан байна. Цахилгаан, шингэний схемийн таних тэмдэг нь олон улсын стандарттай бүрэн нийцсэн байна.

1.10. Лифтэнд дараах техникийн шаардлага тавигдана. Үүнд:

- Бүхээгийн хөдөлгөөний хэвийн /тооцоологдсон/ хурдны хэлбэлзэл 15 хувиас илүүгүй байх.
- Бүхээгийн автоматаар зогсох зогсолтын нарийвчлал ашиглалтын ердийн нөхцөлд ± 35 мм хүртэл хэмжээнд байх.
- Динамик ачаалалд ажилладаг холбоосууд нь ажлын явцад буцаж харих, салахаас хамгаалагдсан байх.
- Лифтийн хийц нь цахилгаан тэжээл тасрах болон бусад гэмтлийн үед үйлчлэх ажилчин нь бүхээгээс хүмүүсийг яаралтай гаргах боломжийг хангасан байх.
- Лифтийн хийц нь баригч ажиллаж бүхээг /эсрэг ачаа/ зогссоны дараа лебедкийг гар удирдлагаар, суурин буюу зөөврийн ачаа өргөх хэрэгслээр болон өөрийн цахилгаан хөдөлгүүрийн тусламжаар ажиллуулж, бүхээгийг баригчийн үйлчлэлээс чөлөөлөх боломжтой байх.
- Лифтийн тоног төхөөрөмж нь хэмжээ, жин, хэлбэрийн хувьд гараар өргөх боломжгүй үед өргөх төхөөрөмжөөр өргөх нөхцлийг хангасан байх.

1.11. Лифт үйлдвэрлэгч нь үйлдвэрлэгдсэн лифт бүрт өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр, барааны тэмдэг, лифтийн даац, үйлдвэрлэсэн он, үйлдвэрийн дугаарыг бичсэн пайзыг ил харагдахуйц газар байрлуулсан байх ёстой.

2. ЛИФТ СУУРИЛУУЛАХ БАРИЛГАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Лифтийн тоног төхөөрөмжийг байрлуулах зориулалттай барилгын хэсэг нь лифт ашиглалтын ба туршилтын үед түүнчлэн ган татлага буюу гинж тасрах үед үүсэх ачааллыг даахаар тооцоологдсон байна.

2.2. Лифтийн тоног төхөөрөмжийг байрлуулах барилгын хэсэг нь холбогдох барилгын норм ба дүрэм болон “Цахилгаан байгууламжийн дүрэм” /БД 43-101-03-ийн 5 дугаар бүлгийн заалт шаардлагад нийцүүлэн галын аюулгүй байдлыг хангахаар баригдах ёстой.

2.3. Лифтийн тоног төхөөрөмжийг байрлуулах зориулалтын байрны барилгын зураг төсөлд түүний ашиглалтын үед тавигдах шаардлагын дагуу халаалт, салхивчийн төхөөрөмжийг байрлуулах нөхцлийг тусгасан байна.

3. ЛИФТИЙН ХОНГИЛ

3.1. Хонгилд хүн болон бусад эд зүйлс орохоос хамгаалах аюулгүйн нөхцлийг хангасан ханаар тусгаарлана.

3.2. Бүхээг, эсрэг ачаа буюу тэнцүүлэгч нь нэг хонгилд байна.

3.3. Гадны орчноос тусгаарлагдсан хонгилын хананд дараах онгорхой хэсэг гаргахыг зөвшөөрнө. Үүнд:

- Давхруудад хонгилын хаалга суурилах нүх.
- Засвар үйлчилгээ хийх зориулалтын болон аваарийн хаалга, лифтийн ажиллагааг хянах зориулалтын нүх
- Гал гарсан үед утааг гаргах нүх.
- Агааржуулалтын систем суурилуулах нүх.
- Хонгилыг машины өрөөтэй холбосон хэсэгт угсралтын технологийн зориулалтын нүх.

3.4. Орон сууц, олон нийтийн үйлчилгээний зориулалттай барилгаас бусад барилгын хонгил хагас тусгаарлагдсан, сараалжин гэх мэт битүү бус хашлагатай байхыг зөвшөөрөх боловч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүмүүс зорчих явган шат, тавцан талын хашилтын өндөр нь 3.5м-ээс багагүй, энэ шат тавцангийн байрлал лифтийн хөдөлгөөнт хийц хэсгээс /бүхээг, эсрэг ачаа, ган татлага/ 0.5м зайтай байвал тэр нь 2.5м, 0.5-1.1м зайтай бол 2м хүртэл намсаж болно.
- Хашилт нь бүхээг талаасаа шалны ирмэгнээс 0.15м-ээс ихгүй зайд тавигдана.
- Хонгилыг нимгэн төмөр, шил, төмөр тороор хашиж болох ба энэ хашлагыг хийхдээ доор дурдсан нөхцлийг хангана. Үүнд:

а/ Нимгэн ган төмрийн зузаан 1мм-ээс багагүй.

б/ Нимгэн /ган бус/ төмрийн бат бэх нь 1мм зузаантай ган төмөр хашлагын бэх батаас багагүй байх.

в/ Шилний зузаан нь 7.5мм-ээс багагүй байх.

г/ Арматуртай шилний зузаан нь 4мм-ээс багагүй байх.

д/ Хөндий шилэн блокийн зузаан нь 4мм-ээс багагүй байх.

е/ Төмөр утсан тор нь 1.2мм-ээс багагүй голчтой утсаар хийгдэх ба хонгилын хэлхээсний дотор талд төмөр торыг чанга татаж бэхлэх.

ё/ Төмөр торыг ташуу тулаас ба хэвтээ холбоосод гадна талд нь бэхлэхийг зөвшөөрнө.

ж/ Сараалж нүхтэй нимгэн ган төмөр нь 1.5мм-ээс багагүй зузаантай байх.

з/ Төмөр утсан тор ба сараалж нүхтэй нимгэн төмөр /хашлага/ торны босоо гадаргууд 10Н /Ньютон/ хүчээр 21мм голчтой төмөр үрэл /шарик/ шахахад үрэл торны нүхээр нэвтрэх боломжгүй байх.

- Төмөр торон ба шилэн хашлагатай хонгилын хүмүүс байж болох шат, талбайтай талд нь 1мм-ээс багагүй зузаан нимгэн ган төмрөөр эсвэл үүнтэй адил бат бэх материалаар хашиж өгнө.

3.5. Бүхээгний чиглүүлэгчийн газарт тулж байгаа хэсгийн тулгуурын доорхи шалны ачааллыг тооцохдоо чиглүүлэгчийн масс дээр баригч барьсан үед үүсэх ачааллыг нэмж тооцно.

3.6. Зөөлөвч тулгуурын доорхи шалны статик хүчийг дараах томъёогоор бодно.

$$4g(K+Q), H,$$

K - бүхээг болон түүний жинг ихэсгэж болох бүх тоноглолын нийлбэр масс, кг

Q - хэвийн даацнаас үүсэх масс, кг

g - чөлөөт уналтын хурдатгал, 9.81 м/с²

3.7. Эсрэг ачааны зөөлөвч тулгуур болон тэнцүүлэгчийн шилжих хэсгийн доорх шалны статик хүчийг дараах томъёогоор бодно.

$$4g(K+xQ), H, \text{-эсрэг ачаа}$$
$$4gxK, H, \text{-бүхээгний тэнцүүлэгч}$$

K- бүхээг болон түүний жинг ихэсгэж болох бүх тоноглолын нийлбэр масс, кг

Q - хэвийн даацнаас үүсэх масс, кг

g - чөлөөт уналтын хурдатгал, 9.81 м/с²

x - даацыг эсрэг ачаатай буюу бүхээгний массыг тэнцвэржүүлэгч төхөөрөмжтэй тэнцвэржүүлэх итгэлцүүр.

3.8. Чиглүүлэгчийн хананд бэхлэгдэх хэсгийн бат бэхийг тооцох ачааллын хэмжээг чиглүүлэгчийн масс дээр баригч барих үеийн моментоос үүсэх ачааллыг нэмж тооцно.

3.9. Лифтийн дараалсан хоёр зогсоолын хоорондох зай 11 метрээс их бол лифт гацсан үед зорчигчийг гаргаж авах аваарийн хаалганы нүхийг хоёр зогсоолын хооронд гаргасан байна.

3.10. Тоног төхөөрөмжид үйлчилгээ хийх зориулалтаар хонгилд орох нээлхийг хонгилын хананд хийж болох ба тэр нь цоожлогддог хаалгатай байна. Хонгилын нээлхийн өргөн нь 500 мм-ээс багагүй, өндөр нь 600 мм-ээс багагүй байна. Хаалганы хавтас нь битүү хийгдэх ба түүний бат бэх нь хонгилын хаалганд тавигдах шаардлагыг хангана.

3.11. Хонгилд салхивчийн нээлхий хийх ба түүнийг 21мм-н диаметртэй бөмбөлөгөөр 10Н хүчээр дарахад нэвтрэхээргүй нүхтэй металл самбараар хаана. Тэр нь 440 Н ачаалал өгөхөд хэв гажилтад орохгүй байх ёстой.

Салхивчийн металл тороор хашиж болно.

3.12. Хонгилын бүх хаалганы босгоны доод хананы дотор гадаргуу дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хонгилын хананы дотоод гадаргуу нь бүхээг рүү орох талаасаа хаалганаас хоёр тийш 25 мм-ийн зайнд овгор товгоргүй байх ёстой.
- Хонгилын хаалганы босгоны дор тэгш гадаргуу бий болгоно. Түүний өндөр нь хаалга онгойх хязгаарын хэмжээний хагас дээр 0.05 м нэмсэнтэй, өргөн нь бүхээгний хаалганы нээгдэх өргөний хэмжээний хоёр талд 0.025м нэмсэнтэй тус тус тэнцүү байна.
- 5 мм-ээс илүү өө сэв, товгор байж болохгүй. Тэр нь 2 мм-ээс илүү өндөр байвал 75 градусын өнцөг үүсгэсэн налуу байна.
- Хонгилын хаалганы босгоноос доод давхрын хаалганы дээд тотго хүртэл хавтгай самбараар холбох буюу эсвэл хонгилын хананы гадаргуу нь хэвтээ хавтгайд буух проекцын хэмжээ нь 20 мм-ээс ихгүй байна.

3.13. Худагт эсрэг ачаа тулгуур дээр суух хэсгийн бүхээг талд нь 2,5 метрээс багагүй өндөртэй хаалт тавьж болно. Энэ хаалтны доод ирмэг нь хонгилын шалнаас дээш 0.3 метрээс ихгүй зайтай байна. Өргөн нь эсрэг ачааны өргөн дээр 0.1 метрийг нэмснээс багагүй байна. Харин дараах нөхцөлд дээрх хаалтыг тавихгүй байж болно.

- Эсрэг ачаа нь тулгуур зөөлөвч дээр бүрэн суусан үед түүний доод ирмэг хонгилын шалнаас дээш 2,5 метрээс багагүй өндөрт байвал.
- Эсрэг ачааны татлаганы шилжих хөдөлгөөнд саад болж байвал.

3.14. Хэд хэдэн лифтийг нэг хонгилд байрлуулах тохиолдолд лифт тус бүрийн хооронд хонгилын хашлагад хэрэглэдэг материалаар тусгаарлах хашлага хийх ёстой.

Хашлагад төмөр утсан тор хэрэглэсэн тохиолдолд утасны диаметр 1.2мм-ээс багагүй, торны сүлжилтийн нүхээр 61мм диаметртэй бөмбөлгийг 10Н хүчээр дарахад нэвтрэхээргүй байх ёстой.

Зэрэгцээ байрласан лифтийн бүхээгүүдийн ба нэг лифтийн бүхээг эсрэг ачааны хоорондох зай 500мм буюу илүү байвал энэ нь бүхээгийн оройд хайс хийсэн тохиолдолд тусгаарлах хашлагыг хонгилын худгийн шалнаас 2000мм өндөр байхаар хийхийг зөвшөөрнө.

- Хонгилын хэмжээг багасгах шаардлагатай үед дээр заасан бүхээгийн оройд хайс хашлага хийсэн тохиолдолд хонгилын хана хүртэл 500мм-ээс илүү байвал хонгилын хашлагад ашигладаг материалыг хэрэглэхийг зөвшөөрнө.

3.15. Эсрэг ачаа бүхий лифтийн эсрэг ачаа нь тулгуур дээрээ бүрэн суусан үед бүхээг хамгийн дээд байрлалд байх ба бүхээгний дээд талд 0.5x0.6x0.8 метрээс багагүй орон зай байна.

3.16. Эсрэг ачаа бүхий лифтийн бүхээг зөөлөвч тулгуур дээр бүрэн суусан үед эсрэг ачаа чиглүүлэгчийн дагуу дээш шилжих боломж 0.2 метрээс багагүй байна.

3.17. Тэнцүүлэгч бүхий лифтийн бүхээг хамгийн дээд давхраас дээш шилжих боломжит зай нь 0.5 метрээс багагүй байна.

3.18. Тэнцүүлэгч бүхий лифтийн бүхээг дээд зөөлөвч тулгуурт бүрэн шахагдан зогссон үед хонгилын өндөр нь доорх нөхцлийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Бүхээгний дээд оройгоос хонгилын дээд хучилтын хийцийн хамгийн доод цэг хүртэл зай 1м-ээс багагүй байна.
- Бүхээгний тоноглолын хамгийн дээд цэг буюу татлаганы бэхэлгээнээс хонгилын дээд хучилтын хийцийн хамгийн доод цэг хүртэл зай 0.3 м-ээс багагүй байна.
- Бүхээгний дээд талд 0.5x0.6x0.8 метрээс багагүй орон зай байна.

3.19. Тэнцүүлэгч бүхий лифтийн бүхээг доод зөөлөвч тулгуурт бүрэн шахагдан зогссон үед тэнцүүлэгчийн чиглүүлэгчийн өндөр нь тэнцүүлэгчийг дээш нь 0.3 метрээс багагүй зайд шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

3.20. Хонгилд гэрэлтүүлэг байх ба түүний унтраалга нь хонгилд мөн машины өрөөнд байна. Хонгилд байх унтраалга нь түүний хаалганаас 0.75 метрээс ихгүй зайд худагт байрлана.

3.21. Хонгилд цахилгаан хэрэглэгчийн залгуур байна.

3.22. Хонгилын элементүүдийн харилцан байрлах зай нь 1 дүгээр хүснэгтэд заасан хэмжээтэй байна.

1 дүгээр хүснэгт

Байршил	Зай /метр/	
	Багагүй	Ихгүй
Бүхээг ба хонгилын хаалганы босгоны хооронд		0.035
Хонгилын хананы дотор талаас:		
а. Бүхээгийн босго хүртэл		0.15
б. Бүхээгийн гүйдэг хаалганы хамгийн ойр байрласан хавтас хүртэл		0.15
-босоогоор онгойдог хаалгатай ачааны лифтэнд энэ зай		0.2
-хонгилын хананы 0.5м-с өндөргүй зарим хэсэгт энэ зай		0.2
Бүхээг ба хонгилын хаалганы хамгийн ойр байрласан хавтастнуудын хооронд		0.12
Хонгил нь нугастай хаалгатай, бүхээг нь эвхдэг хаалгатай бол хаалганууд хаалттай үед энэ хоёр хаалганы самбарын аль ч хэсэгт зай нь		0.15
Бүхээг ба эсрэг ачаанаас илүү гарсан хийц хэсгүүдийн хооронд	0.05	
Бүхээг /эсрэг ачаа/-ийн илүү гарсан хийц хэсэг ба чиглүүлэгчийн бэхэлгээний эдүүдийн хооронд	0.1	

3.23. Хонгилд агааржуулах систем, галын болон хамгаалалтын дохиолол, диспетчерийн хяналтын системээс бусад шугам сүлжээ, тоноглол байрлуулахыг хориглоно.

Хонгилд байх халаалтын системийн удирдлага, тохируулга нь хонгилын гадна байрлана.

4. ХУДАГ

4.1. Хонгилын доод хэсэгт дараах хэмжээ бүхий худаг хийнэ. Үүнд:

- Лифтийн бүхээг зөөлөвч тулгуурыг бүрэн шахаж зогссон үед бүхээгийн шалны доод тал, түүнээс доош илүү гарсан эд ангиас худагны шалны гадаргуу хүртэл 0.5м-ээс багагүй зайтай байвал зохино.
- Бүхээг хамгийн доод давхарт ирсэн үед бүхээгний доорх орон зай 0.5x0.6x1.0 метрээс багагүй байна.
- Бүхээг, эсрэг ачаа хамгийн доод зогсоолдоо байх үед тэдгээрийн доод үзүүрээс тулгуур хүртэл 500 мм-ээс ихгүй зайтай байхаар байрлуулна.

4.2. Худгийн гүн 0.9м-ээс их хэмжээтэй бол орж гарахад зориулагдсан шаттай байна. Шат нь чиглүүлэгч зам төмрийн дагуу хажуу хананд байрлуулсан нөхцөлд түүний бэхэлгээний уртаас ихгүй, худгийн гүний хэмжээн дээр 1.5м нэмсэнтэй тэнцүү урттай байна.

4.3. Худгийн гүн 2,5м-ээс дээш бол гаднаасаа онгойдог, цоожтой энэ дүрмийн 7.7-д заасан шаардлагыг хангасан хаалга байх бөгөөд түүний хаагдсан байдлыг шалгах цахилгааны таслагчтай байна. Хаалга нь 500x1800 мм / өргөн ба өндөр/ хэмжээтэй байна.

4.4. Худаг нь хөрсний, борооны ус орохоос хамгаалагдсан байна.

4.5. Хүмүүс зорчих гарц буюу байрны дээр лифтийн хонгил байрласан тохиолдолд хонгилын доор байрласан хучилт нь ган татлага тасарсан нөхцөлд хамгийн дээд өндрөөс унаж буй эсрэг ачааны цохилтыг дааж чадахуйц бат бэхтэй байна.

Бүхээг болон эсрэг ачааны уналтаас үүсэх цохилтыг дааж чадах чадвар нь зураг төслийн байгууллагын тооцоогоор батлагдсан байх ёстой.

4.6. Худагт лифтийн бүх удирдлагыг таслах гар салгуур тавигдана.

Энэ салгуур нь худгийн хаалганаас гар хүрэх боломжтой, шаландаа ойрхон, тасалсан нөхцөлд өөрөө эргэж залгагддаггүй байх шаардлагатай.

Худгийн гүнээс хамаарч нэг ба хоёр салгуур байж болно.

4.7. Хэрэв худгийн хаалга, түүний шалны хооронд 1,5 метрээс ихгүй зайтай бол нэг салгууртай байна. Энэ үед салгуур худгийн шалнаас 2м, хаалганы босгоноос дээш 0.45м, хажуу тийш 0.75 метрээс ихгүй зайд байрлана.

4.8. Хэрэв худгийн хаалга түүний шалны хооронд 1.5 метрээс их зайтай бол хоёр салгууртай байна. Энэ үед доод салгуур худгийн шалнаас 1,2м, дээд салгуур хаалганы босгоноос дээш 1,0м, хажуу тийш 0,75 метрээс ихгүй зайд байрлана.

4.9. Худагт лифтийн тоног төхөөрөмжийг шалгах, түүнд үйлчилгээ хийх үедээ дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Бүхээгний ажиллагааг салгах салгуур худагт байх ба бүхээг зогссон үед бүхээгний тоноглолын хамгийн доод цэгээс шал хүртэл 2.0 метрээс багагүй зайтай байна.
- Бүхээгийг эргээд ажиллагаанд оруулах үйлдлийг ослоос хамгаалах цахилгаан хэрэгслээр хянадаг байх.

5. МАШИНЫ БА БЛОКИЙН ӨРӨӨ.

5.1. Лифтийн тоног төхөөрөмж гэдэг нь эргүүлэг /өргүүр/ түүнтэй холбоотой механик, цахилгаан тоноглол, блокийг хэлэх бөгөөд эдгээр нь гадны нөлөөллөөс хамгаалагдсан тусгай өрөөнд байна. Үүнийг машины өрөө гэнэ. Түүнд гадны хүн зөвшөөрөлгүй орохыг хориглоно.

5.2. Машины өрөөнд орох замын хэсэгт дүрмийн шаардлагыг хангасан гэрэлтүүлэгтэй байна. Түүний унтраалга нь газраас дээш 1.6 метрээс ихгүй өндөрт хаалганаас 0.75 метрээс холгүй байна.

5.3. Машины өрөөнд орох зам нь саадгүй байх ба цутгамал эсвэл угсармал төмөр бетон шатаар шууд орно.

5.4. Орох хаалганы босгоны өмнө 0.5 метрээс багагүй өргөнтэй тавцан байх ба түүний өндрийн түвшин 0.5 метрээс өндөр бол 0.9 метрээс багагүй өндөр хашлагатай байна.

5.5. Машины өрөөнд лифттэй холбогдолгүй ямар нэг тоног төхөөрөмж, шугам сүлжээ байхыг хориглоно. Машины өрөөнд дараах төхөөрөмжүүд багтана. Үүнд:

- Лифтэнд техникийн үйлчилгээ хийх зориулалтын багаж, тоног төхөөрөмж.
- Агааржуулах, халаах, хөргөх тоноглол. Гэхдээ уурын халаагуур байж үл болно.
- Галын ба хамгаалалтын дохиолол.
- Гал унтраах хэрэгсэл.

5.6. Машины өрөөнд лифтэнд засвар хийх зориулалтын өргөх төхөөрөмж байрлуулах шаардлагатай ба түүний хажууд даац, зөвшөөрөгдөх ачааллыг бичсэн байна. Засварын үед аюулгүй нөхцлийг хангаснаар өөр өргөх төхөөрөмжийг ашиглаж болно.

5.7. Машины өрөөнд хоёр буюу түүнээс дээш лифтийн төхөөрөмж байрласан тохиолдолд эргүүлэг /өргүүр/, оролтын төхөөрөмж, удирдлагын аппаратууд дээр аль лифтэд хамаарах тухай тэмдэглэгээ хийнэ.

5.8. Оролтын төхөөрөмжийг машины өрөөний хаалганы ойролцоо, бага хүчдэлийн удирдлагын төхөөрөмжөөс тусад нь байрлуулна. Түүнийг залгах, салгах татуургыг шалнаас дээш 1200-1600 мм өндөрт байрлуулна.

5.9. Удирдлагын төхөөрөмжийн өмнө түүнд үйлчилгээ хийх дараах боломж бүхий зай талбай байна. Үүнд:

- Удирдлагын төхөөрөмжийн шкаф газраас дээш 0.75 метрээс багагүй зайд.
- Өргөн нь шкафын өргөнөөс багагүй ба 0.5 метрээс их байна.

5.10. Машины ба блокийн өрөө нь бүх талдаа нийт өндрийн хэмжээгээр хашигдсан хана, хучилт /дээвэр/ ба шалтай байна.

5.11. Машины ба блокийн өрөөний хаалга нь гадагшаа онгойдог, цоожтой, самбар нь металл листээр бүрэгдсэн байна. Хаалганы хэмжээ нь:

- машины өрөөнийх 0,8 x 1,8 м
- блокийн өрөөнийх 0,6 x 1,4 метр байна.

5.12. Машины өрөөний хаалганы самбарын аль ч талаас нь 5 см² дурын талбайд 300Н хүч үйлчлэхэд 15 мм-с илүүгүй хотойх ба ачааллыг авсаны дараа хэв гажилтгүй байна.

5.13. Машины өрөөнд нээлхийгээр дамждаг байнгын орц хийхийг хориглоно.

5.14. Блокийн өрөөнд үйлчилгээ хийх нээлхийн хэмжээ нь 0,8 x 0,8 метрээс багагүй байна.

5.15. Нээлхий нь зөвхөн дээшээ машины өрөөнөөс онгойдог, цоожлогддог тагтай байна. Түүнийг онгойлгох хүч нь 150Н-оос ихгүй байна. Нээлхийн хаалттай

байгаа тагны 0.2x0.4 метр талбайд 2000Н хүчээр үйлчлэхэд үлдэгдэл хэв гажилт үүсэхгүй байх.

5.16. Нээлхийн таг нь сунадаг шатаар тоноглогдсон нөхцөлд доош онгойдог байдлаар хийгдэж болно.

5.17. Машины өрөөний шалыг тоос гаргадаггүй, хальтаргаа үүсгэдэггүй гадаргуутай хийх ба хана, дээврийг нь цайвар өнгөтэй тосон будгаар будна.

5.18. Машины өрөөний эргүүлэг /өргүүр/-ийн механизм суурилсан тавцангаас хучилтын доод хэсэг хүртэл 2.2м-ээс багагүй зайтай байна.

5.19. Машины өрөөний эргүүлэг /өргүүр/-ийн механизм суурилсан тавцангаас, засварын ажилд хэрэглэдэг өргөх төхөөрөмжийг зүүх дам нуруу, сэнж хүртлэх зай 2.0м-ээс багагүй байна. Өргөх төхөөрөмжийг зүүх дам нуруу буюу сэнж нь лифтийн техникийн паспортанд заагдсан зургийн дагуу хийгдсэн байна.

5.20. Эргүүлэг /өргүүр/-ийн механизмын эргэлдэх хэсгийн дээд талд 0.5 метрээс багагүй өндөртэй зай байна.

5.21. Татлага чиглүүлэгч блокийг машины өрөөнөөс шалгах, турших, үйлчлэх боломжтой нөхцөлд түүнийг хонгил дотор байрлуулж болно.

5.22. Блокийн өрөөний шалны түвшингээс түүний хучилтын доод хэсэг хүртэл 1,5м-ээс багагүй зайтай байх ёстой. Блокны дээд талд 0.3 метрээс багагүй өндөртэй зай байна.

5.23. Механик төхөөрөмжид үйлчилгээ хийх болон бүхээг шилжүүлэх гар удирдлагын орчинд 0.5x0.6 метрийн зайтай талбай байна.

5.24. 5.22, 5.23-т заасан орчинд очих зам нь 0.5 метрээс багагүй өргөнтэй байх ба энэ замд хөдөлгөөнт механизм байхгүй тохиолдолд энэ зай 0.4 м байж болно.

5.25. Машины /блокийн/ өрөөний шал нь янз бүрийн түвшинд байрласан байж болох бөгөөд шалны түвшингийн зөрүү 0,35м-ээс дээш бол байнгын шат хийж өгөх ба өндөр нь 0.5 метрээс их бол шатанд хашлага хийнэ.

5.26. Машины ба блокийн өрөөний шаланд ган татлага нэвтрэн гарах нүх хийж өгөх ба нүхний ирмэг, ган татлагын хоорондох зай нь 0.01м -ээс багагүй, 0.05 метрээс ихгүй байна. Нүхний ирмэг дээр эргэн тойронд нь 0,05 м-ээс багагүй өндөртэй хашлага хийж өгнө.

5.27. Машины өрөөнд эргүүлэг /өргүүр/, цахилгаан хөдөлгүүрт хоёр талаас нь чөлөөтэй үйлчилгээ хийх тохиромжтой зай байх ба түүний өргөн нь 0,5 м-ээс багагүй байна.

5.28. Удирдах самбарт үйлчилгээг чөлөөтэй хийх зайн өргөн нь 0,75 м-ээс багагүй, өндөр нь 2 м-ээс багагүй байна. 1 метрээс илүүгүй өргөнтэй удирдах самбарын ар талаас нь аппаратуудыг бэхлэхийн тулд хэрвээ самбарын хоёр талаас үйлчилгээ хийх шаардлагатай бол хана ба самбарын хоорондох зай нь 0,5 м-ээс багагүй байна.

5.29. Машины болон блокийн өрөөгөөр дамжин барилгын өөр хэсэг рүү орох буюу гарах зориулалттай орц, гарц хийхийг хориглоно.

5.30. Машины өрөөнд хэд хэдэн эргүүлэг /өргүүр/ байрлуулсан үед хоёр лифтийн цахилгаан самбарын гүйдэл дамжуулах хамгаалалтгүй хэсгүүдийн хооронд ба нэг лифтийн хамгаалалтгүй цахилгааны самбар, нөгөө лифтийн лебедкийн хооронд 1,5 м-ээс багагүй зайтай байна.

6. МАШИНЫ ӨРӨӨГҮЙ ЛИФТИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАЙРЛАЛ

6.1. Машины өрөөгүй лифтийн тоног төхөөрөмж нь хонгилд байрлаж болох ба хонгилын хийц хэсэг нь лифтийн ашиглалт, туршилтын явцад үүсэх ачааллыг даахаар бат бэх хийгдсэн байна.

6.2. Тоног төхөөрөмжид үйлчилгээ хийх зай хонгилд байх ба түүний өндөр буюу хонгилын таазны тоноглолын доод хэсгээс үйлчилгээ хийх орчны шал хүртлэх зай нь 2 метрээс, түүнд орох замын өндөр нь 1.8 метрээс багагүй байна.

6.3. Эргүүлэг /өргүүр/-ийн эргэлдэх хэсгийн дээд талд 0.3 метрээс багагүй өндөртэй зай байна.

Энэ нь хөтлүүр хонгилын хучилтын яг дор байрласан нөхцөлд хамаарахгүй.

6.4. Хонгил дахь удирдлагын төхөөрөмжийн өмнө түүнд үйлчилгээ хийх зориулалт бүхий зай талбай байх ба тэдгээр нь дор дурьдсан хэмжээтэй байна. Үүнд:

- Удирдлагын төхөөрөмжийн шкаф газраас дээш 0.75 метрээс багагүй зайд.
- Өргөн нь шкафын өргөнөөс багагүй ба 0.5 метрээс их байна.

6.5. Хонгил дахь механик төхөөрөмжийн үйлчилгээ хийх орчинд 0.5x0.6 метрийн зай бүхий талбай байна.

6.6. Хонгилд үйлчилгээ хийж буй хүн бүхээг хөдөлгөөнгүй байх үед өөрөө бие даан хонгилоос гарах нөхцлөөр хангагдсан байна.

6.7. Бүхээгт гацсан хүнийг гаргах, лифтэнд динамик туршилт хийх ажлыг хонгилын гаднаас хийгдэхээр тооцсон байх ёстой.

6.8. Бүхээг дээрээс хонгилд байгаа лифтийн тоног төхөөрөмжийг шалгах, түүнд үйлчилгээ хийхдээ дараах шаардлагыг биелүүлсэн байна. Үүнд:

- Бүхээгийг гэнэт хөдлөх, шилжихээс урьдчилан сэргийлж баригчийг ашиглаж болно.
- Бүхээгийг хөдлөхөөс хамгаалах цахилгаан хамгаалалтыг зохих дүрмийн дагуу хийсэн байна.

6.9. Тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийх зай талбай нь энэ дүрмийн 5.28; 5.29-д, гэрэлтүүлэг нь 23.4-т заасан шаардлагуудыг хангасан байна.

6.10. Энэ дүрмийн 6.8-д заасан байдлаар лифтэнд засвар үйлчилгээ хийх боломжгүй нөхцөлд хонгилд тусгай зориулалтын тавцанг хэрэглэнэ.

Энэ тавцангийн талбайн дурын 0.2x0.4 метр талбайд 2000Н хүч үйлчлэхэд үлдэгдэл хэв гажилт үүсэхгүй байх ёстой.

Талбай нь энэ дүрмийн 11.7-д заасан заалтын шаардлагыг хангасан хашлагатай байна. Талбайг ажлын, ажлын бус байрлалд оруулах тусгай удирдлагатай байх ба тэр нь хонгилын гаднаас удирдагдаж, түүний ажлын бус байрлал ослоос хамгаалах цахилгаан хэрэгслээр хянагдана.

6.11. Тоног төхөөрөмж байрласан хэсэгт энэ дүрмийн шаардлагын дагуу гэрэлтүүлэг, унтраалга, розетка байрлуулна.

6.12. Лифтийн хонгилын гадна орших тоноглол нь тусгай шкафанд байрлана. Шкафын хаалга дотогшоо онгойдоггүй, цоож нь автоматаар цоожлогддог байна.

6.13. Удирдлагын тоноглол нь гадны хүн хүрэх боломжгүйгээр хамгаалагдсан байх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- “Машины өрөөнөөс удирдах” горим нь энэ дүрмийн 20.16-д заасан шаардлагын дагуу байх.
- Бүхээгний хөдөлгөөний чиглэл, түүний давхарт ирсэн тухай болон эргүүлэг /өргүүр/-ийн ажиллагааны талаар мэдээлэх гэрлэн мэдээлэл бүхий байх.
- Удирдлагын хэсгийн гэрэлтүүлэг энэ дүрмийн 23.4-т заасан шаардлагын дагуу байх.
- Удирдлагын төхөөрөмжийн өмнө талд 0.5x0.6 метрээс багагүй талбайтай, 2.0 метрээс намгүй өндөртэй зай байна.
- Лифтэнд гацсан хүнийг гаргах үед хэрэглэх хоёр талын утсан холбоотой байх.

7. ХОНГИЛЫН ХААЛГА

7.1. Хонгилын хаалга нь тухайн барилгын галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг хангасан байна.

7.2. Автомат ажиллагаатай хаалганы хавтасны статик шахах хүч нь хаагдах хөдөлгөөн хийж эхэлснээс хойш шилжих замын 1/3-тэй тэнцэх зай өнгөрсний дараа 150 Н-оос ихгүй байх ёстой.

7.3. Автомат ажиллагаатай хаалганы хавтасны хаах кинетик энерги нь /түүнд бэхэлгээтэй бүх эд ангийн хамт/ хаагдах дундаж хурдны үед 10 Ж-оос ихгүй байхаар тохируулагдсан байх ёстой. Хаалга хаагдах дундаж хурд нь хаалганы хаагдаж эхлэх үеэс хоёр хавтастай гүйдэг хаалганд 0.025м, нэг хавтастай гүйдэг хаалганд 0.05 метрээс цааш замд байх хурдтай тэнцэнэ.

7.4. Хаалга хаах үед хавтас хооронд ямар нэг зүйл хавчуулагдсан байхад хаалгыг автоматаар нээдэг сэлгэх залгууртай байна. Энэ сэлгэх залгуур нь бүхээг дээр тавигдана. Хонгилын хаалга дээр тавихыг зөвшөөрөх ба хаалга хаагдаж эхэлснээс хойш 0.05 метрээс цааш үйлчилдэг байна. Хэрэв бүхээгийн, хонгилын хаалганы сэлгэх залгуур давхар ажиллаж байх үед түүний үйлчлэх хүрээ дээрх хэмжээнд мөн адил байна. Сэлгэн залгагч байхгүй хаалганы хувьд хаалганы хаагдах үед хавчих хүч 4 Ж-с хэтрэхгүй байна.

7.5. Эвхэгдэн хаагддаг хаалганы онгойхыг эсэргүүцэх хүч нь 150Н-оос хэтрэхгүй байна. Энэ хүчийг хаалга хагас онгорхой үед түүний хаалганы хавтаснуудын захын ирмэгүүдийн хоорондох зайг 0.1 ± 0.01 метр хэмжээтэй байх үед хэмжинэ.

7.6. Хонгилын хаалгыг олон үет шилээр хийж болно. Гэхдээ шил нь түүний марк, төрөл, бэлтгэн нийлүүлэгчийн худалдааны тэмдэг, нэр бүхий пайзтай байна.

7.7. Машины өрөөний хаалганы самбарын аль ч талаас нь 5 см² дурын талбайд 300Н хүч үйлчлэхэд 15 мм-с илүүгүй хotoйх ба ачааллыг авсны дараа хэв гажилт үлдэхгүй байна.

7.8. Босоо чиглэлд гүйдэг хаалгыг зөвхөн ачааны лифтэнд тавина. Дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- Хаалга нь өөр хоорондоо хамааралгүй хоёроос доошгүй татуургаар ажилладаг байх.
- Татуургын нөөцийн итгэлцүүр нь 8-аас багагүй байна.
- Татуурга нь ган татлага байгаа нөхцөлд түүний чиглэл өөрчлөх блокны диаметр нь ган татлаганы диаметрээс 25-аас багагүй дахин их байх.
- Хаалгыг гараар хааж, нээдэг бол тэнцүүлэгчтэй байна.
- Татлага нь блок, одон дугуйнаас мултрахгүй хамгаалалттай байна.

7.9. Хонгилын нугастай автомат хаалганы хаах хүч 150 Н-оос ихгүй байна.

7.10. Хонгил нь гараар онгойдог хаалгатай нөхцөлд түүний давхар бүрт бүхээг тухайн давхарт ирж байгааг мэдээлдэг дохиолол байна.

7.11. Автоматаар онгойж хаагддаг ачааны болон бусад лифтний хонгилын хаалганд шагайвч нүх гаргаж болно. Шагайвч нүх нь энэ дүрмийн шаардлагыг хангахуйц бат бэх байна. Шагайвч нүхийг 0.006м-ээс багагүй зузаантай тунгалаг материалаар хийнэ.

7.12. Шагайвч нүхний өргөн ба диаметр нь 0.15м-ээс илүүгүй, 0.06м -ээс багагүй хэмжээтэй байх ба түүний доод ирмэг нь шалнаас 1м-ээс дээш өндөрт байрласан байна.

7.13. Хонгилын хаалганы гадаргууны товгор нь 50 мм-ээс илүүгүй хэмжээтэй байх ба хэвтэй хавтгайд 60 град-аас багагүй налуу болгон засал хийсэн байна.

7.14. Хонгилын хаалганы өндөр нь 2.0м-ээс багагүй, өргөн нь бүхээгийн хаалганы өргөнөөс илүүгүй байна.

- 7.15. Хонгилын хаалга нь босготой байх ба тэр нь бүхээгт ачаа ачих үеийн ачааллыг даахаар хийгдсэн байна.
- 7.16. Гүйдэг автомат хаалганы самбарын гадна талд овгор, товгорын хэмжээ 0.003 метрээс ихгүй байх ба хурц ирмэгийг дарсан байна.
- 7.17. Хаалга хаалттай үед түүний эргэн тойронд үүсэх аливаа завсар 0.006 метрээс ихгүй байна.
- 7.18. Хаалгыг онгойлгохоор 150Н хүчээр үйлчлэхэд хаалганд үүсэх завсар дараах хэмжээнээс ихгүй байна:
- 7.18.1. Нэг хавтастай гүйдэг хаалганд 0.03м.
- 7.18.2. Хоёр хавтастай гүйдэг хаалганд 0.045м.
- 7.19. Хэвтээ чиглэлд гүйдэг хаалганы самбар эргэн тойрондоо хонгилын хаалганы нүхний ирмэгээс цааш 0.015м хэмжээтэй зөрж орсон байна.
- Харин дээш гүйж ордог хаалганы самбарын дээд хэсэг зөрж орсон байх албагүй. Хажуу тийш гүйдэг хаалгатай хонгилын зөвхөн нэг хаалга нь онгойдог нөхцөлд хаалганы хоёр хавтасны зөрөх хэмжээ нь 0.015м, самбар хоорондын завсар нь 0.006 метрээс ихгүй байна.
- 7.20. Лифтийн хонгилын хаалга нь бүхээг давхрын зогсоолын талбайгаас хөдлөөд 0.2м явахаас өмнө өөрөө түгжигддэг автомат цоожоор тоноглогдсон байна.
- 7.21. Автоматаар онгойдог хонгилын хаалгатай хүн зөөврийн лифтийн хаалганы цоож бүхээгийн шалны түвшин зогсоолын шалны түвшинд 0.2м-ээс ихгүй зайд ойртсон тохиолдолд онгойдог ба энэ үед бүхээгийн хурд нь 0.63м/с, харин ачааны лифтэнд 0.3м/с-ээс ихгүй байна.
- 7.22. Автомат цоожны тээглүүр нь хоногтоо 0.007 метр гүн орсны дараа бүхээг хөдөлгөөнд орохоор хийгдэх ба энэ нь ослоос хамгаалах цахилгаан хэлхээгээр хянагддаг байна.
- 7.23. Хаалгыг онгойлгохоор түүнд 300Н хүч үйлчлэхэд хаалга онгойхгүй байх шаардлагатай.
- 7.24. Шаардлагатай тохиолдолд хаалганы түгжээг үйлдвэрийн лабораторид туршсан байх ба тэр тухай дээр нь тэмдэглэл хийсэн байна.
- 7.25. Хоёр буюу түүнээс дээш хавтастай хонгилын хаалганы хавтас бүрийн дээд талд автомат цоож байрлуулах албагүй. Энэ тохиолдолд аль нэг хавтас дээр байрлуулсан цоожлогч нь бүхээг ирээгүй тохиолдолд бусад аль ч хаалганы хавтсыг онгойлгохгүй байхаар тавигдсан байна.
- 7.26. Автомат цоожийг хонгилын хаалга гадна талаас онгойлгох боломжгүй байхаар угсарна. Харин лифтийн үйлчилгээний мэргэжлийн хүмүүс хонгилын хаалганы түгжээг хонгилын гадна талаас тусгай түлхүүрээр онгойлгохыг зөвшөөрнө.
- 7.27. Хонгилын хаалга нь гараар нээж хаагддаг байвал автомат цоожноос гадна хаалгыг түгжих автомат бус цоож буюу хаалгыг хаалттай байдалд тогтоож байх хэрэгслээр тоноглогдсон байх ёстой
- 7.28. Дээрх хаалга бүрийг хаалттай байхыг хянах ослоос хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байх ба хаалга хаагдахад автоматаар түгжигддэггүй байна.
- 7.29. Гараар онгойдог автомат бус цоожоор тоноглогдсон хаалгатай лифтийн хонгилын зөвхөн хамгийн доод давхрын хаалганд гаднаас онгойдог гар бариул хийхийг зөвшөөрнө.
- 7.30. Бүхээгийн автомат хаалганы тусламжтайгаар онгойж, хаагддаг хонгилын хаалга нь бүхээг тухайн давхарт байхгүй тохиолдолд өөрөө автоматаар хаагдаж цоожлогддог байх ёстой.
- 7.31. Бүхээгийг удаан хугацаагаар зогсоох буюу засвар хийх тохиолдолд хонгилын хаалганд нэмэлт түгжээ хийх ёстой. Нэмэлт түгжээг тусгай түлхүүрээр онгойлгоно. Автомат бус цоожоор тоноглогдсон дотроос удирдлагатай лифтийн хонгилын хаалганд нэмэлт түгжээ хийхийг хориглоно.

7.32.. Хонгилын хэвтээ чиглэлд гүйдэг хаалга нь дээр, доороо мөн босоо чиглэлд гүйдэг хаалга нь хоёр талдаа /хажуугаасаа/ чиглүүлэгчтэй байна. Хонгилын хаалганы хавтас нь чиглүүлэгчээсээ мултрахааргүй хийгдсэн байх ёстой.

7.33. Автомат цоожоор тоноглогдсон хонгилын хаалганы түгжээ бүрэн цоожлогдсон эсэхийг болон хонгилын хаалганы 2 хавтасны хаагдсан болон түгжигдсэнийг таслагчуудын тусламжтайгаар хянаана.

8. ХОНГИЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ, АВААРИЙН ХААЛГА БА НЭЭЛХИЙ.

8.1. Аваарийн, үйлчилгээний хаалга болон нээлхийн бат бэхэд тавигдах шаардлага нь хонгилын хаалганд тавигдах шаардлагын адил байна.

Аваарийн хаалга нь шагайвч нүхтэй бол өргөн нь 120 мм-ээс ихгүй байх ба хонгилын хаалга хийдэг материалаар хийгдсэн байна.

8.2. Аваарийн хаалганы өндөр нь 1,8 м, өргөн нь 0,35 м-ээс үйлчилгээний хаалганы өндөр нь 1.8м, өргөн нь 0.6м-ээс багагүй, нээлхийн өндөр нь 0.5м өргөн нь 0.5м-ээс ихгүй байх ба хаалга нь дотогшоо онгойдоггүй, гаднаасаа тусгай түлхүүрээр онгойдог, автоматаар түгжигддэг цоожоор тоноглогдсон байна. Үйлчилгээний болон аваарийн хаалга нь дотроосоо түлхүүргүйгээр онгойдог байна.

8.3. Аваарийн хаалга түгжигдсэн эсэхийг ослоос хамгаалах хэрэгслээр хянаана. Түгжигдсэн байдлын хяналт нь хаалга хаагдсан эсэхийг хянадаг хяналтаас хамаарахгүй байна.

9. ЧИГЛҮҮЛЭГЧ

9.1. Бүхээг, эсрэг ачаа, тэнцүүлэгч нь чиглүүлэгч зам төмрийн дагуу хөдөлнө.

9.2. Чиглүүлэгч, түүний бэхэлгээ нь бүхээг, эсрэг ачааны баригч ажиллах үед эсрэг ачаа /бүхээг/-г чиглүүлэгч дээр найдвартай зогсоож байх нөхцлийг хангаж байвал зохино.

9.3. Дараах нөхцөлд чиглүүлэгч гулзайхгүй байх шаардлагатай. Үүнд:

- Бүхээг, эсрэг ачаа, тэнцүүлэгчийн гулгагч чиглүүлэгчээс мултрах үед.
- Ослоос хамгаалах хэрэгслийн ажиллагаа гацсан үед.

9.4. Чиглүүлэгчийн гулзайлт нь баригчаар тоноглогдсон бүхээг, эсрэг ачаа, тэнцүүлэгчийн хоёр чиглүүлэгчийн тэнхлэг хооронд 0.005м, баригчаар тоноглогдоогүй эсрэг ачаа, тэнцүүлэгчийн чиглүүлэгчүүдийн тэнхлэг хооронд 0.01 метрээс илүүгүй байхаар байна.

9.5. Баригчийн төхөөрөмж ажиллах үед бүхээг, эсрэг ачаанаас чиглүүлэгчид үйлчлэх хүчний үйлчлэлээр чиглүүлэгч зам төмөр хотойх үед гулгагчийн ховилоос зам төмөр гарахгүй байхаар тохируулагдсан байна.

9.6. Чиглүүлэгчийн урт нь бүхээг ба эсрэг ачаа худагт байрласан тулгуур дээр суух үед бүхээгийн /эсрэг ачааны/ гулгагч нь чиглүүлэгч зам төмрөөс мултарч гарахааргүй байвал зохино.

9.7. Чиглүүлэгч, түүний залгаасууд нь уулзвар хэсгээрээ шилжих боломжгүй буюу сул хөдөлгөөнгүй байхаар бэхлэгдсэн байна.

9.8. Чиглүүлэгчийн бэхэлгээ нь барилгын суулт, бетоны агшилт, дулааны хэв гажилтын үед 4 чиглэлд шилжилт хийх боломжтой байх.

10. ЭРГҮҮЛЭГ (ӨРГҮҮР)

10.1. Лифтэнд дараах төрлийн эргүүлэг /өргүүр/-ийг хэрэглэнэ. Үүнд:

- Туузан буюу ган татлагыг зөвхөн үрэлтийн хүчний тусламжаар, өөрөөрөө дамжуулан шилжүүлэх дамар буюу хүрдтэй.
- Ган татлагыг өөртөө бэхлэн ороож татдаг хүрдтэй.

- Гинжин татлагатай.

10.2. Лифтийн эргүүлэг /өргүүр/ болон түүний бэхэлгээнүүдийг лифтийн ашиглалт, туршилтын үед үүсэх ачааллыг даахаар тооцож угсарсан байна. Харин ган татлагыг өөртөө бэхлэн ороож татдаг хүрдтэй болон гинжин татлагатай эргүүлэгт /өргүүр/ бүхээгийг дээд тулгуурт тулах үеийн ачааллыг нэмж тооцно.

10.3. 0.63 м/с-ээс дээш хурдтай лифтэнд татлагыг ороож татдаг хүрдтэй болон гинжин татлагатай эргүүлэг /өргүүр/-ийг ашиглахыг хориглоно.

10.4. Татлагыг өөртөө ороож татдаг хүрдтэй болон гинжин татлагатай эргүүлэг /өргүүр/ бүхий лифтэнд эсрэг ачаа бус, тэнцүүлэгч ачаа хэрэглэнэ.

10.5. Лифтийн эргүүлэг /өргүүр/-ийн оронд цахилгаан таль хэрэглэхийг хориглоно.

10.6. Хөтлөх дамартай лифтийн дамрын ховил, татлаганы хооронд үүсэх үрэлтийн хүч нь лифтийн ажлын үе болон туршилтаас үүсэх ачааллыг бүрэн дааж байх ёстой.

10.7. Лифтийн ажиллагааны болон туршилтын үед татлага нь дамжуулах, чиглүүлэгч элементээс мултрах ёсгүй .

10.8. Ган татлагын дамжуулах элемент, тоормосны хүрдний хооронд салдаггүй кинематик холбоос байна .

10.9. Цахилгаан хөдөлгүүрээс мушгих моментыг туузан дамжуулгаар дамжуулж болох боловч энэ үед 2-оос доошгүй тууз хэрэглэх ба туузны чангалалтыг ослоос хамгаалах цахилгаан хэрэгслээр хянана.

10.10. Эргүүлэг /өргүүр/-ийн араат дамжуулга, редуктор , цахилгаан хөдөлгүүрийн голын чөлөөт үзүүр нь хаалт хашлагатай байна.

Бүхээгийг шилжүүлэх гар удирдлага, тоормосны хүрдэнд хаалт хамгаалалт хийх шаардлагагүй ба ажлын бус гадаргууг нь шар өнгөөр будсан байна.

10.11.Эргүүлэг /өргүүр/-ийг гараар эргүүлэх дугуй бариул хийсэн байх ёстой. Ачаатай бүхээгийг /хэвийн даацтай тэнцэх/ дээш өргөх үед дугуй бариулд үйлчлэх хүч нь 235Н-оос ихгүй байна. Энэ дугуй бариулыг хэрэглээгүй үед редукторын гол дээрээс салгаж авч байхаар хийнэ. Энэ бариулыг хигээстэй буюу тахир хэлбэртэй хийхийг хориглоно.

Эргүүлэгийн дугуй бариул дээр лифтийн бүхээгийг өргөх буюу буулгах үеийн эргэлтийн чиглэлийг сумаар заасан байна. Дугуй бариулыг редукторын гол дээр суулгах үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээ салсан байх мөн бүхээгний шилжилтийг машины өрөөнөөс ажиглах боломжтой байх шаардлагатай.

10.12. Татлагыг өөртөө ороож татдаг хүрдтэй эргүүлэг /өргүүр/ны хүрд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хүрдний ажлын гадаргуу нь ган татлагын диаметртэй дүйх ховилтой байна.
- Хүрдэнд ган татлагаас дээш ган татлагын диаметртэй тэнцэх хэмжээний өндөр хашлага байна.
- Бүхээг доод зөөлөвч тулгуур дээр бүрэн суусан үед хүрдэнд татлаганы бэхэлгээний хэсгээс гадна 1,5 ороодсын нөөц үлдсэн байна.
- Хүрдэнд татлага зөвхөн нэг үеэр ороогдсон байна.
- Доош татагдсан татлага, хүрдний ховилтой түүний уртын дагуу байрлах босоо хавтгай дээр үүсгэх өнцөг нь 4 градусаас хэтэрч болохгүй.

10.13. Эргүүлэг /өргүүр/-ийг байнгын бариастай автомат ажиллагаатай тоормосоор тоногдсон байх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тоормослох момент нь пүрш буюу ачааны хүчээр үүснэ.
- Тоормос нь цахилгаанаар ажилладаг байна.

- Тоормослох хүч нь бүхээгийг бүрэн ачаалалтай хөдөлж байх үед зогсоох чадвартай байна.
- Бүхээгийг гар удирдлагаар шилжүүлж байх үед тоормосыг гараар хөндийрүүлэх бариултай байх ба бариулыг тавих үед автоматаар эргээд тоормос барьж байхаар хийсэн байна.

Эргүүлэгт /өргүүр/ туузан тоормос хэрэглэхийг хориглоно.

10.15. Эргүүлэг /өргүүр/-ийг үйлдвэрлэсэн үйлдвэрийн нэр, дугаар, эргүүлэг /өргүүр/-ийн хэв маяг, загвар, редукторын дамжуулгын харьцаа, он, сар, өдрийг бичсэн пайзыг эргүүлэг /өргүүр/-ийн редуктор дээр байрлуулсан байх ёстой.

Эргүүлэг /өргүүр/-ийг үйлдвэрийн лабораторид туршсан байх ёстой.

11. БҮХЭЭГ

11.1. Бүхээг нь туршилт хийх үеийн ба ажлын горимын үед үүсэх ачааллыг даахаар бат бэх хийгдсэн байна.

11.2. Бүхээг нь битүү хана, тааз, шалтай байх ба аваарийн хаалга, нээлхийтэй байж болно.

11.3. Бүхээгний хананд 5см^2 талбайд 300Н хүчээр үйлчлэхэд 15 мм-ээс илүүгүй хотойх ба үлдэгдэл хэв гажилт үүсэхгүй байна.

11.4. Бүхээгний ханыг үйлдвэрийн лабораторид туршсан олон үет шилээр хийж болно. Уг шилэн дээр түүний төрөл, марк, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн нэр бүхий пайз байна. Бүхээгний шилэн хананы доод хэсэгт 1.1 метр өндөрт хаалт, хамгаалалт хийж өгөх ба түүнд перпендикуляр чиглэлээр 440Н, хавтгайн дагууд нь 1270Н хүчээр дурын цэгт нь үйлчлэхэд даадаг байх шаардлагатай.

11.5. Бүхээгний дээврийн талбайн дурын хэсэгт 0.2×0.4 метр талбайд 2000Н хүчээр үйлчлэхэд даах ба үлдэгдэл хэв гажилт үүсдэггүй байх шаардлагатай.

11.6. Бүхээгний дээвэр дээр үйлчилгээ хийх хүн гарах зориулалтаар 0.12 м²-аас багагүй талбайтай, бага талын өргөн нь 0.25 метрээс багагүй хэмжээ бүхий зай байна.

11.7. Бүхээг хонгилын хананаас 0.3 метрээс багагүй зайтай байгаа тохиолдолд бүхээгний дээвэр дээр 0.9 метрээс намгүй хашлага хийнэ.

11.8. Уг хашлаганд перпендикуляр чиглэлд 440Н, хавтгайн дагууд нь 1270Н хүчээр дурын цэгт үйлчлэхэд даадаг байх шаардлагатай.

11.9. Хонгилын хананд угсарсан тоноглолоос бүхээгний дээврийн хамгийн захын цэг хүртэл зай нь 0.1 метрээс багагүй байна.

11.10. Бүхээгний дээврийн ирмэгээс түүний хашлага хүртэл зай нь 0.15 метрээс ихгүй байна.

11.11. Шилэн дээвэр нь бүрээстэй байна.

11.12. Бүхээгний дээвэр дээр удирдлагын аппарат, лифтийг зогсоох салгуур, цахилгааны тэжээлийн залгуур тоноглогдсон байна.

11.13. Бүхээгний хаалганы босгоны доод талд нийт өргөний хэмжээгээр дээд зах нь босготой зэрэгцсэн хэвтээ хавтгайд 60 градусын налууатай босоо хаалт байна. Хаалтны хэвтээ хавтгайд буух проекцийн хэмжээ нь 0.02 метрээс, хаалтны нийт өндөр нь босгоны өндрийг оролцуулаад 0.75 метрээс багагүй байна.

Налуу чиглүүлэгчтэй лифтний бүхээгний хаалт нь хонгилын ханатай параллель тавигдана.

11.14. Бүхээгний өндрийг шалнаас тааз хүртлэх зайгаар хэмжих ба тэр нь 2.0 метрээс багагүй байна. Өндрийг хэмжихдээ таазнаас доош 0.05м хүртлэх зайд доош унжиж байрласан тоноглолын хэмжээг тооцохгүй.

11.15. Лифтийн бүхээг нь баригч төхөөрөмжтэй байна.

11.16. Бүхээгийн хаалга суух нүхний өндөр нь хонгилын хаалганы өндрөөс багагүй байх ба 2 метрээс их байна.

11.17. Гаднаас удирдлагатай ачааны лифтийн бүхээг нь хөдөлгөөний үед ачаа гулсч унахаас хамгаалсан хашлагатай бол хаалгагүй байж болно.

11.18. Бүхээгийн хаалга нь нугастай буюу гүймэл хавтастай, гараар болон автомаар нээгдэж хаагддаг байж болно .

11.19. Бүхээгийн хаалга нь битүү хавтастай байна.

Бүхээгийн дээш гүйдэг хаалгыг хонгилын хашлагад хэрэглэдэг нимгэн төмөр буюу тороор хийж болно. Тороор хийсэн нөхцөлд түүний нүхний өргөн нь 0.01м, өндөр нь 0.06 метрээс ихгүй байна.

11.20. Бүхээгний хаалга хаагдсан үед эргэн тойронд үүсэх завсар нь 0.006 метрээс ихгүй байна.

11.21. Бүхээгийн нугастай хаалга нь зөвхөн дотогшоо онгойдог байна.

11.22. Хонгилын хаалганд шагайвч цонх байгаа нөхцөлд бүхээгний хаалганд бас байх шаардлагатай ба тавигдах шаардлага нь хонгилын хаалганы шагайвч цонхонд тавигддаг шаардлагатай ижил байна.

11.23. Автомат ажиллагаатай бүхээгийн хаалганы хавтасны шахах статик хүч, хавтасны хаах кинетик энерги нь энэ дүрмийн 7.3-д заасан шаардлагыг хангаж байх ёстой .

11.24. Бүхээгийн хаалганы хийцэд тавигдах шаардлага нь хонгилын хаалганы хийцэд тавигдах шаардлагатай ижил байна.

11.25. Бүхээг зогсоол хооронд зогсох үед автомат болон гар ажиллагаатай хаалгууд нь дотроосоо онгойдоггүй байх ёстой .

11.26. Бүхээгийн хаалганы хавтаснуудын бүрэн хаагдсан эсэхийг ослоос хамгаалах хэрэгслээр хянана.

11.27. Нэг хонгилд 2 буюу түүнээс дээш лифт байрласан тохиолдолд лифтээр зорчигчийг нэг бүхээгнээс нөгөөд шилжүүлэх аваарийн хаалга байж болох боловч тэр нь дор дурьдсан нөхцлийг хангасан байна. Үүнд:

- Хаалга нь гадагшаа онгойдоггүй байх.
- Хаалга битүү самбартай байх.
- Хоёр бүхээгийн хоорондох зай нь 0,75м-ээс ихгүй байх.
- Нэг бүхээгээс нөгөөд шилжих замд нь ямар нэг цахилгааны утас буюу ган татлага байхгүй байх.
- Нэг бүхээгнээс нөгөөд шилжих зам нь эсрэг ачааны шилжих зайн хязгаараас хамаарахгүй байх.
- Аваарийн хаалга нь дотроосоо түлхүүрээр онгойдог, гаднаасаа түлхүүргүй онгойдог цоожтой байна. Түүний түгжээтэй эсэхийг ослоос хамгаалах хэрэгслээр хянана.

11.28. Бүхээгийн аваарийн хаалганы хийц нь хонгилын аваарийн хаалганд тавигдах шаардлагыг хангасан байна .

11.29. Бүхээгийн оройд нээлхийтэй бол түүний хэмжээ нь 0,5x0,35 м-ээс багагүй битүү самбартай, гаднаасаа цоожлогддог, дотроосоо тусгай түлхүүрээр онгойдог түгжээтэй, түгжээг нь ослоос хамгаалах цахилгаан хэрэгслээр хянадаг, таг нь гадагшаа нээгддэг, нээгдсэн үедээ таг бүхээгний гадна ирмэгээс цааш гардаггүй байх.

11.30. Торон хаалгатай лифтээс бусад хүн зөөврийн лифт нь салхивчтай байна. Энэ нь лифтийг ажиллаж байхад болон эвдрэлийн улмаас зогссон үед зорчигчид шаардлагатай хүчилтөрөгчийг бүхээгт бүрэн нэвтрүүлэх зориулалттай байх ёстой.

Бүхээгийн доод хэсэгт шалны түвшингээс 300мм-ээс ихгүй, дээд хэсэгт шалны түвшингээс 1800 мм-ээс багагүй өндөрт салхивчийн нүх гаргана. Дээд доод салхивчийн нүхнүүдийн нийт талбай нь бүхээгийн шалны ашигтай талбайн 1%-иас багагүй байна. Нүхний хэмжээ нь 0.01 метрийн голчтой бөмбөлөг нэвтрэхгүй байх шаардлагатай.

11.31. Лифт нь даац хэтэрсэн тохиолдолд цахилгаан хэлхээг таслах зориулалттай хөдөлгөөнт шалтай байж болно. Бүхээгийн хөдөлгөөнт шал нь үргэлж хавтан байх ба шалны өргөн нь хаалга талдаа босгоны бүх өргөний хэмжээтэй тэнцүү, босготой нэг түвшинд байна.

11.32. Лифтийн бүхээг нь энэ дүрмийн 23.4-д заасан шаардлагыг хангасан гэрэлтүүлэгтэй байна.

11.33. Бүхээгт дараах мэдээлэл бичигдсэн байна. Үүнд:

- Даац /кг/.
- Багтаамж /хүний тоо/.
- Лифт үйлдвэрлэгч байгууллагын нэр.
- Үйлдвэрийн дугаар.

12. ЭСРЭГ АЧАА, ТЭНЦҮҮЛЭГЧ.

12.1. Эсрэг ачаа ба тэнцүүлэгчийг дор дурьдсан хүчний үйлчлэлээс хамааруулж тооцно. Үүнд:

- Лифтийн ажлын горим.
- Хэрэв эсрэг ачаа, тэнцүүлэгч баригчтай бол түүний баригч барих үед эсрэг ачаанаас баригч төхөөрөмжинд үйлчлэх хүчийг баригч барих үед байсан хурдаас.
- Тулгуур дээр суух ачааллыг бүхээгний тэр үед шилжих хурдаас.

12.2. Хэд хэдэн хэсгээс бүрдэх эсрэг ачаа, тэнцүүлэгчийг хөдөлж шилжихээс хамгаалан тусгай жаазанд байрлуулан бэхэлсэн байна.

12.3. Эсрэг ачаа, тэнцүүлэгч нь чиглүүлэгч зам төмрийн дагуу гулгагчаар шилжиж байхаар хийгдсэн байна.

13. БАРИГЧ

13.1. Хурд хязгаарлагч ажилласнаар бүхээг (эсрэг ачаа ба тэнцүүлэгч) доошоо явах үед баригчийн төхөөрөмж бүхээгийн хөдөлгөөнийг зогсооно.

Дээшээ шилжиж байгаа бүхээгийн хурд хэвийн хэмжээнээс хэтэрсэн нөхцөлд удаашруулах буюу зогсоох баригч хэрэглэхийг зөвшөөрнө.

13.2. Баригч нь үйлдвэрийн лабораторид туршигдсан байх ёстой.

13.3. Бүхээг ба эсрэг ачаа, тэнцүүлэгчийн баригч төхөөрөмжийг нэг хурд хязгаарлагчийн тусламжтайгаар ажиллуулахыг хориглоно.

13.4. 1 м/с-ээс бага хурдтай лифтийн баригч нь үндсэн татлага тасарснаас буюу суларснаас хамаарч ажилладаг байж болно.

13.5. 2.0 м/с-ээс дээш хэвийн хурдтай бүх төрлийн лифтний бүхээг, эсрэг ачаа, тэнцүүлэгчид удаашруулан зогсоох баригчийн төхөөрөмжийг хэрэглэнэ.

13.6. 1м/с хүртэл хурдтай лифтэнд зөөлөвч амортизатор бүхий огцом зогсоох баригч хэрэглэж болно.

13.7. 0.63м/с хүртэл хурдтай лифтэнд энгийн огцом зогсоох баригч хэрэглэж болно.

13.8. Чиглүүлэгч тус бүрд баригч байвал бүгд ижил төрлийн баригч байна.

13.9. Баригчаар зогссон лифтийн бүхээгийг буцаах хөдөлгөөнд оруулах үед баригч нь шууд дараагийн ажиллагаанд бэлтгэгдсэн байх ёстой.

13.10. Баригч ажиллах үед хоосон бүхээгийн зогсох хамгийн их хурдатгал нь 25 м/с²-ээс ихгүй, удаашруулан зогсоох баригчийн зогсоох хурдатгал нь 9.8 м/с²-ээс ихгүй байна.

13.11. Баригчийн төхөөрөмжийн ажиллагааг ослоос хамгаалах хэрэгслээр хянана. Харин эсрэг ачааны баригч төхөөрөмжийг ослоос хамгаалах хэрэгслээр хянахгүй байж болно.

13.12. Удаашруулан зогсоох баригч нь үйлдвэрийн лацтай байна.

13.13. Баригч дээр түүнийг үйлдвэрлэсэн байгууллагын нэр, таних дугаар бүхий пайз байна.

13.14. Баригчийн төхөөрөмжийг цахилгаан, усан, хийн төхөөрөмжүүдээр ажиллуулахыг хориглоно.

14. ХУРД ХЯЗГААРЛАГЧ

14.1. Бүхээг доошоо явах үеийн хурд нь хэвийн хэмжээнээсээ 15%-аас багагүй ба дор зааснаас ихгүйгээр нэмэгдэх үед хурд хязгаарлагч нь баригчийг ажиллуулна. Үүнд:

- Огцом баригчтай лифтэнд 0.8 м/с.
- Удаашруулан зогсоох болон амортизатор бүхий баригчтай лифтэнд 1.5 м/с.
- 1.0 м/с-ээс дээш хэвийн хурдтай лифтийн хувьд дараах томъёогоор бодно. $1.25\gamma + 0.25/\gamma$ м/с: энд γ -бүхээгний хэвийн хурд м/с.

14.2. Эсрэг ачаа, тэнцүүлэгчийн хурд хязгаарлагчийг эсрэг ачааны доошлох хэвийн хурд нь 15 %-иас дээш болсон үед бүхээгний баригчийг зөвшөөрөгдөх хурдны дээд хязгаараас 10% давсан хэмжээнээс доош байх үед баригч ажиллаж байхаар тохируулсан байна.

14.3. Хурд хязгаарлагчийг үйлдвэрийн лабораторид туршсан байна.

14.4. Хурд хязгаарлагчийн татлаганы диаметр 0.006 метрээс, бат бэхийн нөөцийн итгэлцүүр нь 8-аас багагүй байна.

14.5. Хурд хязгаарлагчийн дамрын диаметр нь түүний татлаганы диаметрээс 30-дахин авсанаас их байна.

14.6. Баригч болон хурд хязгаарлагч нь найдвартай ажиллаж байгааг шалгах боломжтой хэрэгслээр тоноглогдсон байх ёстой.

14.7. Хурд хязгаарлагч нь зөвхөн ган татлага ба ажлын дамрын хооронд үүсэх үрэлтийн хүчний үйлчлэлээр баригчийг ажиллуулдаг хийцтэй бол бүхээгийг хэвийн хурдтай явах үед хурд хязгаарлагчийн ган татлага ба ажлын дамрын хооронд үүсэх үрэлтийн хүчний найдвартай эсэхийг шалгах боломжийг бүрдүүлсэн байвал зохино.

14.8. Хурд хязгаарлагч дээр түүний эргэлтийн чиглэлийг заасан тэмдэглэл байна.

14.9. Бүхээгний доош шилжих хурд түүний хязгаарлагчийн ажиллах хэмжээнд хүрэхээс өмнө таслагч ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана. Харин 1.0 м/с хүртэл хурдтай лифтэнд таслагч нь хурд хязгаарлагчийг ажиллах тэр үед нь таслаж болно.

14.10. Бүхээгний баригчийг сулласны дараа хурд хязгаарлагч хэвийн байдалдаа ороогүй үед лифтийг ажиллахгүй байхаар цахилгааны хамгаалалт хийгдсэн байна.

14.11. Хурд хязгаарлагчийг дараах нөхцөлд хонгилд тавьж болно. Үүнд:

- Туршилтын үед хурд хязгаарлагчийг алсын зайнаас ажиллуулж болдог байх.
- Хурд хязгаарлагч ажилласны дараа тэдгээр нь автоматаар хэвийн байдалд ордог байх.

14.12. Хурд хязгаарлагчийн ган татлага нь чангалагч ачаагаар доош татагдсан байна. Энэ чангалагч нь цахилгааны таслагчтай байна.

14.13. Хурд хязгаарлагч нь лац, ломбо ба дараах мэдээлэл бүхий пайзтай байна. Үүнд:

- Үйлдвэрийн нэр.
- Бүтээгдэхүүний дугаар.
- Хурд хязгаарлагчийн мэдрэх хурд.

15. ЗӨӨЛӨВЧ ТУЛГУУР

15.1. Лифтийн хонгилын ёроолд бүхээг ба эсрэг ачааны доор тэдний эрчийг бууруулах, зогсоох зориулалттай зөөлөвч тулгуурыг байрлуулна. Татлагыг өөртөө ороож татдаг хүрдтэй болон одон дугуйтай эргүүлэг /өргүүр/ бүхий лифтэнд бүхээгний дээшээ явахыг хязгаарлах нэмэлт зөөлөвч тулгуур тавина.

15.2. Зөөлөвч тулгуур нь тусгай бэхлэгдсэн хатуу суурин дээр байрлана.

15.3. 1.0 м/с-ээс бага хэвийн хурдтай лифтэнд пүрштэй тулгуурыг тавьж болно.

15.4. Буцаах пүрштэй шингэний төхөөрөмжит тулгуурыг 1.6 м/с хүртэл хурдтай лифтэнд тавьж болно.

15.5. Цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуурыг ямар ч хурдтай лифтэнд тавьж болно.

15.6. Бүх төрлийн зөөлөвч тулгуур үйлдвэрийн лабораторид туршигдсан байна.

15.7. Бүхээг болон эсрэг ачааны тулгуурын тооцоо дараах нөхцлийг хангана. Үүнд:

- Бүлүүрийн бүрэн явалтыг хязгаарласан шингэний төхөөрөмж бүхий тулгуураас бусад төрлийн тулгууртай лифтийн хэвийн хурдыг 15%-иар ихэсгэж.
- Бүлүүрийн бүрэн явалтыг хязгаарласан шингэний төхөөрөмж бүхий тулгууртай лифтийн тооцооны багасгасан хурдыг 15%-иар ихэсгэж.

Энэ үед лифтэнд байх ачааны массыг тооцоходоо түүний даацыг 25%-иар ихэсгэж бодно.

15.8. Пүрштэй тулгуурын бүрэн ачааллын үед түүний агших хэмжээг дараах томъёогоор бодно.

$$S=(1.15v)^2/g=0.1348v^2$$

s- тулгуурын агших хэмжээ, м;

v- лифтийн бүхээгний хэвийн хурд, м/с;

g- чөлөөт уналтын хурдатгал, м/с²;

Тулгуурын агших хэмжээ нь 0.065 метрээс багагүй байна.

15.9. Пүрштэй болон буцаах пүрш бүхий хий, шингэний төхөөрөмжит тулгууртай лифтний зөөлөвч тулгуур нь дараах шаардлагыг хангасан байна:

- Хэвийн ачаалалтай, 115%-ийн хурдтай шилжих бүхээгний тулгуурт тулах үеийн удаашруулах хурдатгал нь 9.81 м/с²-аас хэтрэхгүй байна.
- 25 м/с²-аас дээш хэмжээтэй удаашруулах хурдатгалын үйлчлэх хугацаа нь 0.04 секундээс ихгүй байна.

15.10. Цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуурын бүрэн ачааллын үед агших хэмжээг дараах томъёогоор бодно.

$$S=(1.15v)^2/2g=0.0674v^2$$

S- тулгуурын агших хэмжээ, м;

v- лифтний бүхээгний хэвийн хурд, м/с;

g- чөлөөт уналтын хурдатгал, м/с²;

15.11. Хэрэв лифт дээд доод давхартаа очих үед түүний удаашрилт нь 20.11-д заасны дагуу байдаг бол тулгуурын агшилтыг тооцоход хэвийн хурдны оронд бүхээг, эсрэг ачааны тулгуурт хүрэх үеийн хурдыг хэрэглэж болно.

Энэ үед тулгуурын агшилт нь дараах хэмжээнээс бага байна. Үүнд:

- Хэвийн хурд 4.0 м/с-ээс ихгүй үед тулгуурын бүрэн агших хэмжээний 50%-тай тэнцүү байх ба гэхдээ 0.42 метрээс багагүй байна.
- Хэвийн хурд 4.0 м/с-ээс их үед тулгуурын бүрэн агших хэмжээний 33%-тай тэнцэх боловч 0.54 метрээс багагүй байна.

15.12. Цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуур нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хэвийн ачаалалтай, 115%-ийн хурдтай шилжих бүхээгний тулгуурт тулах үеийн удаашруулах хурдатгал нь 9.81 м/с²-аас хэтрэхгүй байна.
- 25 м/с²-аас дээш хэмжээтэй удаашруулах хурдатгалын үйлчлэх хугацаа нь 0.04 секундээс ихгүй байна.

15.13. Тулгуураас ачааллыг авсны дараа тулгуур автоматаар анхны байдалдаа ирэх ба үүнийг ослоос хамгаалах хэрэгслээр хянана.

15.14. Пүрштэй тулгуураас бусад тулгуур нь техникийн өгөгдөхүүнийг заасан хүснэгтэн мэдээлэлтэй байна.

15.15. Бүхээг болон эсрэг ачааг зөөлрүүлэгчтэй баригчийн төхөөрөмжөөр тоноглож болно. Ийм нөхцөлд худагт хатуу тулгуурыг байрлуулж болно.

15.16. Шингэний тулгуур нь шингэний түвшинг тодорхойлох заагчтай байна. Шилэн заагч байхыг зөвшөөрөхгүй.

16. ТАТАХ, ЗҮҮХ ЭЛЕМЕНТ

16.1. Бүхээг, эсрэг ачаа тэнцүүлэгч нь ган татлагаар холбогдсон байна.

Мөн ган татлаганы оронд гинж болон ган татлаганаас багагүй бат бэхийн нөөцтэй, аюулгүйн нөхцлийг хангасан өөр татлага хэрэглэхийг зөвшөөрнө.

16.2. Лифтэнд хэрэглэх татлага нь улсын стандартын шаардлагын дагуу шалгаж туршсан үйлдвэрийн гэрчилгээтэй байх ёстой.

16.3. Бүхээг, эсрэг ачааны зэрэгцэн ажилладаг татлагууд нь ижил үзүүлэлт, хийц, хэмжээтэй байна.

16.4. Тэнцүүлэгч бүхий лифтний ган татлаганы тоо нь 2-оос доошгүй байна.

16.5. Полиспаст хэрэглэсэн үед түүний салаануудын тооноос үл хамааран нэг татлага гэж үзнэ.

16.6. Татлагын гологдлын нормыг 7 дугаар хавсралтад заасан ба энэ хавсралтад заагдаагүй материалаар хийгдсэн татлагын гологдлын норм нь тухайн лифтийн ашиглалтын зааварт тусгагдсан байна.

16.7. Лифтэнд залгаатай ган татлага хэрэглэхийг хориглоно.

16.8. Ган татлагын диаметр нь 8мм-ээс багагүй байна.

16.9. Ган татлаганы чиглэл өөрчлөх блок болон хүрд, дамрын диаметр нь ган татлаганы диаметртээс 40-өөс багагүй дахин их байна.

16.10. Ган татлагыг доорх томъёогоор тооцоолно.

$$P/S = K$$

К- Бат бэхийн нөөцийн итгэлцүүр. Энэ нь дараах хэмжээнээс багагүй байна. Үүнд:

- Гурав ба түүнээс олон ган татлагатай хүрд, дамар бүхий эргүүлэгт /өргүүр/ 12.
- Хоёр ган татлагатай хүрд, дамар бүхий эргүүлэгт /өргүүр/ 16.
- Хүрдтэй эргүүлэгт /өргүүр/ 12.

Р- Татлагын тасрах хүчний хэмжээ /Н/.

С- Ган татлагын салааны тооцоот таталтын хүч /Н/. Үүнийг бүхээг хамгийн доод давхарт байх үед тооцно.

16.11. Татлаганы төгсгөлийн бэхэлгээнүүдийн бат бэх нь татлаганы тасрах хүчийн 80%-иас багагүй байна.

16.12. Татлаганы төгсгөлийг шаантган бэхэлгээгээр буюу 2-оос доошгүй даруулга бүхий боолтоор бэхлэх ба дээрх бэхэлгээтэй ижил хэмжээний бат бэхтэй өөр бэхэлгээ хэрэглэхийг зөвшөөрнө.

16.13. Гинжин татлагын бат бэхийн итгэлцүүр 10 байх ба түүнийг 16.10-д үзүүлсэн томъёогоор бодно.

17. ТАТАХ ЭЛЕМЕНТҮҮДИЙН АЧААЛЛЫГ ТЭНЦҮҮЛЭГЧ

17.1. Лифт татлагуудын ачааллын зөрүүг автоматаар тэнцүүлэх тоноглолтой байна. Гинжин татлагатай үед тэр нь бүхээг, түүнийг тэнцүүлж буй ачааны аль алинд байна.

17.2. Автомат тэнцүүлэгчид шахалтанд ажилладаг пүрш хэрэглэж болно.

17.3. Татлаганы уртын ялгаа зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан буюу аль нэг татлага нь тасарсан үед ослоос хамгаалах цахилгаан хэрэгсэл ажиллаж лифтийг зогсоохоор хийнэ.

17.4. Тэнцүүлэгч татлага хэрэглэх үед дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Блок чангалах төхөөрөмжтэй байх.
- Блокны диаметр нь тэнцүүлэгч татлаганы диаметрээс 30-аас багагүй дахин их байна.
- Чангалагч нь ачааны хүндийн хүчээр ажиллах ба ослоос хамгаалах цахилгаан хэрэгслээр хамгаалагдсан байна.

17.5. 3.5 м/с-ээс их хэвийн хурдтай лифтэнд тэнцүүлэгчийн чангалагч нь түүний огцом хөдөлгөөнөөс хамгаалсан төхөөрөмжөөр тоноглогсон байна. Энэ хамгаалах төхөөрөмж нь ослоос хамгаалах хэрэгслээр хамгаалагдсан байна.

17.6. Татлаганы чиглэл өөрчлөх блок, одон дугуй нь дараах шаардлагыг хангасан хаалт хамгаалалттай байна. Үүнд:

- Үйлчлэгч, засварчид гэмтэх, бэртэхээс хамгаалагдсан байх.
- Татлага нь блок, одон дугуйнаас мултрахгүй хамгаалагдсан байх.
- Татлага, блок, одон дугуйны хооронд өөр зүйл хавчуулагдахаас хамгаалсан байх.
- Хаалт хамгаалалтыг салгахгүйгээр блок, одон дугуйнд үзлэг хийхэд саад болохгүй байх.

18. ЛИФТИЙН ЦАХИЛГААНЫ ХЭСЭГ

18.1. Цахилгаан төхөөрөмж, цахилгааны утасны үзүүлэлтүүд, тэдгээрийн хийц нь Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Цахилгаан байгууламжийн дүрэм”/БД 43-101-03/-ийн 5.5.3; 5.5.4; 5.5.5 дугаар заалтын шаардлагыг хангасан буюу лифтийн тэжээлийн гүйдэл, хүчдэлд тохирсон, лифтийн ашиглалт, хадгалалт, зөвөрлөлтөд зохицсон байна.

18.2. Тэжээлийн эх үүсвэрээс хүчдэлийг машины өрөөнд оруулахдаа лифт тус бүрт тоноглогдсон гар удирдлагатай оролтын төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

18.3. Машины өрөөнд 2 ба түүнээс илүү лифт байрласан байвал энэ өрөөнд 2-оос доошгүй тэжээлийн шугам оруулна.

18.4. Хэрэв машины өрөө байхгүй тохиолдолд оролтын төхөөрөмжийг цахилгааны удирдлагын шкафанд, хэрэв удирдлагын шкаф нь хонгилд байрладаг бол лифтэнд гацсан хүнийг гаргах үед лифтийг ажиллуулах удирдлагын дэргэд байрлуулах ба түүнд гадны хүн хүрэх боломжгүй байх ёстой

18.5. Цахилгаан төхөөрөмжүүдийг өөр өөр өрөөнүүдэд байрлуулсан тохиолдолд лифтийн цахилгаан тэжээлийг салгах, өөрөө буцдаггүй салгуур өрөө бүрт байх ёстой.

18.6. Оролтын төхөөрөмж нь дор дурьдсан шугамаас бусад цахилгааны шугамын хүчдэлийг салгаж тэжээлийн бүх фазыг таслана. Үүнд:

- Машины ба блокийн өрөө, бүхээг, хонгилын гэрэлтүүлгийн.
- Бүхээгийн агааржуулалтын системийн.
- Бүхээгээс үйлчлэгч ажилчдыг дуудах болон хоёр талын дуудлагын холбооны.
- Машины өрөө, худаг, бүхээгний дээр, доор байрлах хэрэглэгчийн залгуурын.
- Аваарийн дохиололын.
- Засварын дуудлагын.

Энэ нөхцөлд дээр заагдсан шугамын хүчдэлийг салгахад зориулж машины өрөөнд байрлуулсан тусгай салгуурууд байх ба машины өрөөгүй нөхцөлд тэдгээрийг цоожтой шүүгээнд байрлуулна.

18.7. Хэрвээ хүчний ба удирдлагын хэлхээг салгах нэмэгдэл салгуурууд суурилагдсан байвал бүхээгийн гэрэлтүүлэг ба салхивчийн цахилгаан хэлхээ, бүхээгээс үйлчлэх ажилчдыг дуудах ба бүхээгээс хоёр талын дуудлагын холбоог оролтын төхөөрөмжийн дотор талаас залгаж болно.

Энэ нөхцөлд оролтын төхөөрөмжийг алсын зайнаас салгах дамжуулгаар тоноглож болохгүй бөгөөд мөн автомат салгуурыг оролтын төхөөрөмж маягаар ашиглаж болохгүй.

18.8. Хэд хэдэн лифт нэгдсэн нэг машины өрөөтэй нөхцөлд тэдгээрийн бүхээгний унтраалга нь тус тусдаа байна.

18.9. Хонгилын гэрлийн унтраалга оролтын төхөөрөмжийн дэргэд байна.

18.10. Аль нэгэн зогсоолын талбай дээр хүчний ба удирдлагын хэлхээг залгах, салгах алсын удирдлагатай салгуурыг төхөөрөмжилж болох бөгөөд энэ үед бүхээгт хүмүүс байх үед цахилгааны хэлхээ тасрахгүй байх, гадны хүн энэ салгуурт хүрэхээргүй байх нөхцөл хангагдсан байх ёстой.

18.11. Хүчний цахилгаан хэлхээний хүчдэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Машины өрөөнд 660 В-оос ихгүй байх.
- Бүхээг, хонгил, зогсоолын талбай, машины өрөөгүй лифтний цахилгааны төхөөрөмжийг суурилуулсан талбайн 50ГЦ давтамжтай хувьсах гүйдэлд 415 В-оос ихгүй, 60 гц давтамжтай хувьсах гүйдэлд 440 В-оос ихгүй, тогтмол /шулуутгасан/ гүйдэлд 460 В-оос ихгүй байна.
- Удирдлагын хэлхээ, гэрэлтүүлэг, дохиолол ба цахилгаан багаж залгах хэлхээний хүчдэл нь 250 В-оос ихгүй байна.
- Зөөврийн гэрэлтүүлэгт 42В-оос ихгүй байх ба хүчдэлийг бууруулах автотрансформатор ашиглахыг хориглоно.

18.12. Удирдлага, гэрэлтүүлэг, дохиоллын хэлхээний тэжээлд шугамын фазын ба "0"-ийн утсыг ашиглаж болно.

18.13. Фазын хүчдэлд залгагдаж байгаа хэлхээ ослоос хамгаалах хэрэгсэлтэй бол энэ хэлхээн дэх цахилгаан соронзон аппаратууд /Контактор, реле, соронзон залгуур/-ын ороомгийн гаралт ба "0" шугамын хооронд ослоос хамгаалах хэрэгслийг холбож болохгүй.

18.14. Ослоос хамгаалах цахилгаан хэлхээг бууруулагч трансформатораас хувьсах гүйдлээр тэжээх үед трансформаторын хоёр дахь ороомгийн нэг гаргалгааг заавал газардуулна. Энэ хэлхээнд байгаа цахилгаан соронзон аппаратуудын ороомог ба трансформаторын газардуулагдсан гаралтын хооронд ослоос хамгаалах хэрэгслийг холбож болохгүй.

18.15. Ослоос хамгаалах цахилгаан хэлхээг шулуутгагчаар дамжуулан бууруулагч трансформатораас тэжээх үед шулуутгагчийн аль нэг туйлыг

газардуулна. Энэ үед удирдлагын хэлхээний цахилгаан соронзон ороомгийн гарц ба газардуулгын туйлын хооронд ослоос хамгаалах хэрэгслийг холбож болохгүй. бөгөөд бууруулах трансформаторын хоёр дахь ороомгийг газардуулахгүй.

18.16. Хамгаалалтын газардуулга ба “0” шугамд ямар нэг таслагч, салгагч тавихыг хориглоно.

18.17. Газардуулгын утсанд нь гал хамгаалагч, салгуур холбохыг хориглоно.

18.18. Оролтын төхөөрөмж, машины өрөө, худагт суурилуулсан салгуур болон цахилгаан хэлхээг салгах, залгах алсын ба гар удирдлагатай салгуурын гүйдэл дамжуулах хэсгүүдийн хүчдэл нь хувьсах гүйдлийнх бол 42 В-оос, тогтмол гүйдлийн бол 60 В-оос их үед санамсаргүй хүрэхээс хамгаалагдсан байвал зохино.

Дээрх салгуурууд дээр аль байрлалд залгагдах, салгагдах тухай тэмдэглэл байх шаардлагатай.

18.19. Ослоос хамгаалах хэрэгсэл бүхий цахилгаан хэлхээ их биелэх үед лифт зогсох ба эргээд “хэвийн ажиллагаа” горимд автоматаар ордоггүй байвал зохино.

19. ЦАХИЛГААН ДАМЖУУЛГА

19.1. Лифтийн цахилгаан дамжуулга дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- Тоормосны удирдлагын /цахилгаан, соронзон гэх мэт/ цахилгаан төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хэсэг их биелэх тохиолдолд уг дамжуулга залгагдахгүй байх ба бүхээг зогссон үед механик тоормос барихад саад болохгүй байх.
- 0.63м/с хэвийн хурдтай лифтийн бүхээг нь 0.4 м/с-ээс хэтрэхгүй багассан хурдаар явуулах боломжийг хангасан байх.

19.2. Цахилгаан хөдөлгүүрийг шугамаас шууд тэжээх үед хувьсах гүйдлийн цахилгаан дамжуулга нь дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- Цахилгаан хөдөлгүүрийг залгах мөчид буюу залгасны дараа механик тоормос салдаг байх.
- Цахилгаан хөдөлгүүрийг зогсоох үед механик тоормос барьж байх.
- Аль нэг нь төгсгөлийн унтраалга байж болох бие биенээс үл хамаарах хоёр цахилгаан соронзон салгах хэрэгслээр цахилгаан хөдөлгүүрийн үндсэн гүйдлийн хэлхээ тасардаг байх. Нэг цахилгаан соронзон салгах хэрэгслийн оронд контактын бус салгах хэрэгсэл ашиглаж болно.
- Лифт зогссоны дараа аль нэг цахилгаан соронзон салгах хэрэгслийн ерөнхий хэлхээний салгагч нь залгаатай байсан ч лифт цаашид хөдлөхгүй байх ба буцаж явах боломжтой байна.

19.3. Удирдлагатай хувьсгуураас цахилгаан хөдөлгүүрийг тэжээх үед хувьсах гүйдлийн цахилгаан дамжуулалт нь дараах шаардлагуудыг хангах ёстой:

- Тоормосны цахилгаан тэжээлийг салгах үйлдэл нь цахилгаан хөдөлгүүрийн тэжээлийг салгах цахилгаан хэрэгсэлтэй нэгдсэн буюу үүргийн хувьд бие биеэс хамаарах хоёроос доошгүй цахилгаан хэрэгслээр гүйцэтгэгдэхээр хийгдэнэ. Хөдөлгүүр бүхээгийг тогтоон барьж чадах хэмжээний цахилгаан гүйдэлтэй болсон нөхцөлд тоормос тавигдаж, хөдөлгүүр ажиллаж байхаар хийгдэнэ.
- Цахилгаан хөдөлгүүрийг зогсоох үед механик тоормос барьдаг байх.
- Цахилгаан хөдөлгүүрийн ерөнхий гүйдлийн хэлхээ өөр хоорондоо үл хамаарах хоёр цахилгаан соронзон салгах хэрэгслээр салдаг байх, аль нэг цахилгаан соронзон салгах хэрэгсэл салах үед хувьсгуураас цахилгаан хөдөлгүүрт дамжигдах цахилгаан гүйдэл нэгэн зэрэг бүрэн тасарч байх нөхцөлд бүх фазууд нь нэгэн зэрэг салахаар байх.
- Лифт зогссон үед цахилгаан хөдөлгүүрт дамжигдах цахилгаан гүйдэл тасрахгүй байх, эсвэл эхлэн явуулах, зогсоох ба хэвийн хурдаар

ажиллуулах үед хувьсгуур цахилгаан хөдөлгүүрт цахилгаан гүйдэл дамжихгүй байх гэмтэлтэй тохиолдолд цахилгаан хөдөлгүүр салдаг байх.

- Лифтийн цахилгаан хөдөлгүүрийн тэжээлийн хувьсгуурыг цахилгааны схемийн дагуу алсаас салгадаг байхаар тооцоолсон бол ийм сонголтыг заавал механик тоормос барьсны дараа гүйцэтгэхээр тохируулсан байх.
- Хэрэв цахилгааны систем нь бүхээгийг зогсоолын талбайн түвшинд цахилгаан хөдөлгүүрийн тоормослох моментоор барьж байхаар тооцоологдсон байвал цахилгаан хөдөлгүүр ба хувьсгуурын хооронд гал хамгаалагч, унтраалга буюу бусад таслах хэрэгсэл тавихыг хориглоно.

19.4. Удирдлагатай хувьсгуураас цахилгаан хөдөлгүүрийг тэжээх үед тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тоормосны цахилгаан тэжээлийг салгах үйлдэл нь цахилгаан хөдөлгүүрийн тэжээлийг салгах цахилгаан хэрэгсэлтэй нэгдсэн буюу үүргийн хувьд бие биеэс үл хамаарах хоёроос доошгүй цахилгаан хэрэгслэлээр гүйцэтгэгдэн хийгдэх.
- Хөдөлгүүр нь бүхээгийг тогтоон барьж чадах хэмжээний цахилгаан гүйдэлтэй болсон нөхцөлд тоормос тавигдаж, хөдөлгүүр ажиллаж байхаар хийгдэнэ.
- Бүхээгийн зогсолт болгонд механик тоормос барьж байх.
- Хэрэв бүхээгийг зогсоолын талбайд энэ дүрмийн 1.10.2-т заасан хязгаарт цахилгаан хөдөлгүүрийн тоормослох моментоор зогсох түвшинд барьж чадаж байвал механик тоормосоор барихгүй байж болно.
- Бүхээг нь зогсоолын талбайн түвшинд байрласан үед механик тоормос гэмтсэн тохиолдолд цахилгаан хөдөлгүүр ба хувьсгуур нь залгаатай байж бүхээгийг зогсоолын түвшинд барьж /цахилгаан тоормос/ байх.
- Механик тоормос гэмтэлтэй үед цахилгаан хөдөлгүүрийн хурд саарч цаашид зогсолт хийн бүхээгийг зогсоолын талбайд хөдөлгүүрийн тоормослох моментоор барина.
- Хэрэв лифтийн эргүүлэг /өргүүр/ нь үл хамаарах хоёр тоормостой буюу нэг тоормосны үл хамаарах хоёр системтэй бол цахилгаан тоормос шаардахгүй.
- Бүхээг хөдөлгөөнд орж байх үед аюулгүй ажиллагааны таслагч ажиллавал, хувьсгуур тасарч цахилгаан хөдөлгүүрийн цахилгаан тоормос гүйдэлгүй болж, механик тоормос барьж байх.
- Энэ үед хаалгануудын ослоос хамгаалах цахилгаан хэлхээ салах ёстой бөгөөд цаашид гэмтлийг арилгатал лифтийн үйл ажиллагаа зогсоно.
- Лифтийн цахилгаан хөдөлгүүрийн тэжээлийн хувьсгуурыг цахилгаан схемийн дагуу алсаас салгадаг байхаар тооцоолсон бол ийм сонголтыг заавал механик тоормос барьсны дараа гүйцэтгэгдэхээр тохируулсан байх.
- Цахилгаан хөдөлгүүрийн өдөөгчийн хэлхээ тасрах тохиолдолд хөдөлгүүрийн өөрийн хүчдэл автоматаар таслагдаж, механик тоормос барьдаг байх.
- Хэрэв цахилгаан дамжуулгын систем нь бүхээгийг зогсоолын талбайн түвшинд цахилгаан хөдөлгүүрийн тоормослох моментоор барьж байхаар тооцоологдсон байвал цахилгаан хөдөлгүүр ба хувьсгуурын хооронд гал хамгаалагч, унтраалга буюу бусад таслах хэрэгсэл тавихыг хориглоно.

20. УДИРДЛАГЫН СИСТЕМ

20.1. Лифт нь дотроос, гаднаас мөн хосолмол удирдлагатай байна.

20.2. Бүхээг дотор удирдлагын мэдээлэл өгөх аппарат нь хаалганы ойролцоо байрлана.

20.3. Автомат хаалгатай лифтний бүхээгт удирдлагын самбарт “хаалга” гэсэн буюу эсвэл тусгай тэмдэглэл бүхий товчлуур байх ба үүнийг дарснаар зогсож байгаа бүхээгний хувьд бүх өгөгдсөн тушаал гүйцэтгэгдэхгүй зөвхөн хаалга онгойх тушаал гүйцэтгэгдэнэ. Харин хөдөлгөөнд байгаа бүхээгний хувьд уг товчлуурыг дарснаар бүхээг шилжиж буй чиглэлийнхээ хамгийн ойр байгаа давхарт зогсоод хаалгыг онгойлгодог байхаар хийсэн байна.

20.4. Бүхээгний хаалга бүрэн хаагдахаас өмнө бүхээг хөдөлгөөнд орох ёсгүй. Харин өөр давхраас дуудлага өгсөн нөхцөлд бүхээгний хаалга бүрэн хаагдсанаас хойш 2 секундээс багагүй хугацааны дараа хөдөлнө.

20.5. Байнгын лифтчинтэй ажилладаг ачааны ба эмнэлгийн лифт нь зөвхөн дотроос удирдлагатай байна.

20.6. Лифт нь ганцаарчилсан ба нэгдсэн удирдлагатай байж болно. Орон сууцны ба олон нийтийн барилга байгууламжид нэг ижил хэвийн хурдтай, нэг ижил давхруудыг үйлчилдэг, бие биэндээ ойрхон байрласан лифтүүдэд нэгдсэн удирдлага тавьж болно.

20.7. Лифтийн удирдлагын систем нь дараахь шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Лифтийн цахилгаан хангамж тасрахад цахилгаан хөдөлгүүр зогсохын хамт удирдлагын хэлхээ тасардаг байх.

Цахилгаан хангамжийг сэргээсний дараа дараах нөхцөлд бүхээг хөдөлгөөнд орно. Үүнд:

- Лифтийн бүхээгийн зогссон шалтгааныг арилгасны дараа.
- Ганцаарчилсан удирдлагатай лифтэнд удирдлагын шинэ мэдээлэл өгсний дараа.
- Нэгдсэн удирдлагатай лифтэнд шинэ мэдээлэл өгсөн буюу түрүүчийн бүртгэгдсэн мэдээллийн дагуу.

Эдгээр бүх нөхцөлд бүхээгийн хөдөлгөөн зөвхөн хонгилын ба бүхээгийн хаалганууд хаалттай үед явагдана.

Бүхээгийн хаалгыг гараар нээж, хаадаг лифтэнд, бүхээгт хүнтэй лифтийг зөвхөн бүхээг дотроос удирдан явуулна. Энд дараах шаардлагуудыг тавигдана. Үүнд:

- Цуглуулгат удирдлагатай лифтийн бүхээг зогсоолын талбайгаас ажлын тоормослолтын зайнаас бага зайд байх үед бүхээгээс буюу зогсоолын талбайгаас зогсоох боломжгүй байх.
- Цахилгаан хөдөлгүүрийг салгах ба механик тоормос залгах цахилгаан хэрэгслийн контакт, тэрчлэн ослоос хамгаалах хэрэгсэл зөвхөн цахилгаан хэлхээг салгах байдлаар ажиллах ёстой.
- Лифтийн ажлын үед ба гаднаас ирж байгаа цахилгаан соронзон үйлчлэлийн нөлөө нь ослоос хамгаалах цахилгаан хэлхээний ажиллагаанд саад болохгүйгээр хийгдсэн байх.

20.8. Цуглуулгат удирдлагатай лифтээс бусад лифтийн удирдлагын систем нь урьд өгөгдсөн дуудлагыг биелүүлэх ажиллагаа дуусахаас өмнө /“зогс” мэдээлэл өгсөнөөс бусад/ шинэ дуудлагыг биелүүлж эхлэх боломжгүйгээр хийгдсэн байх.

20.9. 1.6 м/с ба түүнээс дээш хэвийн хурдтай лифтийн удирдлагын систем нь дээд, доод зогсоолын талбайн өмнө бүхээгийн ажлын удаашруулах хурдатгалыг орлох хэмжээний хурдны өөрчлөлттэй байна.

20.10. Богино шилжилт бүхий бүлүүртэй тулгуур хэрэглэсэн лифтийн удирдлагын системд бүхээг дээд, доод зогсоолын талбайд ойртох үед хурд хязгаарлах аваарийн төхөөрөмжийн тусламжаар хурдыг удаашруулдаг байна.

20.11. Хурд хязгаарлагч аваарийн төхөөрөмж дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Ажлын удаашруулах төхөөрөмжөөс хамааралгүй ажилладаг байх.
- Тулгуурт хүрэх үед бүхээгийн хөдөлгөөний хурд $V_b / 1.15$ хүртэл саарах. V_b – тулгуурын тооцоолсон хурд.
- Удаашруулах хурдатгал 9.81 м/с^2 –аас ихгүй байх.

20.12. Нэгдсэн удирдлагын системтэй хүн зөөврийн лифт дараах боломжийг хангасан байна. Үүнд:

- Бусад лифтийн хэвийн ажиллагааг зөрчихгүйгээр нэг буюу хэсэг лифтийг зогсоодог байх.
- Засварт зогссон лифтийн бүх хүчдэлийг цахилгаан төхөөрөмжөөс бүрэн салгадаг байх.
- Нэгдсэн удирдлагатай лифтийн цахилгаан хэлхээний элементүүдээс хүчдэлийг бүрэн салгаж болохгүй тохиолдолд хувьсах гүйдлийн 42В-оос дээш хүчдэлтэй, тогтмол гүйдлийн 60 В-оос дээш хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсгүүд нь хаалт хамгаалалттай, урьдчилан сэргийлэх санамж бичигтэй байна.

20.13. Лифт нэгдсэн удирдлагатай үед түүний зогсоолын талбайнуудад бүхээг аль давхраас хаашаа хөдөлж байгаа чиглэлийг заах дохиололтой байна.

20.14. Цахилгаан хөдөлгүүр нь хэт ачааллын үед түүнийг цахилгаанаар тэжээдэг бүх хэлхээг таслаад буцааж залгахдаа гараар гүйцэтгэгддэг системтэй байна.

20.15. Дараах нөхцөлд цахилгаан хөдөлгүүр салах, механик тоормос барих, бүхээг зогсох үйл ажиллагаа явагдаж байвал зохино. Үүнд:

- Цахилгаан хөдөлгүүр нь зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү халсан үед хөдөлгүүр зогсох буюу тоормос барих ажиллагаа нь лифтийн бүхээгийг шилжиж буй чиглэлийн дагуу хамгийн ойр орших зогсоолын талбайд очиж зогсоох эсвэл өгсөн тушаалыг биелүүлсний дараа гүйцэтгэгдэнэ. Хөдөлгүүр хэт ачаалалд орж зогссоны дараа өөрөө хөрөөд эргээд автоматаар ажилладаг хэлбэрээр хийхийг зөвшөөрнө.
- Хүчний ба удирдлагын хэлхээнд богино холболт үүсэх үед.
- Тогтмол гүйдлийн хөдөлгүүрийн сэргээлтгүй болсон үед.
- Энэ дүрмийн 20.15, 20.18, 21.18, 21.23, 21.25-д заасан болон 21.14-д заасан төгсгөлийн унтраалгаас бусад аюулгүй ажиллагааны таслагчууд ажилласан үед.

Хөдөлгүүр хэд хэдэн хэлхээнээс тэжээгддэг нөхцөлд хэлхээ бүрд энэ зүйлийн 20.14.1, 20.14.2-д тавигдсан шаардлага хамаарна. Тогтмол гүйдлийн генератороор тэжээгддэг хөдөлгүүр хэт ачааллаас хамгаалагдсан байна.

20.16. Хурд хязгаарлагч, тулгуур, баригч, татлага тэнцүүлэгчийн таслагч, ослоос хамгаалах цахилгаан хэрэгсэл, төгсгөлийн унтраалгууд ажилласны дараа эдгээр таслагчийн контактуудыг тусгай сэлгэн салгагчийн тусламжаар холбож бүхээгийг цахилгаан хөдөлгүүрээр хөдөлгөдөг системтэй байхыг зөвшөөрнө.

Удирдлагыг зөвхөн машины өрөөнөөс явуулах ба машины өрөөгүй үед тусгай шүүгээнээс явуулна. Харин шүүгээ ба машины өрөөний гадна байрлуулсан аппаратуудаас удирдах боломжгүй байлгах / “зогс” товчлуур хамаарахгүй/. Үүнд:

- Бүхээгний “дээш”, “доош” гэсэн тэмдэглэлтэй өөрөө буцдаг товчлуурыг дарж хөдөлгөөнд оруулна.
- Бүхээгийг хэвийн хурдаар явуулахыг зөвшөөрнө.

- Бүхээг хонгилын доод хэсэгт байх үед нь ажилласан баригч, тулгууруудын таслагч ба төгсгөлийн унтраалгын контактуудыг холбосон үед бүхээг зөвхөн дээшээ хөдөлж байх.
- Бүхээг хонгилын дээд хэсэгт байрлаж байх үед эсрэг ачаатай холбоотой баригчийг болон тулгууруудын таслагч, төгсгөлийн унтраалгын контактуудыг холбосон үед бүхээгийг зөвхөн доош хөдөлгөж байх.

20.17. Бүхээгийг “Машины өрөөнөөс удирдах” горимоор ажиллуулах үед дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Уг командыг өгөх удирдлагад гадны хүн хүрэх боломжгүй байх.
- Хонгилын хаалгыг тусгай түлхүүрээр онгойлгоход саадгүй байх.
- Хонгил, бүхээгний хаалга автоматаар онгойдоггүй байх.
- Хамгийн дээд, доод давхарт бүхээг автоматаар зогсдог байх.
- “Завгүй” гэсэн дохиололтой бол энэ дохиолол асаалттай байх.
- “Зогс” товчлуураас бусад машины өрөөний гадна байрласан бүх удирдлагын аппаратын ажиллагаа салгагдсан байх. Энэ үед зогсоолын талбайд байрлуулсан “Зогс” товчлуурын үйл ажиллагааг хязгаарлана.
- “Автомат цоожны хөдөлгөөнт чөлөөлүүр” /отводка/ лифтний хаалганы автомат цоожийг онгойлгохгүйгээр байх.
- Машины өрөөнөөс удирдах үед бүхээгийг дээш, доош явуулах товчлуур ба “Зогс” товчлуурыг ашиглана.

Машины өрөөнөөс удирдах үед 20.14-д зааснаас бусад тохиолдолд ослоос хамгаалах цахилгаан хэрэгслүүд ажиллагаатай байна.

Машины өрөөнөөс удирдах товчлуур нь өөрөө буцахаар хийсэн байна. Товчлуурын хажууд бүхээгийг хааш нь шилжүүлэх тухай тэмдэглэл хийгдсэн байна. Энэ товчлуурын ойролцоо бүхээгний хөдөлгөөнийг зогсоох товчлуур байна. Энэ нь өөрөө буцдаггүй, улаан өнгөтэй “Зогс” гэсэн тэмдэглэлтэй байна.

20.18. Машины өрөөнөөс удирдах удирдлагад дараах гэрлэн мэдээллийг өгдөг байна. Үүнд:

- Бүхээгний хөдөлгөөний чиглэл.
- Бүхээг хонгилын хаалганы харалдаа ирсэн тухай.
- Бүхээг аль давхарт ирсэн мөн эргүүлэг /өргүүр/-ийн ажиллагааг шалгах байрлалд ирсэн эсэх.

Бүхээгийг зогсоосны дараа дахин явуулахдаа шинээр тушаал өгнө.

20.19. Лифтийн бүхээгийг “үзлэг” /ревизия/ горимоор хөдөлгөөнд оруулж болох бөгөөд энэ үед дор дурдсан нэмэлт товчлуур тавихаар тооцсон байна. Үүнд:

- Бүхээгийн орой дээр нэмэлт товчлуур байрлуулна. Удирдлагыг зөвхөн бүхээгийн орой дээрээс нэмэлт товчлуурыг “үзлэг” горимын товчлууртай зэрэг дарж явуулна.
- Бүхээгийн хурд 0.63 м/с-ээс илүүгүй байна.
- Энэ горимд шилжүүлэхдээ машины өрөөнөөс гүйцэтгэнэ.
- Хаалганы хаалттай болон түгжээтэй байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгслийг алгасан гараар удирдах таслагчаар холбосон байна.

20.20. Бүхээгний дээвэр дээр орох хонгилын хаалганаас 0.7 м-ээс холгүй зайд лифтийг зогсоох товчлуур байрлах ба түүний хажууд “Зогс” гэсэн тэмдэглэл байна.

20.21. Бүхээгний орой дээрээс хөдөлгөөнийг удирдахад дараах нөхцөл хангагдсан байна. Үүнд:

- Удирдлагын аппаратны товчлуур нь өөрөө буцдаг байх.
- Машины өрөөнөөс удирдах үед 20.18-д зааснаас бусад тохиолдолд ослоос хамгаалах хэрэгсэл ажиллагаатай байна.
- Машины өрөөний, давхрын, бүхээгний удирдлагын ажиллагаа тасарсан байна.

- Автомат цоожны хөдөлгөөнт чөлөөлүүр” /отводка/ лифтийн автомат цоожийг онгойлгохгүй байх.
- Хонгил, бүхээгний хаалга автоматаар онгойх боломжгүй байх.
- ”Завгүй” гэсэн дохиололтой бол энэ дохиолол асаалттай байх.

“Үзлэг” горимоос “Хэвийн ажиллагаа” горимд шилжихдээ бүхээг дээрх удирдлагыг салгаад, хонгилын хаалгыг хаасны дараа машины өрөөнөөс гүйцэтгэнэ.

20.22. Удирдлагын системд бүхээг дээд, доод давхрын зогсоолд автоматаар зогсох төхөөрөмжтэй байх ба дээд байрлалд байх үед бүхээгний оройгоос хонгилын хучилт хүртэл зай нь 1.8 м-ээс багагүй байна.

20.23. Бүхээг нь даац хязгаарлагчтай байх ба тэр нь бүхээгний ачаалал даацаас 10% буюу 75 кг-с багагүй хэмжээгээр ихэссэн үед бүхээгийг зогсоох ёстой. Энэ үед лифт хэт ачаалагдсан гэсэн гэрлэн буюу дуут мэдээлэл өгөх ба хаалга хаагдахгүй байх ёстой.

20.24. Машины өрөө, худаг, бүхээг, бүхээгний орой, лифтийн доод давхар, блокийн өрөө зэрэг хэсгүүд нь хоорондоо харилцах утсан холбоотой байна

20.25. Үрэлтийн хүрд буюу дамар бүхий эргүүлэгтэй /өргүүр/ лифтийн удирдлага нь дараах тохиолдолд хөдөлгүүрийг салгадаг байна. Үүнд:

- Бүхээгт явах тушаал өгсний дараа бүхээг хөдөлгөөнд орохгүй байвал.
- Бүхээг буюу эсрэг ачаа хөдөлж байгаад татлага хөтлөх элементтэй гулсалт үүсэн 45 секундээс удаан зогсоход. Энэ үед “Хэвийн ажиллагаа”-ны горимд автоматаар буцдаггүй байх.
- Лифтийн засвар, үйлчилгээ гүйцэтгэгчид зориулж лифтийн аль нэг давхарт ажиллагааны горимыг өөрчлөх гар удирдлага байрлуулахыг зөвшөөрнө. Гэхдээ энэ нь гадны хүн хүрэх боломжгүй байх.

20.26. Хэвийн ажиллагааны явцад бүхээгний хаалга тохиолдлоор онгойх үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээ тасардаг байна. Энэ үед “Хэвийн ажиллагаа”-ны горимд автоматаар буцдаггүй байх.

21. ОСЛООС ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ

21.1. Ослоос хамгаалах хэрэгсэл нь ажиллахдаа үндсэн хөдөлгүүрийн ажиллагааг зогсоож хөдөлгүүрийн гол тэжээлийн шугамын таслагчаас бусад аюулгүйн хэлхээнд холбогдоно.

21.2. Ослоос хамгаалах хэрэгслийн бүтцэд. Үүнд:

- Үндсэн хөдөлгүүр, тоормосны контакторын тэжээлийг салгадаг, энэ дүрмийн 21.8-д заасан шаардлагыг хангах ослоос хамгаалах нэг буюу хэд, хэдэн контакт.
- Дараах хэсгээс бүрдсэн ослоос хамгаалах цахилгаан хэлхээ.
- Үндсэн хөдөлгүүр, тоормосны контакторын тэжээлийг шууд салгадаггүй, энэ дүрмийн 21.8-д заасан шаардлагыг хангах ослоос хамгаалах нэг буюу хэд, хэдэн контакт.
- Энэ дүрмийн 21.8-д заасан шаардлагад тусгагдаагүй ослоос хамгаалах бусад контакт.

21.3. Ослоос хамгаалах хэрэгслээс гарч байгаа дохиолол нь энэ хэлхээнд байгаа бусад цахилгаан тоноглолын дохиоллын нөлөөнд өөрчлөгддөггүй байх.

21.4. Дохиоллыг бүртгэх, түдгэлзүүлэх, оч унтраах цахилгаан хэлхээнд ямар нэг доголдол гарсан байхад ослоос хамгаалах хэрэгсэл ажиллаж ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслахад саад болохгүй байх.

21.5. Аюулгүйн таслагчийн хүчдэл тусгаарлагч нь дараах хэмжээтэй байна. Үүнд:

- 250В-их биений хамгаалах зэрэглэл IP4X-ээс багагүй.
- 500В-их биений хамгаалах зэрэглэл IP4X-ээс бага.

21.6. Ослоос хамгаалах хэрэгсэл нь гальваник контактыг ашигласан ажлын тоноглолтой хавсран ажиллахыг хориглоно.

21.7. Ослоос хамгаалах хэрэгслээс дохиолол өгөхдөө цахилгаан хэлхээг контактаар салгадаг аппарат хэрэглэх боловч соронзон удирдлагатай /герконон/ контакт хэрэглэхийг үл зөвшөөрнө.

21.8. Ослоос хамгаалах хэрэгсэл ажиллахдаа хэлхээг албадан салгадаг байх. Энэ үед контакт хайлаад гагнагдсан байсан ч түүнийг салгах боломжтой байх.

21.9. Ослоос хамгаалах цахилгаан хэлхээнд мэдээлэл цуглуулах төхөөрөмж залгахыг зөвшөөрнө. Энэ нь дүрмийн 21.2-д заасан шаардлагыг хангасан байна. Харин 20.18, 21.17, 21.19, 21.24, 21.26-д зааснаас бусад цахилгаан техникийн төхөөрөмжийг ослоос хамгаалах цахилгаан хэлхээнд зэрэгцээ холбох буюу шонгууд дээр нь залгаж үзэхийг хориглоно.

21.10. Лифтийг "Хэвийн ажиллагаа" горимд тавьсны дараа лифтний цахилгаан хэлхээнд холбосон бүх хэмжих, оношлох гэх мэт гадны тоноглолыг салгасны дараа лифт хөдөлж эхэлж байхаар хийгдсэн байна.

21.11. Оч унтраагч буюу контакт сайжруулах элементийг зөвхөн ослоос хамгаалах хэрэгсэлтэй зэрэгцээ холбохыг зөвшөөрөх ба энэ нь 21.2-д заасан шаардлагыг хангаж байх ёстой.

21.12. Ослоос хамгаалах хэрэгсэлд дараах нөхцөл байдлыг хянана. Үүнд:

- Бүхээг хамгийн дээд, доод давхраас цааш хэтрэн шилжихээс хамгаалах /төгсгөлийн унтраалга/
- Хонгилын хаалганы хаалттай байдал.
- Хаалганы ремений чангалалт.
- Хонгилын хаалганы автомат түгжээ цоожлогдсон эсэх.
- Түгжээгээр тоноглогдоогүй хонгилын хаалганы хаагдсан байдал.
- Хонгилд байдаг аварийн, хяналтын болон үйлчилгээний зориулалтын хаалганы хаалттай байдал.
- Бүхээгний хаалганы хаалттай байдал.
- Бүхээгний аварийн хаалганы буюу нээлхийн түгжээ цоожтой байгаа эсэх.
- Бүхээгний хурд хязгаарлагчийн ажиллагаа.
- Бүхээгний хурд хязгаарлагч анхны байрлалдаа ирж байгаа эсэх.
- Лифтийг зогсоох салгуурын ажиллагаа.
- Баригчийн ажиллагаа.
- Үндсэн татлага сунах, тасрах.
- Хурд хязгаарлагчийн татлага сунах, тасрах.
- Тэнцүүлэгч татлагуудын чангалалт.
- Тэнцүүлэгч татлагуудын чангалагчийн огцом хөдөлгөөний хязгаарлагчийн ажиллагаа.
- Бүхээг шилжүүлэх гар удирдлагын бариулын байрлал.
- Зөөлөвч тулгуур анхны байрлалдаа ирсэн эсэх.
- Хонгилоос удирдах хэлхээг салгасан эсэх.
- Блокын өрөөнөөс удирдах хэлхээг салгасан эсэх.
- Үйлчилгээний талбайн байрлал.
- Байрлал түгжих тоноглолын байдал.

21.13. Төгсгөлийн унтраалга дараах зайд ажиллана. Үүнд:

- Бүхээг хамгийн доод давхраас зөөлөвч тулгуурт шүргэх хүртэл.
- Бүхээг хамгийн дээд давхраас түүний эсрэг ачаа доод тулгууртаа шүргэх хүртэл.
- Тэнцүүлэгч бүхий лифтийн бүхээг хамгийн дээд давхраас дээш 0.2м зайд шилжих хүртэл. Бүхээг дээрээ зөөлөвч тулгууртай нөхцөлд уг зөөлөвч тулгуур холбогдох тулгуурт шүргэх хүртэл зайд үйлчилнэ.

Бүхээг /эсрэг ачаа/ зөөлөвч тулгуурт шахан зогссон үед төгсгөлийн унтраалга салсан байх ёстой. Төгсгөлийн унтраалга хэлхээг тасалсны дараа лифт автоматаар хэвийн ажиллагаанд орох ёсгүй.

21.14. Төгсгөлийн унтраалга 21.8-д заасны дагуу хөдөлгүүрийн болон тоормосны хэлхээг салгах ёстой. Харин 21.16-д заасан нөхцөлд бол төгсгөлийн унтраалгыг ослоос хамгаалах цахилгаан хэлхээнд холбохыг зөвшөөрнө. Үрэлтийн дамар буюу хүрдтэй лифтэнд хөдөлгүүрийн тэжээлийг салгахдаа хөдөлгүүрийн хэлхээнд холбогдсон хоёр контакттай катушкаар гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Тохируулгат хөдөлгүүртэй лифтийн төгсгөлийн унтраалгын зогсоох хугацаа нь тухайн системийн зогсоож болох хамгийн бага хугацаатай ижил байна.

21.15. Үрэлтийн дамар буюу хүрдтэй лифтний удирдлагын хэлхээнд төгсгөлийн унтраалгыг тоноглохдоо хөдөлгүүрийн тэжээлийн хэлхээнд бие биеээсээ үл хамаарах цуваа холбогдсон хоёр цахилгаан соронзон аппарат байрлуулах ба тэдгээрийн нэг нь контактын бус аппарат байхыг зөвшөөрнө.

Хөдөлгүүр зогсоход аль нэг аппарат салаагүй байсан ч лифт чиглэлээ өөрчилж шилжихээс нааш дахин залгагдахгүй байх ёстой.

21.16. Хүрд буюу одон араагаар хөтлөгддөг лифтийн аюулгүйн хэлхээнд төгсгөлийн унтраалга холбож болно. Энэ нөхцөлд чиглэл бүрд бие биеээсээ үл хамаарах 2-оос доошгүй төгсгөлийн унтраалга тавина.

Төгсгөлийн унтраалга нь хөдөлгүүрийн үндсэн гүйдлийг давхар салгах нөхцлийг хангах цахилгаан соронзон аппарат тус бүрт үйлчилнэ. Хөдөлгүүр зогсоход аль нэг аппарат салаагүй байсан ч лифт чиглэлээ өөрчилж шилжихээс нааш дахин залгагдахгүй байх ёстой.

21.17. Хонгилын хаалганы хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь 21.8-д заасан аюулгүйн хэлхээг салгах ба хаалганы аль нэг хавтас хаагдаагүй нөхцөлд бүхээг хөдөлгөөнд орохгүй байх ёстой.

21.18. Бүхээгийн хөдлөх нөхцлийг хангахын тулд автомат түгжээг хянах ослоос хамгаалах цахилгаан хэлхээ нь бүхээг давхраас хааш хаашаа 0.2м-ээс дотогш зайд байхад залгагдахыг зөвшөөрнө.

21.19. Хаалганы ремений чангалалтыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь ремень сулрах үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.20. Хонгилын хаалганы автомат түгжээг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь хаалга нээлттэй үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.21. Хонгилын түгжээгүй хаалганы хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь хаалганы аль нэг самбар нь нээлттэй үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.22. Хонгилд байдаг аваарийн, хяналтын болон үйлчилгээ хийх зориулалтын хаалганы хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь тэдгээрийн хаалга нээлттэй үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.23. Бүхээгний хаалганы хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь түүнийг нээлттэй байх үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.24. Бүхээгний аваарийн хаалга болон нээлхийн хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь тэдгээрийн хаалга нээлттэй үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана. Эргээд хэвийн ажлын горимд автоматаар шилжиж болохгүй.

“Гал унтраагчдыг зөөх” горимд нээлхийн хаалттай байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгслийг алгасан холбохыг зөвшөөрнө.

21.25. Бүхээгний хурд хязгаарлагчийн ажиллагааг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь бүхээгний шилжих хурд түүнийг хязгаарлах ёстой хэмжээнд хүрэхээс өмнө ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана. Харин 1 м/с хүртэл хурдтай лифтэнд бүхээгний хурд түүнийг хязгаарлах ёстой хэмжээнд хүрсэн үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслахыг зөвшөөрнө.

21.26. Бүхээгний хурд хязгаарлагч анхны байдалдаа буцах ажиллагааг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь бүхээгний хурд хязгаарлагч анхны байдалдаа орох хүртэл ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана. Дээрх тоноглол нь лифтийг машины өрөөнөөс ажиллуулж бүхээг, эсрэг ачааг баригчаас суллах үед алгасан залгагддагаар хийгдсэн байна.

21.27. Бүхээгний орой дээрх, машины өрөөний болон лифтийг зогсоох салгуур нь эргээд зөвхөн гараар залгагддаг байна. Дээрх салгуур ажилласнаар цуглуулах удирдлагатай лифтний дуудахаас бусад бүх тушаалыг хүчингүй болгоно. Лифт зогссоны дараа уг тоноглолыг залгаад дахин тушаал өгсний дараа лифт хөдөлгөөнд орно.

21.28. Бүхээгний баригчийн ажиллагааг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь баригч барьсан үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.29. Татлага сунах буюу тасрахыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь татлага сунах буюу тасрах үед цахилгаан хэлхээг таслана.

21.30. Хурд хязгаарлагчийн татлага сунах буюу тасрахыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь татлага тогтоосон хэмжээнээс илүү сунах буюу тасрах үед цахилгаан хэлхээг таслана.

21.31. Тэнцүүлэгч татлаганы чангалагчийн огцом хөдөлгөөнийг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь огцом хөдөлгөөнийг хязгаарлах төхөөрөмжийн ажиллах үед цахилгаан хэлхээг таслана.

21.32. Бүхээгийг гараар шилжүүлэх гар бариулын байрлалыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь бариул эргүүлэгт /өргүүр/ угсраатай үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.33. Шахуургат зөөлөвч тулгуур анхны байдалд ирсэн байдлыг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь зөөлөвч тулгуур анхны байдалдаа ирэхээс 0.05м-ээс их зайд байгаа үед ослоос хамгаалах цахилгаан хэлхээг таслана.

21.34. Худагт байрлах ослоос хамгаалах хэрэгсэл нь цахилгаан хэлхээг гараар таслах ба өөрөө буцдаггүй байна.

21.35. Блокийн өрөөнд байрлах ослоос хамгаалах хэрэгсэл нь цахилгаан хэлхээг гараар таслах ба өөрөө буцдаггүй байна.

21.36. Машины өрөөгүй лифтийн засвар үйлчилгээ хийх зориулалтын тусгай тавцанг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь уг тавцан ажлын бус байдлаас гаргах үед цахилгаан хэлхээг таслана.

21.37. Байрлал түгжих төхөөрөмжийг хянах ослоос хамгаалах хэрэгсэл нь уг төхөөрөмж ажиллах үед цахилгаан хэлхээг таслана.

21.38. Электрон эд анги бүхий ослоос хамгаалах цахилгаан хэлхээ нь үйлдвэрийн лабораторид туршигдсан байна.

22. ЦАХИЛГААНЫ УТАС

22.1. Нэг лифтний хүчний, удирдлагын, гэрэлтүүлгийн, дохиоллын хэлхээний хөндийрүүлэгчтэй утсуудыг тэдний хүчдэл нь 460В-оос ихгүй буюу бүх утасны хөндийрүүлэгч нь хамгийн их хүчдэлд тооцоологдож хийгдсэн байвал тэдгээрийг нэг багцаар буюу нэг дан хоолойд сүвлэн угсарч болно.

22.2. Цахилгаан машин ба аппаратад холбох төгсгөвч нь тухайн утас, кабелийн хэлбэр, хөндлөн огтлолд тохирсон байна. Хэрэв үндсэн салгуурыг салгасны дараа зарим төгсгөвч дээр цахилгааны хүчдэл байдаг бол тэдгээрийг бусад хүчдэлгүй утаснаас тусгаарласан байхаас гадна хүчдэл нь 50В-оос их бол түүний дээр тусгай тэмдэглэл хийсэн байна.

22.3. Лифтийн цахилгаан тоноглол нь үйлчилгээ, тохируулга хийхэд зориулагдсан, стандартын шаардлагыг хангасан, цахилгааны схемийн дагуу хийгдсэн таних тэмдэг, тэмдэглэлтэй байна. Гал хамгаалагчийн төрөл, үзүүлэлтийг

түүний дээр болон гэрнийх нь гадна талд бичсэн байна. Утасны тэмдэглэгээнд түүний өнгийг ашиглахыг зөвшөөрнө.

22.4. Утаснуудын бүрээс нь холбогдож байгаа төгсөвч, тоноглолын их биед бүрэн орж залгагдах, эсвэл тусгай нягтруулагчийн тусламжтайгаар холбогдоно.

22.5. Лифтийн битүү хэсгийн дотуур явж буй утас нь түүний ажиллагааны явцад гэмтэж болзошгүй нөхцөлд түүнд тусгай хамгаалалт хийж өгнө.

22.6. Ослоос хамгаалах цахилгаан хэлхээг ашиглалтын явцад түүнд тусгай багаж, аппарат залгах зориулалтаар хийсэн бол түүнийг буруу залгах боломжгүй байдлаар хийнэ.

23. ГЭРЭЛТҮҮЛЭГ БА ТЭЖЭЭЛИЙН ЗАЛГУУР

23.1. Бүхээг, хонгил, хонгилын худаг, машины ба блокийн өрөө, түүнд орох гарц, зогсоолын талбайнууд нь байнгын цахилгаан гэрэлтүүлэгтэй байх ба унтраалга нь автомат буюу гар ажиллагаатай байж болно.

23.2. Гадна байгаа гэрэлтүүлгээр хонгилын дотор талыг бүрэн гэрэлтүүлэх бололцоотой шилэн болон торон хашлагатай хонгилд гэрэлтүүлэг тавих шаардлагагүй. Бүхээг болон бусад төхөөрөмжүүдийн гэрэлтүүлэг, гар багаж залгах залгуурыг барилгын цахилгаан сүлжээнээс тэжээж болно.

23.3. Бүхээгний гар унтраалга, түүний орой дээрх залгуурыг шаардлагатай гэж үзвэл машины өрөөнд байрлуулж болно. Нэг машины өрөөтэй хэд хэдэн лифтний бүхээгний гар унтраалга лифт бүрийн ойролцоо байрласан байна.

23.4. Гэрэлтүүлэг нь дараах хэмжээтэй байна. Үүнд:

- Машины өрөө нь түүний шалны түвшинд 200Лк-аас багагүй.
- Блокийн өрөөний блок дээр 100Лк-аас багагүй.
- Засвар, үйлчилгээ хийх зориулалтын талбайд 200Лк-аас багагүй.
- Удирдлагын төхөөрөмжид 100Лк-аас багагүй.
- Машины өрөөгүй лифтэнд түүнийг орлох шүүгээний орчимд 200Лк-аас багагүй.
- Бүхээгт түүний шалны түвшинд 50Лк-аас багагүй.
- Давхрын талбайнуудад түүний шалны түвшинд 50Лк-аас багагүй.
- Хонгилд түүний хаалга хаалттай байх нөхцөлд 50Лк /100ватт/ -аас багагүй.
- Захын гэрлүүд нь хонгилын дээд доод цэгээс 0.5м-ээс ихгүй зайд байрлана.
- Бүхээгийн орой дээр 200вт-аас доошгүй чадалтай гэрэлтүүлэг хийнэ.

23.5. Бүхээгний гэрэлтүүлэг нь 2-оос доошгүй, зэрэгцээ холболт бүхий чийдэнтэй байна.

23.6. Цахилгаан тасарсан үед бүхээгт 1Вт-ын чийдэнг 1 цагийн хугацаанд асааж чадах зай хураагуураар тэжээгддэг гэрэл автоматаар асдаг байвал зохино.

23.7. Бүхээгийг ачаалах үед түүний чийдэн гэмтэхээргүй хамгаалагдсан байна.

23.8. Хөдөлгөөнт шалтай лифтийн бүхээгийн гэрэл нь хонгилын хаалга нээгдэхэд асаж, бүхээгээс бүх зорчигчид гарч хонгилын хаалга хаагдмагц 5 секундын дараа автоматаар унтарч байхаар хийхийг зөвшөөрнө.

23.9. Машины ба блокийн өрөө, худаг, бүхээгийн орой дээр ба доор 42 В-оос дээшгүй хүчдэлтэй зөөврийн гэрэл залгах зориулалттай 1-ээс доошгүй залгуур байрлуулна.

23.10. Цахилгаан багаж залгах залгуурын хүчдэл 250В-оос ихгүй байна.

24. БҮХЭЭГИЙН ДААЦ, БАГТААМЖ

24.1. Лифтийн бүхээгийн шалны ашигтай талбайг даацаас нь хамааруулж 2 дугаар хүснэгтэд нийцүүлж сонгон авна.

2 дугаар хүснэгт

Лифтийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, мI-аас илүүгүй	Лифтийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, мI-аас илүүгүй	Лифтийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, мI-аас илүүгүй
100	0.37	675	1.75	1200	2.80
180	0.58	750	1.9	1250	2.90
225	0.7	800	2.00	1275	2.95
300	0.9	825	2.05	1350	3.1
375	1.10	900	2.20	1425	3.25
400	1.17	975	2.35	1500	3.40
450	1.3	1000	2.40	1600	3.56
525	1.45	1050	2.50	2000	4.20
600	1.6	1125	2.65	2500	5.0
630	1.66				

Лифтийн даац нь 2500 кг –аас дээш бол нэмэгдсэн 100 кг бүрт бүхээгийн ашигтай талбайг 0.16 мI-аар нэмэгдүүлнэ.

Даацын завсрын хэмжээст түүнд ноогдох талбайг даацаас хамааруулсан шугаман харьцаагаар тодорхойлно.

24.2. Лифтийн бүхээгийн багтаамж, даацыг тогтооход нэг хүний жин 75кг байхаар бодож тооцно.

24.3. Лифтийн бүхээгийн шалны ашигтай талбайг энэ дүрмийн 24.1-д заасан хэмжээнээс дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд ихэсгэхийг зөвшөөрнө. Үүнд:

- Бүхээгийн ачаа нь даацаас 10% буюу түүнээс дээш байгаа нөхцөлд бүхээг доторхи удирдах товчлуураар лифтийг явуулах боломжгүй байх.
- Лифтийн даац 25 хүртэл хувиар илүү ачаалагдсан үед түүнийг машины өрөөнөөс удирдаж ажиллуулж болдог байх.
- Бүхээг нь хэт ачааллыг мэдрэх дохиоллын төхөөрөмжтэй байх.
- Шингэний дамжуулгат лифтээс бусад бүх лифтэд энэхүү нэмэгдүүлсэн ачааны жин нь лифтийн ачаа даацыг 2 дахин нэмэгдүүлснээс багагүй байх.

Лифтийн хийц хэсгийн бат бэх нь дор дурдсан тохиолдолд үүсэх нэмэлт ачааллыг даахаар тооцоологдсон байх. Үүнд:

- Хурдны дээд хязгаараар тохируулагдсан хурд хязгаарлагч ажиллахад бүхээг баригчийн үйлчлэлээр чиглүүлэгчийг зуурч зогсох үед, түүнчлэн бүхээг хэвийн хурдаас 15%-иар хэтэрсэн хурдаар тулгуур дээр суух үед үүсэх ачааллыг даахаар тооцоологдсон байх.
- Лифтийн хийц хэсгийн бат бэхийн тооцоо нь бүхээг баригчийн үйлчлэлээр чиглүүлэгчид зуурч зогсох, тулгуур дээр суух үед бүхээгийн шалны талбайд жигд байрлуулсан ачаа нь бүхээг дотор

хөдөлж шилжих боломжгүй, түүнчлэн баригчийн үйлчлэлээр бүхээг зогсох үед ган татлага тасрахгүй байхаар хийгдсэн байх.

24.4. Лифтийн бүхээгийн шалны ашигтай талбай нь энэ дүрмийн 24.1-д заасан хэмжээнд хүрээгүй, бүхээгтээ тусгай нэмэлт хаалгатай лифтэнд энэ дүрмийн 24.3-д заагдсан шаардлагууд хамаарахгүй.

24.5. Лифтийн хийц хэсгийн тооцоог хийхдээ үйлдвэрийн дотоод зөөврийн /авто ачигч, цахилгаан кар г.м/ хэрэгслийг ачаатай нь зөөвөрлөдөг зориулалттай лифтийн бүхээгт тийм тээврийн хэрэгсэл орох /гарах/ үед үүсэх динамик ачааллыг оролцуулан тооцно.

25. ЛИФТИЙГ ҮЙЛДВЭРЛЭХ, АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

25.1. Лифтийн загвар хийцэд туршилт хийгээд тэнцсэн нөхцөлд энэ дүрмийн шаардлагыг хангасан тухай туршилт явуулах эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэгч болон нийлүүлэгч байгууллагаар лифтийг үйлдвэрлэх хэрэглэх зөвшөөрлийг Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас олгоно.

25.2. Энэ дүрмийн шаардлагыг хангасан баталгаа бүхий эд хэсгүүдээс иж бүрдэл болгон нийлүүлдэг үйлдвэрт энэхүү зөвшөөрлийг олгож болно.

25.3. Зөвшөөрлийг нэг лифтэнд эсвэл ижил төрлийн олон лифтэнд олгож болно.

25.4. Ижил материалаар нэг зураг, технологиор үйлдвэрлэгдсэн лифтүүдэд нэг зөвшөөрөл олгож болно.

25.5. Лифтийг хүлээн авах туршилт хийхийн тулд өргөдөл гаргагч нь дараах материалыг бүрдүүлж мэргэжлийн хяналтын байгууллагад өгнө. Үүнд:

- Лифт үйлдвэрлэх техникийн даалгавар.
- Лифтийн загварыг турших программ, аргачлал.
- Туршилтын загварыг бэлтгэх техникийн нөхцөл.
- Үйлдвэрийн урьдчилсан туршилтын дүн бүхий протокол.
- Лифтийг угсрах заавар.

Дараах агуулга бүхий ашиглалтын заавар байна. Үүнд:

- Лифтийг магадлан турших аргачлал.
- Лифтийг ашиглах нөхцөлд тавигдах шаардлага, засвар, техникийн үйлчилгээ, техникийн оношлол хийх журам.
- Лифт гацсан үед түүнээс зорчигчийг гаргах аргачлал.
- Түргэн элэгддэг эд ангийн жагсаалт.
- Паспортын загвар.
- Лифтийг угсрах зураг.
- Элементүүдийн тайлбар бүхий цахилгааны схем, цахилгааны холболтын схем.

25.6. Мэргэжлийн хяналтын байгууллагаас дээрх бичиг баримтыг шалгасны үндсэн дээр лифтэнд үйлдвэрлэлийн туршилт хийх талаар шийдвэр гаргана.

25.7. Туршилт хийх шийдвэр гарсан нөхцөлд өргөдөл гаргагч туршилт хийх комиссыг тушаалаар томилно. Комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн хяналтын байгууллагаас улсын байцаагч оролцоно.

25.8. Туршилтыг лифт үйлдвэрлэсэн газар нь эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн туршилтын стэнд дээр гүйцэтгэнэ. Мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр лифтийг угсрах газар нь туршиж болно.

25.9. Туршилтын үр дүнд акт үйлдэнэ. Энэ дүрмийн шаардлагад нийцээгүй үр дүн гарсан нөхцөлд нэмж гүйцэтгэх ажлын даалгавар өгөгдөнө.

25.10. Гадаад орноос лифтийг импортлон оруулж, ашиглахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авах ба техникийн бичиг баримтыг нь монгол, англи хэл дээр орчуулсан байна.

25.11. Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авсан лифтэнд ашиглалтын явцад ашиглагч, үйлчлүүлэгч болон бусад хүмүүсийн аюулгүйн нөхцлийг хангаагүй зөрчил илэрсэн нөхцөлд түүний үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын байгууллагаас зогсоох эрхтэй.

Үйлдвэрлэсэн буюу угсарсан байгууллага нь уг зөрчлийг арилгасны дараа уг лифтийг ашиглах зөвшөөрлийг сэргээн олгоно.

25.12. Лифтийн ослоос хамгаалах хэрэгсэл болон зарим эд хэсгийг өөрчилсний дараа түүнийг хэрэглэх зөвшөөрлийг дахин авах ба энэ үед тухайн өөрчилсөн хэсэгт хэсэгчилсэн туршилт хийж болно.

26. ЛИФТИЙГ БҮРТГЭХ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ

26.1. Шинээр угсарсан лифт бүрийг ашиглалтад оруулахын өмнө, мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлсэн байх ёстой.

26.2. Лифтийн угсралт, тохируулга хийгдсэний дараа түүнд техникийн бүрэн магадлал хийнэ.

Техникийн бүрэн магадлалын шаардлагыг хангаж чадаагүй нөхцөлд гарсан зөрчлийг холбогдох байгууллагаар нь арилгуулаад дахин магадлал хийнэ.

26.3. Лифт эзэмших байгууллага нь энэ дүрмийн 29.6; 29.8-д заасан баримт бичиг бүрдсэн үед лифтийг ашиглалтанд хүлээн авах дараах бүрэлдэхүүнтэй комиссыг томилно. Үүнд:

- Лифт эзэмшигч байгууллагын төлөөлөгч, комиссын дарга.
- Захиалагчийн төлөөлөгч /Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч/
- Лифт угсарсан, шинэчлэл хийсэн байгууллагын төлөөлөгч.
- Лифтийн засвар, техник үйлчилгээний ажлыг хариуцагч буюу гэрээт мэргэжлийн байгууллагын төлөөлөгч.
- Барилгын байгууллагын төлөөлөгч.
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагч.

26.4. Комиссын дарга нь лифт хүлээн авах комиссын ажиллах хугацааг 5 хоногийн өмнө мэдэгдэнэ.

26.5. Лифтийг барилга хүлээж авах улсын комисс ажиллах үед зэрэг хүлээн авах нөхцөлд дээрх комисс нь улсын комиссын дэргэд салбар комисс хэлбэрээр байгуулагдан ажиллаж болно.

26.6. Лифтийг хүлээн авах комиссын дарга нь комиссын бүрэлдэхүүнд дараах бичиг, баримтыг танилцуулна. Үүнд:

- 29.6; 29.8-д заасан баримтууд.
- Лифтчинг томилсон тушаал, лифтчиний мэргэжлийн үнэмлэх.
- Лифтийн засвар үйлчилгээг хийх мэргэжлийн хүнийг томилсон шийдвэр энэ талаар мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээ.
- Лифтийн ашиглалт хариуцагчийг томилсон тушаал.

26.7. Комисс нь лифтэнд үзлэг, шалгалт хийнэ. Үзлэг шалгалтын дүнг үндэслэж комисс 4 дүгээр хавсралтын дагуу “Лифтийг ашиглалтад хүлээн авах” акт үйлдэж, техникийн бэлэн байдлын актын хамт тухайн лифтийн паспортад хавсаргана.

26.8. Дүрмийн 26.11-д заасан зөрчлүүд илэрсэн тохиолдолд комисс, лифтийг ашиглалтад оруулахыг хориглосон үндэслэлүүдийг тусгасан дүгнэлт баримт үйлдэж эзэмшигчид өгнө.

26.9. Лифтийг хүлээж авах комиссын ба техникийн бэлэн байдлын актыг үндэслэн улсын байцаагч шинээр угсарсан лифтийг улсын бүртгэлд авах буюу

шинэчлэл хийгдсэн лифтийн бүртгэлийг шинэчилсний үндсэн дээр паспортад тухайн лифтийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн тухай ба дараагийн ээлжит магадлал хийх хугацааг тогтоож тэмдэглэл хийнэ.

26.10. Лифтийг ашиглалтад оруулах зөвшөөрөл олгох, бүртгэхдээ улсын байцаагч өөрийн нэр, гарын үсгийг бичиж тэмдэг дарсан байна.

26.11. Техникийн магадлал, үзлэг, шалгалтаар доорхи зөрчил илэрсэн нөхцөлд лифтийг ашиглалтад оруулахыг хориглоно. Үүнд:

- Техникийн магадлал, үзлэг, шалгалтын үед арилгаж болохгүй, лифтийн ашиглалтын аюулгүй ажиллагаанд нөлөөлөх гэмтлүүд илэрсэн
- Лифтийн ашиглалт хариуцагч томилогдоогүй.
- Лифтийн засвар, техникийн үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулах хариуцагч томилогдоогүй буюу энэ талаар мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулаагүй.
- Мэргэжлийн үйлчлэгч ажилчин байхгүй.
-

27. ЛИФТИЙН АШИГЛАЛТ

27.1. Лифт эзэмшигч нь түүний ажиллагаанд хяналт тавьж, засвар, үйлчилгээг тогтмол хийх зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар лифтийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангах ёстой. Үүний тулд:

- Хууль эрх зүйн акт, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, техникийн нормыг мөрдөх.
- Лифт ашиглахад шаардагдах боловсон хүчнийг бүрдүүлэх.
- Мэргэжил, эрүүл мэндийн хувьд зохих буй шаардлага хангасан хүн ажиллуулах.
- Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны талаар ажилчдыг тогтоосон хугацаанд нь мэргэжил дээшлүүлж, шалгаж байх.
- Лифт ашиглахтай холбоотой хууль, дүрэм, бусад эрх зүйн акт баримтуудаар ажиллагсдыг хангасан байх.
- Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааг мөрдүүлэх хяналтыг бий болгох.
- Тогтоосон хугацаанд нь лифтийг оношлол, магадлалд оруулдаг, ашиглалтаас хасдаг байх.
- Лифтийн ажлын байранд гадны хүн оруулдаггүй байх
- Улсын байцаагч болон Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн бүрэн эрхийнхээ хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх.
- Осол аваар гарч болзошгүй үед улсын байцаагчийн шаардлагаар буюу өөрөө лифтийн ашиглалтыг зогсоож байх.
- Осол аваар гарсан үед түүний үр дагаварыг арилгах, шалтгааныг тогтооход оролцох, гарсан зөрчлийг арилгах.
- Лифт ашиглалтын талаарх зөрчил, үүсэх шалтгаанд дүн шинжилгээ хийж гарах шалтгааныг арилгах.
- Лифтийн ашиглалтын үед ажилчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авах.
- Осол аваар гарсан үед холбогдох газруудад цаг тухайд нь мэдэгдэж байх.
- Лифтэнд гарсан осол, аварийн бүртгэлтэй байх.
- Мэргэжлийн хяналтын байгууллагад гарсан осол, авар, зөрчил тэдний гарсан шалтгаан, авсан арга хэмжээний талаар мэдээлдэг байх.

27.2. Лифтийн ашиглалт, аюулгүй ажиллагааны байдалд тавих хяналтыг улсын хяналтын байгууллага, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

27.3. Үзлэг, шалгалтын дүнг тухайн лифтийн паспортад бичих бөгөөд шаардлагатай үед холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага өгч, зөрчил дутагдлыг арилгуулна.

27.4. Лифт эзэмшигч нь зөрчлийг арилгасан тохиолдолд энэ тухайгаа улсын хяналтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

27.5. Лифтэнд тавих үйлдвэрлэлийн хяналтын журмыг байгууллагын удирдлага боловсруулж мэргэжлийн хяналтын байгууллага, Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч талуудтай зөвшилцөн батална.

27.6. Лифтийн бүхээгт буюу үндсэн зогсоолын талбайд. Үүнд:

- Лифт ашиглах заавар.
- Аваарийн алба буюу үйлчлэгч ажилчидтай холбоо барих утасны дугаар бүхий пайз хадна.

27.7. Лифтийг өөр эзэмшигч буюу түрээслэгчид шилжүүлэх нөхцөлд паспортыг хамт шилжүүлнэ.

27.8. Лифтийн шинэ эзэмшигч буюу түрээслэгч нь лифтийн ашиглалтыг энэ дүрмийн дагуу зохион байгуулж мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

27.9. Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагын удирдлага дараахь үүрэгтэй. Үүнд:

- Лифтийг ашиглалтад оруулсны дараа ээлжит техникийн магадлалыг 12 сар тутамд нэгээс доошгүй удаа хийлгэнэ. Үүний тулд дурьдсан хугацаанд техникийн магадлал хийлгэх бэлтгэл ажлыг / лифтчид, засвар үйлчилгээ болон ашиглалт хариуцагч нарыг бэлэн байдалд байлгах / ханган эрх бүхий байгууллагад мэдэгдэн гүйцэтгүүлнэ.
- Ээлжит техникийн магадлал хийлгэхийн өмнө лифтэндээ урсгал засвар хийлгэсэн байвал зохино.
- Лифт эзэмшигч байгууллага нь лифтээ техникийн магадлалд оруулснаар лифтнийхээ техникийн байдал, засвар үйлчилгээ хийдэг байгууллага хүмүүсийн ажлын чанарын талаар мэдэж аваад цаашид ямар засвар, үйлчилгээ хийх шаардлагатай, ямар сэлбэг нөөцөлж байх хэрэгтэй болохыг тогтоолгож авна.

Лифтийг хүлээн авсан өдрөөс эхлэн техникийн паспортыг хөтөлж эхлэнэ. Ингэснээр лифтийн ашиглагдаж эхэлсэн өдрөөс эхэлж түүний тухай түүх нь бичигдэж, техникийн байдлыг тодорхойлох, санхүүгийн хувьд зарцуулсан зардлыг тооцох, аливаа осол аваарь гарсан нөхцөлд түүний хариуцлагыг хүлээх этгээдийг тогтооход чухал баримт болдог бөгөөд үүний тулд дараах ажлуудыг хийнэ. Үүнд:

- Лифтийн засвар, үйлчилгээний ажлыг хариуцан гүйцэтгэгч, ашиглалт хариуцагчийг томилсон тушаалын дугаар, он, сар, өдөр, овог нэр, албан тушаалыг лифт бүрийн паспорт дээр бичиж гарын үсгийг зуруулна.
- Лифтийн засвар ба техник үйлчилгээний ажлыг хариуцах мэргэжлийн хүнгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан паспортод тэмдэглэнэ.
- Лифтэнд засвар, техникийн үйлчилгээ, магадлал хийх бүрд паспортонд хийсэн ажлыг дэлгэрэнгүй бичиж, гүйцэтгэсэн хүнээр гарын үсэг зуруулна.

Лифт эзэмшигч нь түүний засвар, техникийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд энэ дүрмийн шаардлагын дагуу эрх, үүргийг тусгасан гэрээтэй ажиллана. Гэрээнд дараах зүйлийг заавал тусгасан байна. Үүнд:

- Хоёр талын гэрээгээр хүлээх эрх, үүрэг, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд харилцан хүлээх хариуцлага.

- Гүйцэтгэх ажлын хэмжээ, чанар, ажлын чанарыг хянах хэлбэр, гарсан маргааныг шийдвэрлэх тухай.
- Ажлын гүйцэтгэлийг хүлээж авах журам.
- Гэрээнд лифтийн засвар, үйлчилгээ хийх мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.
- Мэргэжлийн үнэмлэх бүхий лифтчин, диспетчер, цахилгаан механикч нарыг ажилд авч тэдэнд ажил үүргийн заавар өгч, бусад холбогдох дүрэм журмаар ханган ажиллах.
- Машины өрөөнд лифтийн цахилгааны схем, тосолгооны картын самбар хийж тавих.
- Улсын байцаагч болон барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн албан шаардлагыг тогтоогдсон хугацаанд нь биелүүлж, биелэлтийг албан бичгээр гаргаж өгөх, лифтийг ажиллуулахыг хориглосон нөхцөлд зөвхөн улсын байцаагч болон мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрлөөр ажиллуулах.

27.10. Лифтийн ашиглалт хариуцагчийг байгууллагын даргын тушаалаар томилно. Энэ албан тушаалтан нь лифтийн цахилгаан-механикч эсвэл цахилгааны буюу механикч инженер мэргэжилтэй хүн байна. Тухайн байгууллагад ийм мэргэжлийн хүн байхгүй нөхцөлд байгууллагын дарга байна.

27.11. Лифтийн ашиглалт хариуцагч нь дараах зүйлсийг мэддэг байвал зохино. Үүнд:

- "Лифтийг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм", "Цахилгаан байгууламжийн дүрэм" /БД 43-101-03/ , "Захиргааны хариуцлагын тухай", "Төрийн хяналт шалгалтын тухай", "Барилгын тухай", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам.
- Лифтчин, диспетчер, цахилгаан механикч, ашиглалт хариуцагчийн ажил үүргийн хуваар.
- Өөрийн байгууллагад ашиглагддаг лифтийн ерөнхий бүтэц, ажиллах зарчим, техникийн үндсэн үзүүлэлт.
- Лифтийн техникийн үйлчилгээ, магадлалаар хийгдэх ажил, түүний ажлын чанарыг шалгах, хүлээн авах ажил.

27.12. Лифтийн ашиглалт хариуцагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- Лифтийн техникийн паспортыг хөтөлж, лифтэнд засвар, үйлчилгээ хийх бүрд хийгдсэн ажлыг дэлгэрэнгүй бичүүлж гүйцэтгэсэн хүнээр нь гарын үсэг зуруулж, лифтэнд гарч болох аливаа осол, эвдрэл гэмтлийг хариуцах эзнийг тогтоох баримт, нотолгоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.
- Лифтчин механикуудад ажил үүргийн, аюулгүй ажиллагааны зааварчилга өгч холбогдох дүрэм, журмын мөрдөлтөд хяналт тавих.
- Лифтчин, диспетчер, цахилгаан механик зэрэг хүмүүсийг дүрмийн дагуу давтан сургалтанд хамруулж, мэргэжлийн комиссоор шалгуулан үнэмлэхэд нь тэмдэглэл хийлгэх.
- Лифтийн засвар, техникийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг тохиолдолд тэд гэрээт үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.
- Ээлжит техникийн магадлал хийлгэх бэлтгэлийг хангаж, түүнийг хугацаандаа чанартай хийлгэх ажлыг зохион байгуулж, өөрөө тэр ажилд байлцана.
- Мэргэжлийн үнэмлэхгүй, давтан шалгалт өгөөгүй лифтчин, зөвшөөрлийн гэрчилгээгүй буюу зөвшөөрлийн хугацаа нь дууссан

механик, мэргэжлийн байгууллагаар лифтэнд аливаа ажил үйлчилгээ хийлгэхгүй байх.

- Лифтэнд осол гарсан нөхцөлд осолдогчид яаралтай эмнэлгийн тусламж үзүүлэн 24 цагийн дотор мэргэжлийн хяналтын болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэж холбогдох хүмүүсийг иртэл ослын байдлыг хэвээр байлгах.
- Машины өрөөний болон хонгилын гэрэлтүүлгийн бүрэн байдал, давхруудад лифт ашиглах заавар байгаа эсэх, машины тасалгааны цоож түгжээний найдвартай байдалд онцгой анхаарах.
- Улсын байцаагч болон барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн албан шаардлагыг дурьдсан хугацаанд нь гүйцэтгэж хариуг албан бичгээр мэдэгдэж байх ажлыг зохион байгуулах.
- Лифтэнд гадны байгууллагаар хийлгэсэн ажлыг шалган хүлээж авах, эвдрэл гэмтлийн акт тогтоох комиссыг ахлан ажиллаж холбогдох бичиг баримтыг үйлдэх.
- Лифтчин, диспетчер, цахилгаан механикууд ажиллах журмаа зөрчсөн нөхцөлд арга хэмжээ авах, арга хэмжээ авахуулах, талаар холбогдох албан тушаалтанд уламжлах.
- Лифтийн засвар, техникийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх мэргэжлийн байгууллага нь үүргээ биелүүлэх чадвар, боломжоор дутагдалтай байгаа нөхцөлд мэргэжлийн хяналтын газарт мэдэгдэх.
- Осол аваар гарч болохоор гэмтэл, доголдолтой лифтийг засаж хэвийн болгох хүртэл нь ажиллуулахгүй байх.

27.13. Лифтчинээр 18 насанд хүрсэн эмчийн үзлэгт орсон эрүүл мэндийн шаардлага хангасан хүмүүсийг авч ажиллуулна.

27.14. Лифтчидийн мэдлэг, дадлагыг эзэмшигч байгууллагаас зохион байгуулсан мэргэжлийн комисс жил бүр шалгана.

27.15. Лифтчин дараах зохих зүйлсийг мэддэг байх шаардлагатай. Үүнд:

- Ажиллаж байгаа лифтийнхээ бүтэц зохион байгуулалт.
- Удирдлагын системийн зорилго ба түүнийг зөв ажиллуулах арга.
- Ослоос хамгаалах хэрэгслийн байрлал ба түүний ач холбогдол, хаалганы цоож, хаалга, шалны доорхи авалцаа, баригч, төгсгөлийн унтраалга, хурд хязгаарлагчийн ажиллагаа.
- Дохионы зориулалт.

27.16. Лифтчинд хориглох зүйлүүд:

- Ажлын цагт лифтийг эзэнгүй орхих.
- Ганцаараа хонгилын худагт орох, бүхээгийн орой дээр гарах ба түүн дээр ямар нэгэн зүйл хадгалах.
- Хонгил, бүхээгийн хаалга онгорхой үед лифтийг зогсоолын талбайгаас явуулах.
- Машины өрөөг онгорхой орхих.

27.17. Лифтчин лифтэнд тохиолдсон гэмтлийн тухай лифтийн ашиглалт хариуцагч, цахилгаан-механикчид мэдэгдэж гэмтлийг арилгатал лифтийг ажиллуулахгүй байх.

Лифтчин өөрийн дураар лифтийн эд ангийг оролдох, тохиолдсон гэмтлийг засварлахыг хориглоно.

27.18. Лифтэнд засвар, үйлчилгээ хийсний дараа зөвхөн тухайн лифтийг зассан цахилгаан-механикчийн зөвшөөрснөөр лифтийг ажилд оруулна.

27.19. Лифтчин лифтийг ажилд оруулахын өмнө ерөнхий залгуурыг залгаж машины өрөөг цоожлоод дараах зүйлийг шалгана. Үүнд:

- Хонгил, бүхээг болон зогсоолын талбайн гэрэлтүүлгүүд.
- Хонгил, бүхээгийн цэвэрлэгээ, лифтийн бүрэн бүтэн байдал.

- Дуут ба гэрлэн дохионы ажилтай эсэх.
- Бүхээг үндсэн зогсоолын талбайд лифтийг ажиллуулах заавар байгаа эсэх.
- Хонгил, бүхээгийн хаалганы автомат цоож ажилтай эсэх.
- Хонгил, бүхээгийн хаалганы ослоос хамгаалах хэрэгсэлийн ажиллагааг шалгахдаа аль нэгэн хаалгыг онгорхой байлгаж удирдлагын аль ч товчлуурыг дарахад бүхээг нь хөдөлгөөнгүй байхыг магадлах.
- Дотроос удирдлагатай лифтэнд шалгалтыг бүхээг дотроос гүйцэтгэнэ.
- Гаднаас удирдлагатай лифтэнд шалгалтыг хоёр хүн гүйцэтгэнэ.
- Үүний тулд нэг хүн удирдлагын аппаратын дэргэд, нөгөө нь шалгагдаж байгаа хаалганд ажиглалт хийнэ.
- Ослоос хамгаалах хэрэгсэлийн ажиллагааг шалгахын тулд хаалганы самбар нэг бүрийг ээлж дараалан онгорхой байлгаж лифтэнд дуудлага өгнө.
- Дуудлаганд лифт хөдлөхгүй байх ёстой.
- Бүхээг давхрын талбайгаас дээш доош 0.2 м-ээс илүүгүй зайд ирэхэд бүхээгний хаалга цоожтой байх буюу онгойсон нөхцөлд бүхээгийг зогсоож байгаа эсэх.
- Ачааны болон эмнэлгийн үйлчлэгчтэй лифтын цоожийг бүхээг дотроос шалгана.
- Харин ачааны, бага ачааны үйлчлэгчгүй лифтийн шалгалтыг гадна талаас нь гүйцэтгэнэ. Цоожны ажиллагаатай эсэхийг бүх давхруудад шалгана.
- Шалны доорхи авалцаа ажилтай эсэх.
- Шалан доорхи авалцааг шалгахдаа бүхээг дотор хүн байхад дуудлага авахгүй байхыг батлах ёстой. Шалан доорхи авалцааны шалгалтыг хоёр хүн гүйцэтгэнэ. Үүний тулд нэг хүн бүхээгдээ суугаад түүнийг хагас давхар дээш явуулахад хоёр дахь хүн дороос дуудах товчлуурыг дарна.
- Гэрлэн дохионууд ажиллагаатай байгаа эсэх.
- Дохионы ажиллагааг шалгахдаа хүн зөөврийн лифтэнд хаалга нь онгорхой ба хаалттай мөн дотроо хүнтэй байвал “завгүй” гэдэг дохионы гэрэл асч байна. Харин ачааны лифтийн хонгилын хаалга онгорхой үед “завгүй” гэдэг дохионы гэрэл асч хаалгыг хаасан үед дохио асахгүй байна.

27.20. Лифтэнд үзлэг шалгалт хийж байхад гэмтэл илэрвэл “Лифт ажиллахгүй”, “засвартай” гэсэн анхааруулах бичээсийн аль нэгийг хонгилын хаалга бүрт өлгөж лифтийг зогсооно. Илэрсэн гэмтийн тухай лифтийн ашиглалт хариуцагч, цахилгааны механикч нарт даруй мэдэгдэх үүрэгтэй.

27.21. Хүн зөөврийн лифтийн ажлын үед лифтчин дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Лифтийн даацыг хэтрүүлэхгүй байх.
- 12 хүртэлх насны хүүхдийг хүргэж өгөх.
- Насанд хүрэгсдийг тэдний хүсэлтээр хүргэж өгөх.
- “Завгүй” гэсэн гэрэл дохио ассан үед зорчигчдоор бүхээгийг дууддаг товч даруулахгүй байх.
- Хүүхдийн тэргийг бүхээгт оруулах, гаргахад хүүхдээ гар дээрээ авч байхыг зөвлөх.
- Бүхээг нь давхрын хооронд зогсвол зорчигчдоос өөрсдөө арга хэмжээ авахаар оролдож болохгүйг сануулаад механикийг дуудах.

27.22. Ачааны лифтийн үйлчлэгч нар дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Бүхээгний даацыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.
- арин ачигдсан ачааныхаа хүндийн жинг бүрэн тодорхойлж чадахгүйд хүрвэл уг ачааг тээвэрлэх зөвшөөрлийг лифтийн ашиглалт хариуцагчаас авах ёстой.
- Гаднаас удирдлагатай лифтэнд ямар ч үед хүн суулгахыг хориглож хүн зорчиж байвал лифтийн ашиглалт хариуцагчид мэдэгдэх.
- Бүхээгийн давхраас дуудах үед бүхээг нь дугтрагдах доргих зэрэг ямар нэг зөрчил ажиглагдвал цаг тухайд нь лифтийн ашиглалт хариуцагчид мэдэгдэж зохих арга хэмжээ авахуулах.
- Ачаа тээвэрлэж байгаа үед бүхээг дотор үйлчлэгчээс гадна ачааг хүргэгчээс өөр хүн байхыг хориглох.
- Бүхээг нь давхруудын хооронд зогсвол үйлчлэгч нар нь гэмтлийн дохио өгөөд цахилгаан механикч ирэхийг хүлээнэ.

27.23. Доор дурьдсан гэмтэл тохиолдсон үед үйлчлэгч нар нь цахилгааны ерөнхий залгуурыг салгаж хүчдэлийг салган лифтийг зогсоож лифтийн ашиглалт хариуцагч буюу цахилгаан-механикчид мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

- Хонгилын хаалга онгорхой ба бүхээг хүнтэй үед бүхээг хөдөлгөөнд орох.
- Дохиоллын гэрлүүд ажилгүй болсон.
- Хөдөлгөөнт шалтай лифтийн бүхээгэнд хүн байгаа буюу бүх хүмүүс гарч хаалга хаасан үед дохионы гэрэл асах.
- Давхрын зогсоолд бүхээг ирээгүй байхад хонгилын хаалга гаднаас онгойх.
- Бүхээг ямарч удирдлагагүйгээр хөдөлгөөнд орох.
- Лифтийн бүхээг нь дуудлага буюу тушаал өгсөн давхартаа зогсохгүй байх.
- Лифтийн цахилгааны дамжуулах утас, аппаратын хөндийрүүлэгч нь муудсан /цахилгаан гүйдэл цохиж, хөндийрүүлэгч халж шатсанаас үнэр гарах г.м/.
- “Зогс” товчлуур эвдэрсэн.

Мөн дээр дурьдсанаас гадна бүхээг хөдлөх үед хэвийн биш дуу, цохио гарах, тэнцүүлэгч чиглүүлэгчээс мултрах, давхрын талбайд жигд бус зогсох зэрэг гэмтэл илэрвэл.

27.24. Лифтчин лифтийн бүхээгэнд тавигдсан гэрлийн шил шатсан, шилийг солиход асахгүй байвал лифтийг зогсоож цахилгаанчинг дуудна.

27.25. Лифтчин ажил дууссаны дараа дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Лифтээ ажил эхэлдэг үндсэн зогсоол буюу хянаж удирддаг түвшинд зогсоох.
- Бүхээг хоосон байгааг шалгаж үзэх / ажлын дараа бүхээгийг ачаатай орхихыг хориглоно/.
- Автомат удирдлагагүй бол бүхээгний гэрлийг өөрөө унтраах.
- Бүхээгний хаалга автомат цоожгүй бол хонгилын хаалгыг цоожлох.
- Машины өрөөний гэрлийг унтрааж цахилгааны ерөнхий залгуурыг салгах.
- Машины өрөөг цоожлоод түлхүүрийг зохих журмаар жижүүрт үлдээнэ.

27.26. Лифт ашиглалтын явцад дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- Лифтийн машины ба блокийн өрөө, хонгилд түүний ашиглалтад хамаарахгүй бусад зүйл хадгалах.
- Эмнэлгийн /өвчтөний/ болон дотор удирдлагатай ачааны лифтээр зөвхөн лифтчин үйлчлэгчтэйгээр хүн, ачаа зөөвөрлөх.
- Ачааны лифтээр хүн ба ачааг хамт зөөвөрлөхийг.

Харин ачааг дагалдагч хүн ба лифтчин нь ачаатай хамт байж болно.

- Гадны удирдлагатай лифтээр хүн зөөвөрлөхийг.
- Лифтээр тэсрэх аюултай, химийн ба цацраг идэвхит ачаа зөөх тохиолдолд лифт ашиглагч байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрлийг авах ба ачааг дагалдагч ажилчны аюулгүй байдал, лифтийн тоног төхөөрөмжийг гэмтээхгүй байх арга хэмжээ авна.

Дээр дурдсан ачаа болон зорчигчдыг нэг зэрэг хамт зөөвөрлөхийг хориглоно.

Лифтээр галын аюултай ачаа зөөвөрлөх үед / хялбар шатах шингэн, шатах шингэн/ галын аюулаас хамгаалах шаардлагыг хангах ёстой.

27.27. Лифтийн ашиглалт, техникийн үйлчилгээ хариуцагчийн үүргийг тушаалаар зааж өгнө.

27.28. Мэргэжлийн үнэмлэх бүхий цахилгаан механик, лифтчин, диспетчерийг тушаалаар томилно.

27.29. Цахилгаан механикч, лифтчин, диспетчер нь өөрт хариуцуулсан лифтийн хүрээнд ажиллана.

27.30. Ашиглагч байгууллага нь цахилгаан механикч, лифтчин, диспетчерт тэдгээрийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх энэ дүрэм, ажил үүргийн хуваарь, тухайн ажлыг гүйцэтгэх үйлдвэрлэлийн болон аюулгүй ажиллагааны зааврыг өгч судлуулна.

28. УГСРАЛТ, ЗАСВАР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

28.1. Лифтийн угсралт, засвар, техникийн үйлчилгээ, шинэчлэл хийх ажлыг эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан, мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

28.2. Лифтийг угсрах, засварлах, аж ахуйн нэгж, байгууллага нь эдгээр ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авахын тулд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Угсрах, засварлах лифтүүдийн төрөл, хэлбэр техникийн үзүүлэлтүүд.
- Монгол, англи хэлээр бичигдсэн угсралт, тохируулгын технологийн заавар, техникийн нормууд /угсрах эрх авах нөхцөлд/.
- Монгол, англи хэлээр бичигдсэн засвар, техникийн үйлчилгээ хийх технологийн заавар, техникийн нормууд /засвар үйлчилгээ хийх эрх авах нөхцөлд/.
- Угсралт, засвар, техникийн үйлчилгээ хийх ажилд шаардагдах багаж хэрэгслийн хангалтын тухай мэдээлэл.
- Лифтийн угсралт, засвар, техникийн үйлчилгээг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчний хангалтын тухай мэдээлэл, ажилчид нь дүрмийн мэдлэгийн шалгалт өгсөн тухай протокол.
- Угсралтын үед гагнуурын ажлыг гүйцэтгэх гагнуурчны эрхийн үнэмлэхтэйг баталсан баримт.

28.3. Тусгай зөвшөөрлийг 3 жилээс илүүгүй хугацаатай олгоно.

28.4. Лифтийн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар техникийн үйлчилгээний систем нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

- Үечилсэн үзлэг, урсгал засвар, аваар-техникийн үйлчилгээнээс бүрдсэн техникийн үйлчилгээний систем.
- Их засвар, ашиглалтын явцад өөрчлөн сайжруулах ажлаас бүрдсэн лифтийг сэргээн засварлах үйл ажиллагаанаас бүрдэнэ.

28.5. Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварын ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагыг оролцуулж болно.

28.6. Лифт ашиглагч буюу мэргэжлийн байгууллага нь ажлын багтаамж, нөхцлөөс хамааран ажиллах хүчний баг бүрдүүлсэн байна.

28.7. Лифт ашиглагч буюу мэргэжлийн байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд нь мэргэжлийн хяналтын байгууллагад үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаж шалгалт өгсөн байна.

28.8. Дээрх хүмүүс цахилгааны аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх ёстой.

28.9. Лифтийн үечилсэн үзлэгийг лифтчин гүйцэтгэнэ.

28.10. Диспетчерийн хяналттай лифтийн үйлчилгээг мэргэжлийн хяналтын байгууллагатай зохицон өөр үечлээр гүйцэтгэж болно.

28.11. Засвар, техникийн үйлчилгээ гүйцэтгэх эрх бүхий байгууллага нь дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Лифт эзэмшигчид лифтийн паспортыг хэрхэн хөтлөх бусад холбогдох бичиг баримтыг яаж бүрдүүлэх талаар мэргэжлийн зүгээс заавар зөвлөгөө өгөх.
- Лифт ашиглалтын талаар гарч буй аюулгүй ажиллагааны зөрчил дутагдлыг арилгах талаар лифт эзэмшигчид зөвлөгөө өгч, биелэгдэхгүй байгаа зөрчлийн талаар хяналтын байгууллагад мэдэгдэх.
- Давхар бүрд лифт ашиглах заавар, машин зааланд лифтийн цахилгааны схем, тосолгооны картыг хийж тавихыг шаардаж, хийхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх.
- Лифтэнд засвар, техникийн үйлчилгээ хийх график төлөвлөгөө боловсруулж байгууллагын даргаар батлуулан мөрдөж ажиллах.
- Лифтэнд засвар хийсэн тохиолдолд гүйцэтгэсэн ажлаа лифтийн ашиглалтыг хариуцагчид хүлээлгэн өгөөд, паспорт дээр өөрийн хийсэн ажлаа дэлгэрэнгүй бичиж гарын үсгээ зурна. Шаардлагатай үед лифтэнд хэсэгчилсэн техникийн магадлал хийж акт үйлдэнэ.
- Техникийн үйлчилгээ хийхдээ лифтийн ашиглалтын зааварт бичигдсэн технологийн дагуу эзэмшигч байгууллагын төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэж тэдэнд хийж байгаа ажлаа тайлбарлан хэрхэн хяналт тавьж байх талаар зааж зөвлөнө.
- Мэргэжлийн хяналтын байгууллагаас лифт эзэмшигч байгууллагад өгсөн албан шаардлагаас гэрээний үүргийн дагуу өөрт хамаарагдах хэсгийг дурьдсан хугацаанд нь биелүүлэх.

29. ЛИФТИЙН ТЕХНИКИЙН ОНОШЛОЛ, МАГАДЛАЛ

29.1. Техникийн магадлалыг лифтийн техникийн байдлыг тодорхойлох зорилготой хийнэ. Тэр нь бүрэн, ээлжит, хэсэгчилсэн магадлал гэсэн 3 төрөлтэй байна.

Засвар, техникийн үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгэж байгаа тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, лаборатори техникийн магадлалыг гүйцэтгэнэ.

Техникийн магадлалыг гүйцэтгэх ажил мэргэжлийн хяналтын байгууллагын байнгын хяналтанд байна.

Туршилтыг хийхдээ тахометр, амперметр, металлын гэмтэл илрүүлэгч, туухай, лазерын зай хэмжигч, люксмер зэрэг хэмжигч багажуудыг ашиглана.

29.2. Шинээр угсарсан лифтийг ашиглалтад оруулахын өмнө түүнд мэргэжлийн хяналтын байгууллагаас техникийн бүрэн магадлал хийнэ.

29.3. Техникийн бүрэн магадлалыг дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- Тухайн лифт нь энэ дүрэм болон техникийн паспортын өгөгдөлтэй нийцэж байгааг магадлах.
- Лифтийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны нөхцөл хангагдсан байдлыг магадлах.
- Бичиг баримтын иж бүрдэл энэ дүрмийн дагуу хийгдсэн эсэх.

29.4. Лифтийн бүрэн магадлалыг лифт угсарсан байгууллагын хүсэлтээр тэдний болон барилгын байгууллагын төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэнэ.

29.5. Лифтийн бүрэн магадлалаар лифтийн бүх эд ангийг үзэж, хэмжин бүх горимд ажиллуулж шалгаад энэ дүрмийн дагуу туршилт хийнэ.

29.6. Техникийн бүрэн магадлалаар дараах бичиг баримтын бүрдлийг шалгана. Үүнд:

- Далд ажлын акт.
- Төхөөрөмжийн газардуулгыг шалгасан протокол.
- Дохиолол, удирдлага, хүчний цахилгаан төхөөрөмж, гэрэлтүүлгийн ба хүчний цахилгааны утасны хөндийрүүлэгчийн эсэргүүцэл хэмжсэн протокол.
- “0”-ийн шугамыг газардуулаад цахилгааны 1000В хүртэл хүчдэлийн тэжээлтэй үед хамгаалалт ажиллаж байгааг шалгасан протокол.

29.7. Техникийн бүрэн магадлалаар дараах үзлэг шалгалт хийгдэнэ. Үүнд:

- Лифтийн тоног төхөөрөмж нь паспортын өгөгдөлтэй нийцэж байгаа эсэх.
- Угсаргааг зургийн дагуу хийсэн байдлыг үзэж, хэмжиж шалгах.
- Лифтийн ажиллагаа нь түүний ашиглалтын зааврын дагуу байгаа эсэх.
- Энэ дүрмийн дагуу туршилт хийх.
- Нийлүүлэгчээс хүлээлгэн өгсөн бичиг баримтын бүрдэл бүрэн эсэх.

29.8. Техникийн бүрэн магадлал хийсний дараа акт үйлдээд лифтийн паспорт дээр тэмдэглэл хийн магадлал хийсэн байгууллагын гүйцэтгэгч нар гарын үсгээ зурж тэмдэг дарна.

29.9. Лифтийг ашиглалтад оруулсны дараа ээлжит техникийн магадлалыг 12 сар тутамд нэгээс доошгүй удаа хийнэ.

29.10. Ээлжит техникийн магадлалыг дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- Лифт бүрэн бүтэн, аюулгүй ажиллагааны нөхцөл ханган ажиллаж байгааг магадлах.
- Лифтийн ашиглалтыг энэ дүрмийн шаардлагын дагуу зохион байгуулж байгаа эсэхийг магадлах.

29.11. Ээлжит техникийн магадлалаар дараах үзлэг шалгалт хийгдэнэ. Үүнд:

- Лифтийн тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад өөрчлөгдөж болох үзүүлэлтүүд нь паспортын өгөгдөлтэй нийцэж байгаа эсэх.
- Лифтийн ажиллагаа нь ашиглалтын зааврын дагуу байгаа эсэх.
- Энэ дүрмийн дагуу туршилт хийх.
- Лифтийн ашиглалтыг энэ дүрмийн шаардлагын дагуу зохион байгуулж байгаа эсэх.

29.12. Их засвар хийсний дараа болон 29.14-т заасан ажлууд хийгдсэний дараа хэсэгчилсэн техникийн магадлал хийнэ.

29.13. Хэсэгчилсэн техникийн магадлал нь лифтийн үндсэн эд ангиудыг шинээр сольсон ба засварласан үед тэдгээр нь аюулгүй ажиллагааг хангасан хэвийн байдалтай байгааг тодорхойлох зорилгоор хийгдэнэ.

29.14. Лифтийн дараах эд ангийг сольсны дараа хэсэгчилсэн техникийн магадлал хийнэ. Үүнд:

- Бүхээг.
- Эргүүлэг /өргүүр/.
- Ган татлага, хөтлөх хүрд.

- Ослоос хамгаалах баригчууд.
- Хурд хязгаарлагч.
- Удирдлагын шкафыг сольсны дараа буюу цахилгаан схемд өөрчлөлт оруулсан үед.

29.15. Хэсэгчилсэн техникийн магадлалаар дараах ажлыг хийнэ. Үүнд:

- Лифтийн засварласан болон сольсон тоног төхөөрөмж паспортын өгөгдөлтэй нийцэж байгаа эсэх.
- Засварласан болон шинээр угсарсан тоног төхөөрөмжийн байдлыг үзэж, хэмжиж шалгах.
- Засварласан болон шинээр угсарсан тоног төхөөрөмжид туршилт хийх.
- Ослоос хамгаалах хэрэгслийн ажиллагааг шалгах.

29.16. Лифтийн тоног төхөөрөмжийг нүдээр үзэн, хэмжиж шалгахдаа лифтийн тоног төхөөрөмжийн үзүүлэлт нь паспортын өгөгдөлтэй, байрлалын хэмжээ нь угсралтын ажлын зурагтай таарч байгаа эсэхийг нягтлана.

29.17. Лифтийг ажиллуулж шалгах үед түүнийг бүх горимдоо цахилгааны схемийн ажиллах зарчмын дагуу хэвийн ажиллаж байгааг нягтлаад, дараах механизмын ажиллагааг шалгана. Үүнд:

- Эргүүлэг /өргүүр/
- Бүхээг, хонгилын хаалга, түүний ажиллагаа.
- Туршилтын үед шалгадгаас бусад ослоос хамгаалах хэрэгсэл.
- Дохиолол, холбоо, диспетчерийн хяналт, гэрэлтүүлэг.
- Бүхээгний давхарт зогсох нарийвчлал.

29.18. Лифтийн туршилтаар түүний хурд хязгаарлагч, баригч, зөөлөвч тулгуур, тоормосны систем, цахилгаан төхөөрөмж, үндсэн дамар, газардуулга, цахилгаан хэлхээний тусгаарлагчыг туршина.

29.19. Хурд хязгаарлагчийг туршихдаа лифтийг ачаалахгүйгээр хурдыг нь паспортад заасан хэмжээгээр ихэсгээд хурд хязгаарлаж байгааг, мөн энэ үед баригч барьж байгаа эсэхийг шалгаж үзнэ.

29.20. Баригчийг туршихдаа баригч ажиллаад бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийг чиглүүлэгч дээр зогсоон барьж чадаж байгааг шалгана. Баригчийг мэдэрч ажиллах ёстой нөхцөл бүр дээр нь тусад нь туршиж үзнэ.

Бүрэн магадлалын үед болон бүхээг сольсны дараа баригчыг дараах ачааллаар туршина. Үүнд:

- Аажим зогсоогч баригчтай бол хэвийн даацыг 25% ихэсгэж.
- Огцом зогсоогч буюу амортизатор бүхий огцом зогсоогч баригчтай бол хэвийн даацаар.
- Ээлжит магадлалын үед бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн баригчыг бүхээгийг ачаалалгүйгээр шилжүүлж туршина.

Бүхээгийг ажлын хурдаар шилжиж байх үед баригчыг турших ба 1 м/с-ээс их хурдтай лифтэнд ажлын хурднаас бага хурдаар туршиж болох боловч энэ хурд нь 1 м/с-ээс багагүй байна.

29.21. Пүрштэй болон цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуурыг сольсны дараа буюу бүрэн магадлалын үед бүхээгт хэвийн даацын хэмжээний ачаатай байхад түүнийг ажлын хурдаар тулгуур дээр буулгаж туршина.

Бусад зөөлөвч тулгуурын хувьд тулгуурын агшилтаас хамаарч хурдыг багасган сонгож авна. Харин ээлжит магадлалын үед пүрштэй тулгуурыг турших шаардлагагүй түүний байдал, байх ёстой хэмжээсийг үзэж, хэмжиж шалгана. Цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуурын хувьд хоосон бүхээгийг 0.71 м/с хурдаар шилжүүлж тулгуур дээр буулгаж туршина.

29.22. Тоормосыг сольсны дараа техникийн бүрэн магадлал хийхдээ лифтийг хэвийн даацаас 25% илүү ачаатай ажлын хурдаар доош явуулж байгаад хөдөлгүүрийг унтраахад тоормос ажиллаж хөдөлгөөн зогсож түүний удаашруулах хурдатгал нь 9.81 м/с^2 -аас ихгүй байгааг нягталж туршина.

Ээлжит магадлалын үед бүхээгийг ачаагүйгээр дээш шилжүүлж байх үед хөдөлгүүрийг зогсоож тоормос барьж байгааг шалгаж туршина.

29.23. Баригч, эсрэг ачаа, зөөлөвч тулгуурыг туршсаны дараа лифтийн татлага түүнд хамаарах эд ангид ямар нэг гэмтэл илэрсэн эсэхийг үзэж шалгана.

29.24. Удирдлагат хувьсгуур бүхий хөдөлгүүрийг паспортад нь түүний цахилгаан тоормослох чадварыг туршихаар заасан бол түүнийг гүйцэтгэнэ.

Цахилгаан хөдөлгүүрийн тоормослох чадварыг шалгахдаа бүхээг хамгийн дээд давхарт байх ба тоормосны колодка тавиастай байх үед 3 минут байлгаж үзнэ. Мөн бүхээгийг шилжүүлээд түүний давхарт зогсох нарийвчлалыг шалгаж болно.

29.25. Үрэлтийн дамар буюу хүрдтэй лифтний татлага нь дамар /хүрд/-тай барьцалдах хэмжээг бүрэн магадлалын үед туршихдаа бүхээгийг хонгилын доод байрлалд байхад хэвийн даацаас 25% илүү ачаалаад доош шилжүүлнэ. Энэ үед бүхээгийг зөөлөвч тулгуурт хүрэхээс өмнө доод давхарт зогсооно. Харин ээлжит магадлалын үед хоосон бүхээгийг хонгилын дээд хэсгээс дээш шилжүүлж бүхээгийг дээд давхарт бүрэн зогсож байгааг шалгана.

29.26. Эсрэг ачаа тулгуур дээр бүрэн суусан үед бүхээг дээш шилжихгүй байхыг шалгахдаа бүхээгийг дээш нь гар удирдлагаар буюу эсвэл хөдөлгүүрийн бага хурдаар шилжүүлэх гэж оролдоно. Энэ үед бүхээг дээш шилжихгүй байх ёстой.

29.27. Газардуулга, дамжуулагчийн тусгаарлагчийн эсэргүүцэл, хэлхээний хамгаалах тоноглолыг угсралт, шинэчлэл хийсний дараа болон техникийн бүх магадлалын үед шалгана.

29.28. Ашиглалтын явцад шинэчлэл хийсэн лифтэнд хэсэгчилсэн магадлал хийхдээ шинэчилж өөрчилсөн техникийн бичиг, баримт, өөрчлөлт хийсэн эд ангийг шалгаж, хэмжиж үзнэ.

29.29. Лифтийн солигддоггүй металл хийцэд үл эвдлэх аргаар шинжилгээ хийж тэнцсэн тохиолдолд лифтийн цаашид ашиглагдах хугацааг тогтоож өгнө.

29.30. Лифтийн ашиглагдах хугацаа дууссаны дараа түүний ашиглагдах хугацааг сунгаж болох талаар эрх бүхий мэргэжлийн байгууллага шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Үүнд дараахь ажил хийгдэнэ. Үүнд:

- Гадна үзлэг, хэмжилт хийх.
- Лифтийг бүх горимоор нь ажиллуулж шалгана.
- Лифтийн тоног төхөөрөмжид гэмтэл, зөрчил, элэгдэл, зэврэлт байгааг шалгаж тогтооно.
- Ослоос хамгаалах хэрэгслүүдийг ажиллуулж туршиж үзэх.
- Металл хийцэд үл эвдлэх аргаар шинжилгээ хийх.
- Газардуулга, дамжуулагчийн тусгаарлагчийн эсэргүүцэл, хэлхээний хамгаалах тоноглолыг турших.

Шинжилгээний үр дүнг үндэслэн лифтийн цаашид ашиглагдах хугацааг тогтооно.

29.31. Техникийн туршилт, оношлол, магадлалын үр дүнгээр акт үйлдэж, паспортад тэмдэглэл хийнэ. Харин шинжилгээний үр дүнгээр экспертийн дүгнэлт гарна.

29.32. Техникийн магадлалыг эрх бүхий байгууллага нь техникийн магадлал хийх ерөнхий технологийг /хавсралт 8/ мөрдлөг болгон гүйцэтгэнэ.

29.33. Техникийн оношлол, магадлал хийх магадлалын байгууллага /зөвлөх үйлчилгээ үзүүлэгч/ нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Лифт эзэмшигчидээс техникийн магадлал хийлгэхээр мэдэгдсэн хугацаанд нь гүйцэтгэх. Үүний тулд үйлчилдэг байгууллагатайгаа ажлын график урьдчилан хийсэн байх.
- Лифтэнд үзлэг хийх үедээ ашиглалт хариуцагчид лифтийн бүх эд анги, механизмын техникийн байдал ямар түвшинд байгааг үзүүлэн тайлбарлаад актанд солих шаардлагатай буюу элэгдэлд ороод эхэлчихсэн эд ангийн талаар тодорхой зааж өгнө.
- Техникийн магадлал хийх үед лифтийн туслах ажилчдыг оролцуулах зайлшгүй шаардлага гарвал тэдэнд аюулгүй ажиллагааны зааварчлага өгөөд нэг хүний командаар ажиллагааг явуулна.
- Магадлалын үед илэрсэн зөрчил дутагдлын талаар лифт эзэмшигч байгууллагын удирдлагад мэдэгдэж уг зөрчлийн гарсан шалтгаан арилгах арга замын талаар заавар зөвлөгөө өгнө.
- Сар бүр магадлал хийсэн лифтийн техникийн байдлын талаар улсын байцаагчид тайлагнаж байна.
- Лифтийн техникийн байдалд дүгнэлт гаргах үед улсын байцаагчийн шаардлагаар лифтийн үзлэгт оролцоно.

29.34. Техникийн магадлал ба үзлэг, шалгалтаар доорхи зөрчлүүд илэрсэн нөхцөлд лифтийг ашиглалтад оруулах буюу цаашид ашиглахыг хориглоно. Үүнд:

- Техникийн магадлал ба үзлэг, шалгалтын үед арилгаж болохгүй, лифтийн ашиглалтын аюулгүй ажиллагаанд нөлөөлөх гэмтлүүд илэрсэн.
- Улсын байцаагч болон барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн өгсөн шаардлагыг биелүүлээгүй.
- Лифтийн ашиглалт хариуцагч томилогдоогүй.
- Лифтийн засвар ба техникийн үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулах хариуцагч томилогдоогүй буюу мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулаагүй.
- Мэргэжлийн лифтчин байхгүй.

29.35. Магадлал хийсэн лифтийн актны нэг хувийг магадлал хийснээс хойш 3 хоногийн дотор тухайн орон нутгийн улсын байцаагчид өгч байна.

30. МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

30.1. Цахилгаан механикч, лифтчин, диспетчерийн мэдлэгийн ээлжит шалгалтыг 12 сар тутамд байгууллагаас байгуулсан комисс сургалтыг явуулсны үндсэн дээр дотооддоо зохион байгуулна. Цахилгаан механикчийн ээлжит мэдлэгийн шалгалтын комисст улсын байцаагч заавал оролцоно. Харин лифтчин, диспетчерын ээлжит мэдлэгийн шалгалтанд улсын байцаагч заавал оролцох шаардлагагүй.

30.2. Ээлжит бус шалгалтыг цахилгаан механикч, лифтчин, диспетчерээс дараах тохиолдолд авна. Үүнд:

- Өөр ажилд шилжсэн үед.
- Улсын байцаагчийн шаардсанаар.

30.3. Мэдлэгийн ээлжит шалгалтыг ажилд орсноос хойш 1 сараас ихгүй хугацаанд, цаашид 12 сар тутамд үечилсэн хэлбэрээр авч протокол үйлдэн үнэмлэхэд нь тэмдэглэл хийж тэмдэг дарж баталгаажуулна.

30.4. Үйлчлэх ажилчдын мэдлэгийг шалгасан материалыг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

30.5. Цахилгаан механикч, лифтчин, диспетчерийг бэлтгэх сургалт, шалгаруулалтыг мэргэжлийн сургалтын төв, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан зохих сургалтын бааз, багшлах боловсон хүчин бүхий байгууллага гүйцэтгэнэ

Шалгалтын дүнгээр протокол үйлдэж тэнцсэн хүмүүст үнэмлэх олгоно.

30.6. Үйлчлэх ажилчид нь цахилгааны аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зохих түвшинд бэлтгэгдсэн байна.

31. ЛИФТИЙН АЖИЛЛАГААНД ДИСПЕТЧЕРИЙН ХЯНАЛТ ТАВИХ

31.1. Лифтэнд диспетчерийн хяналт тавих ажлыг эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, мэргэжлийн боловсон хүчин бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

31.2. Лифтийн диспетчерийн хяналтыг эрх бүхий байгууллагаар шалгагдаж, тогтоосон журмын дагуу хэрэглэгдэхээр зөвшөөрөгдсөн диспетчерийн пунктээр хэрэгжүүлнэ.

31.3. Угсралт, засвар, шинэчлэл, техникийн үйлчилгээ, тоног төхөөрөмжийг солих ажлын төслийг гүйцэтгэх, бэлтгэх үйл ажиллагаанд зориулалтын техникийн хэрэгсэл, мэргэшсэн мэргэжилтэн бүхий байгууллага диспетчерийн хяналт тогтооно.

31.4. Диспетчерийн хяналт хэрэгжүүлэх тоног төхөөрөмж эзэмшигч нь шаардагдах засвар үйлчилгээг хийх замаар түүний бүрэн бүтэн байдлыг ханган ажиллана. Энэ зорилгоор мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж болно.

31.5. Диспетчерийн хяналт хэрэгжүүлэх тоног төхөөрөмжид лифтийг угсарч, шинэчилсний дараа болон тогтоосон хугацаанд үечилсэн хэлбэрээр бэлтгэн нийлүүлэгчээс өгсөн ашиглалтын бичиг баримтын дагуу үзлэг шалгалт хийж байна.

31.6. Диспетчерийн хяналт хэрэгжүүлэх тоног төхөөрөмжид лифтийн ажиллагааг алсаас зогсоох удирлага байх боловч алсаас ажиллуулах удирдлага байж болохгүй.

31.7. Диспетчерийн хяналт нь дараах боломжоор хангагдсан байна. Үүнд:

- Диспетчерийн пунктээс бүхээгтэй, машины өрөөтэй ярих утсан холбоогоор хангагдсан байх ба диспетчерийг дуудах дуут дохиололтой байх.
- Бүхээг давхарт ирээгүй үед хаалга онгойхыг мэдээлдэг байх.
- Машины, блокийн өрөө, машины өрөөг орлох шкафын хаалга онгойхыг мэдээлдэг байх.
- Лифтийн ослоос хамгаалах цахилгаан хэлхээ ажиллахыг мэдээлдэг байх.
- Аль лифтнээс ямар мэдээлэл ирж байгааг тодорхойлох боломжтой байх.

Диспетчерийн хяналтад лифтийн техникийн байдлыг мэдээлэх нэмэлт мэдээллийн хэрэгсэлтэй байж болно.

31.8. Диспетчерийн хяналтын цахилгааны тэжээл лифтийн цахилгааны тэжээлээс тусдаа байх ба диспетчерийн хяналтын тэжээл тасарсан үед 1 цагаас багагүй хугацаанд бүхээг диспетчерийн пунктын хооронд ярих утсан холбоо ажиллагаатай байхаар хийгдсэн байна.

32. БУСАД ЗҮЙЛ

32.1. Лифт түүний ашиглалтын үед энэ дүрмээс гадуур зохицуулах асуудлыг тусад журам гарган зохицуулна. Энэ нь дүрмээр тавигдаж буй шаардлагатай зөрчилдөхгүй байна.

32.2. Энэ дүрэм гарахаас өмнө ашиглаж байгаа лифтийг энэ дүрэмд зохицуулж өөрчлөхгүй байж болно.

32.3. Энэхүү дүрэмд тусгагдаагүй лифтийн техникийн шинэ шийдлийг хэрэглэхийг зөвшөөрнө. Энэ үед аюулгүй ажиллах нөхцлийг хангасан талаар тогтоосон журмын дагуу баталгаажуулсан байна.

33. ОСОЛ АВААРИЙГ ШАЛГАН СУДЛАХ

33.1. Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлсэн лифтийн угсралт, ашиглалт, засвар шинэчлэлттэй хобогдсон осол, аваарийг судлах, дүгнэлт гаргах ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

33.2. Лифт эзэмшигч нь осол аваар гарсан даруйд мэргэжлийн хяналтын байгууллагад 24 цагийн дотор яаралтай мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв гарсан осол аваар нь цаашид хүний амь нас, эрүүл мэндэд хор хүргэхгүй нөхцөлд байвал улсын байцаагчыг иртэл нь осол аваарийн ул мөрийг хэвээр хадгалж байвал зохино.

Осол аваарийн талаар холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэх ёстой.

34. ДҮРЭМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

34.1. Энэхүү дүрмийг лифтийн зураг төсөл зохиох түүнийг үйлдвэрлэх, ашиглах, угсрах, засварлах ба лифтийг суурилуулах барилга, байгууламжийн зураг төсөл хийхэд оролцогч бүх аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэд мөрдөнө.

34.2. Энэхүү дүрмийн заалтыг зөрчсөн хуулийн этгээд албан тушаалтанд тухайн зөрчил нь осол аваарийн байдалд хүргэсэн эсэхийг харгалзахгүйгээр Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

34.3. Бүх шатны албан тушаалтан өөрийн удирдлагад ажилладаг ажилтанд энэ дүрэмд нийцээгүй үүрэг даалгавар өгөх болон шийдвэр гаргах, байцаагч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч үйл ажиллагааг нь зогсоосон лифтийг дур мэдэн ажиллуулах буюу илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авахгүй байх зэрэг нь ноцтой зөрчилд тооцогдоно.

34.4. Зөрчлийн шинж байдал, түүний үр дагавраас хамааруулан гэм буруутай хүмүүст захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

1 дүгээр хавсралт

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

1. Аажмаар тоормослон баригч - тоормосны барих хэсэгтээ пүрш хэрэглэдэг хүчний системтэй баригч.
2. Аажмаар өсөх хүчний баригч – тоормослох зам ихсэх тусам тоормослох хүч нь дагаж өсдөг аажмаар тоормослох баригч.
3. Автомат бус цоожтой хаалга – хаалгыг түгжих ба онгойлгох үйлдэл нь гараар гүйцэтгэгддэг хаалга.
4. Ажлын горим – лифтийн хэвийн даацаас хэтрээгүй ачаатай, хэвийн хурдаар нь хөдөлгөөнд оруулах горим.
5. Ажлын хурд – хэвийн хурдаас 15 хувиар ихсэж болох бүхээгийн хөдөлгөөний хурд.
6. Амортизатор – огцом хөдөлгөөний хурдыг сааруулан хязгаарладаг төхөөрөмж.
7. Ачааны лифт – зөвхөн ачаа зөөвөрлөх зориулалттай лифт.
8. Баригч – хурд хязгаарлагчийн удирдлагаар бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийг чиглүүлэгч зам төмөрт барьж зогсоох ослоос хамгаалах тоноглол.
9. Блок – ган татлаганы чиглэлийг өөрчилдөг, гол дээрээ чөлөөтэй эргэдэг дугуй эд анги.
10. Блокийн өрөө - ган татлагын блокууд байрлах тусгай өрөө.
11. Бүлүүр - шингэний цилиндрийн хөдөлгөөнт хэсэг.
12. Бүхээгийн багтаамж – шалны ашигтай талбайн хэмжээнээс хамааруулан тооцоологдсон зорчигчдын тоо.
13. Бүхээгийн зогсоолын түвшин – бүхээгийн хаалганы босго ба хонгилын хаалганы босгоны хоорондох өндрийн зай. Энэ зайг бүхээг талбайд бүрэн зогссон үед хэмжинэ.
14. Бүхээгийн шалны ашигтай талбай – бүхээгийн хана ба хаалганы дотоод хэсгээр хашигдсан шалны талбай.
15. Гадна удирдлагатай лифт – зөвхөн хонгилын гаднаас удирдагддаг лифт.
16. Галын аюулын горим – гал гарсан үед бүхээг нь зорчигчийг үндсэн зогсоолд хүргэж гадна ба дотор дуудлагыг тасална.
17. Гуллагч - бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн чиглүүлэгчтэй харьцаж, харилцан хөдлөхөд завсар нь байрлах элэгдлээс хамгаалсан тусгай материалаар хийсэн эд анги.
18. Даац – лифтийн зөөвөрлөх зориулалттай ачааны хамгийн их жин.

19. Дамар - бүхээг, эсрэг ачаа /тэнцүүлэгч/-г өргөж буулгах татлагад хөдөлгөөн дамжуулдаг лебедкийн редукторын гол дээр байрлах эд анги.
20. Динамик ачаалал – лифт ажиллах үед түүний хөдөлгөөнөөс үүссэн доргио, чичиргээ, инерцийн хүчний үйлчлэлээс үүсэх ачаалал.
21. Дотоод удирдлага – лифтийг хөдөлгөөнд оруулж буй тушаал нь зөвхөн бүхээг дотроос өгөгдөж буй удирдлагын төрөл.
22. Дохиоллын хэлхээ – ослоос хамгаалах цахилгаан хэрэгслийн гадагш өгөх мэдээллийг дамжуулах цахилгаан дамжуулах хэлхээ.
23. Дуудлагын товчлуур – бүхээгийг зогсоолын түвшинд авчрах, давхарт байрлах товчлуур.
24. Зөөлөвч тулгуур - бүхээг /эсрэг ачаа/ зогсоолын доод /дээд/ түвшингээс доошлох /дээшлэх/ үед тэдгээрийн үл хөдлөх хэсэгт тулах мөргөлтийн хүчийг зөөллөн, зогсоох зориулалттай эд анги
25. Эргүүлэг /өргүүр/ – лифтийн бүхээгийг хөдөлгөөнд оруулах зорилготой цахилгаан хөдөлгүүр, түүнээс өгөгдөж буй механик энергийг ган татлага хөтлөгч хүрдэнд дамжуулах механизм бүхий төхөөрөмж.
26. Лифтийн шинэчлэл – цахилгааны болон кинематик схем, лифтийн паспортын үзүүлэлтэд өөрчлөлт оруулах хэмжээний техникийн өөрчлөлт хийх.
27. “Машины өрөөнөөс удирдах” горим – бүхээгийн ажиллагааг зөвхөн машины өрөөнөөс удирдан ажиллуулах ба энэ үед бүхээг давхарт зогссон үед аль ч хаалга онгойхгүй бусад бүх горимын удирдлага ажиллахгүй байх горим.
28. Огцом тоормослох баригч - бүтэцдээ зөөлөн, уян хатан эд ангийг агуулаагүй баригч.
29. Оруулах төхөөрөмж – лифтэнд өгөгдөж байгаа цахилгааны тэжээлийн эхэнд тавигдах, хүчдэлийн тэжээлийн шугамыг залгах ба таслах зориулалттай цахилгаан тоноглол.
30. Ослоос хамгаалах хэрэгсэл – лифтийн аюулгүй ажиллагааг хангах зориулалттай цахилгаан болон механик төхөөрөмж.
31. Ослоос хамгаалах цахилгаан хэлхээ - ослоос хамгаалах цахилгаан хэрэгслийн цахилгаан гүйдлийг дамжуулдаг хэлхээ.
32. Төгсгөлийн унтраалга – хөдөлж байгаа биеийн механик хүчний үйлчлэлээр цахилгаан тэжээлийг салгадаг хэрэгсэл.
33. Тушаах товчлуур – бүхээг дотроос лифтийг удирдах зориулалттай товчлуур.
34. Тэнцүүлэгч - хөтлөгч хүрдтэй лифтэнд эсрэг ачааны оронд хэрэглэх ачаа.

35. Удирдлагын систем – лифтийг ашиглах үед түүнд аливаа үйлдэл хийх дуудлага, тушаалыг лифтийн үйлдлийн системд дамжуулах хэрэгслийн иж бүрдэл.

36. Удирдлагын хэлхээ – цахилгаан эд ангиудыг шаардлагатай үед нь ажиллуулах зорилго бүхий цахилгаан хэлхээ.

37. “үзлэг” горим – бүхээгийн ажиллагааг зөвхөн бүхээгний орой дээр байрлах удирдлагаар ажиллуулах ба энэ үед бүхээг давхарт зогссон үед аль ч хаалга онгойхгүй, бусад бүх удирдлага ажиллахгүй байх горим.

38. Хавсарсан удирдлага – лифтийг дуудах болон тушаах товчлуураар удирдах хэлбэр.

39. Шингэний зөөлөвч тулгуур – шингэний цилиндрт байгаа шингэн нь бүлүүрийн даралтаар цилиндрийн багасгасан сувгаар гарахдаа бүлүүрийн явалтыг удаашруулж, хөдөлгөөнийг зөөллөх зориулалтын систем.

40. Хонгилын худаг – лифтийн хонгилын доод зогсоолоос доош байх хийц хэсэг.

41. Нэгдсэн удирдлага - өгөгдсөн программын дагуу 2 буюу түүнээс дээш лифтийг хамтатган удирдах удирдлагын систем.

42. Хурд хязгаарлагч - Бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн хурд хэтэрсэн тохиолдолд тэдгээрийн баригчийн төхөөрөмжийг ажиллуулах зорилготой төхөөрөмж.

43. Хүн зөөврийн лифт – зөвхөн хүн зөөвөрлөх зориулалттай лифт.

44. Хүрд – татлаганы нэг үзүүр өөрт нь бэхлэгсэн ба хөдөлгүүрийн тусламжтай эргэхдээ татлагыг өөртөө ороох буюу хөвөх журмаар татлаганд бэхлэгдсэн бүхээгийг шилжүүлдэг лебедкийн нэг эд анги.

45. Хүчний хэлхээ – цахилгааны энергийг хуваарилах, дамжуулах, үзүүлэлтийг нь өөрчлөх цахилгаан хэлхээ.

46. Хэвийн хурд – бүхээгийн тооцоологдсон хамгийн их хурд.

47. “Хэвийн ажиллагаа” горим – лифт зорчигчдод үйлчлэх хэвийн ажиллагааны нөхцлийг ханган ажиллах горим.

48. Хэрэглэх зөвшөөрөл олгох – лифтийг олноор үйлдвэрлэхийн өмнө түүнийг тусгай лабораторид үйлдвэрийн туршилт хийгээд тэнцсэн тохиолдолд үйлдвэрлэн борлуулж болох зөвшөөрлийг олгох үйлдэл

49. Цуглуулах удирдлага – хэд хэдэн тушаал өгөхөд тэдгээрийг өөрийн санамждаа хадгалаад тэдгээр тушаалыг өгсөн дарааллах нь дагуу гүйцэтгэдэг удирдлагын систем.

50. Чиглүүлэгч – бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн хоёр хажууд байрлаж тэдгээрийн шилжих хөдөлгөөнийг чиглүүлж өгөх төмөр зам.

51. Шингэний цилиндр – шингэний даралтын энергийг давших, буцах хөдөлгөөн бүхий механик энерги болгон өөрчилдөг шингэний хөдөлгүүр

54. Шингэн шахуургат лифт – Бүхээгийг шингэний систем бүхий төхөөрөмжөөр шилжүүлдэг лифт.

2 дугаар хавсралт

ЛИФТИЙН ПАСПОРТ

Лифтийг.....-ын
зөвшөөрөл өгсөн байгууллага
20.. оны .. сарын .. өдрийн -р зөвшөөрлийг үндэслэн үйлдвэрлэв.

Лифтийг өөр эзэмшигчид шилжүүлэх үед энэхүү паспортыг лифтийн хамт шилжүүлнэ.

Бэлтгэн нийлүүлэгчийн нэр, хаяг	
---------------------------------	--

Лифтийн паспортанд хавсрагдах баримтуудын жагсаалт

Баримтын нэр	Баримтын тэмдэглэгээ	Хуудасны тоо
Угсаргааны зураг		
Цахилгааны зарчмын схем, схемийн элементийн жагсаалт		
Шингэний зарчмын схем, схемийн элементийн жагсаалт		
Бусад техник ашиглалтын зааврууд		

Ерөнхий мэдээлэл

Үйлдвэрлэгч байгууллага	
Лифтийн төрөл, хэлбэр	
Үйлдвэрийн дугаар	
Үйлдвэрлэсэн он	
Хонгил ба машины өрөөн дэх зөвшөөрөгдөх температур /С/ /хамгийн их ба бага/	

Лифтийн ашиглалтын орчин /чийглэг, тоосжилт, галын ба дэлбэрэх аюул/	
Лифтийн үндсэн техникийн бичиг баримтууд /нэр ба тэмдэглэл/	
Зориулалт, ашиглагдах хугацаа	

2. Техникийн үндсэн үзүүлэлтүүд

2.1. Ерөнхий мэдээлэл

Даац кг	
Зорчигчдын тоо	
Бүхээгийн хэвийн хурд м/с	
Бүхээгийн “Үзлэг” горимоор ажиллуулах хурд м/с	
Удирдлагын хэлбэр	
Зогсоолын тоо	
Хонгилын хаалганы тоо	
Өргөлтийн өндөр м	

	Гүйдлийн хэлбэр	Хүчдэл В	Давтамж
Лифтийн оролтын төхөөрөмж			
Хүчний хэлхээ Лифтийн хөтлүүр Хаалганы хөтлүүр			
Удирдлагын хэлхээ			
Гэрэлтүүлгийн хэлхээ Бүхээг Хонгил Засварын ажил			
Дохиололын хэлхээ			

2.2. Эргүүлэг /өргүүр/

Хэлбэр /редуктортой, редукторгүй, ган татлага хүрдтэй, дамартай, араатай/	
---	--

Үйлдвэрийн дугаар	
Үйлдвэрлэсэн он	
Гаралтын гол дээрх хэвийн эргэх момент НМ	
Масс кг	
Дамрын диаметр, мм	
Блокийн диаметр, мм	

2.2.1. Редуктор

Хэлбэр, маяг	
Үйлдвэрийн дугаар	
Үйлдвэрлэсэн он	
Дамжуулгын тоо	
Тэнхлэгийн хоорондох зай мм	
Масс кг	

2.2.2. Тоормос

Хэлбэр		
Тоормосны хүрдний диаметр мм		
Тоормосны дамжуулга	Хэлбэр	
	Момент, Н*м	
	Гүйцэтгэх механизмын явалт мм	

2.3. Цахилгаан хөдөлгүүр

Зориулалт	
Хэлбэр	
Гүйдлийн хэлбэр	
Хүчдэл В	
Хэвийн гүйдэл А	
Давтамж Гц	

Чадал кВт	
Хөдөлгүүрийн зөвшөөрөгдөх халалт С /хөндийрүүлэгчийн ангилал/	
Эргэлтийн давтамж эрг/мин	
Ажлын горим ПВ %	
Цагт залгах тоо	
Гүйцэтгэл /ердийн, чийгээс хамгаалалттай, тоосны хамгаалалттай, далайн гэх мэт/ хамгаалалтын зэргийг заасан	
Масс кг	

2.4. Шингэнт дамжуулга

Хэлбэр	
--------	--

2.4.1. Шингэний цилиндр

Хэлбэр	
Тоо	
Үйлдвэрийн дугаар	
Үйлдвэрлэсэн он	
Бүлүүрийн диаметр мм	
Явалт мм	
Ажлын даралт, мПа хамгийн бага хамгийн их	
Туршилтын даралт, Мпа	
Хурд м/сек өргөх үед, багагүй буух үед, ихгүй	
Масс кг	

2.4.2. Шингэнт төхөөрөмж

Хэлбэр	
--------	--

Үйлдвэрийн дугаар	
Ажлын шингэний хамгийн их урсгал дм ³ /мин	
Ажлын шингэн	
Насосны ажлын эзлэхүүн дм ³	
Хамгаалах клапаны тохируулах даралт, мПа	
Туршилтын даралт, мПа	
Масс кг	

2.4.3. Дамжуулах хоолой

Өндөр даралтын хоолой /хэлбэр/	
--------------------------------	--

2.5. Хонгилын хаалга

Бүтэц /гүйж онгойх, эвхэж хаагдах ба онгойх нэгээс хоёр хавтастай/	
Хаалганы нээлхийн хэмжээ /өргөн, өндөр/ мм	
Нээж, хаах арга /гар, хагас автомат, автомат/	
Дамжуулга /цахилгаан, шингэн, пүрштэй гэх мэт/	
Бүхээг зогсоолын талбайд зогссон үед хонгилын хаалгыг онгойлгох арга	
Бүхээг зогсоолын талбайд байхгүй үед хонгилын хаалга онгойлгох арга	

2.6. Бүхээг

Дотор хэмжээ, мм өргөн гүн өндөр	
Шалны бүтэц /хөдөлгөөнтэй ба хөдөлгөөнгүй/	
Хаалганы бүтэц	
Хаалга нээх, хаах арга /гараар, автомат, хагас автомат/	

Хаалганы дамжуулга /цахилгаан, хийн, гэх мэт/	
Бүхээгийн хэлбэр	
Масс кг	

2.7. Эсрэг ачаа

Масс кг	
---------	--

2.8. Ган татлага

	Бүхээг	Хурд хязгаарлагч
Хэлбэр		
Бүтэц		
Стандартын тэмдэглэл		
Диаметр, мм		
Ган татлагын тоо		
Нэг ган татлагын урт, м		
Ган татлагын тасрах ачаалал Н /кгс/		
Бат бэхийн нөөцийн итгэлцүүр		

2.9. Ослоос хамгаалах хэрэгсэл

2.9.1. Механик төхөөрөмж

		Бүхээг	Эсрэг ачаа
Баригч	Хэлбэр /Аажим тоормослох, огцом тоормослох, амортизатортой г.м/, тэмдэглэл		
	Ямар нөхцөлд ажиллах		

Хурд хязгаарлагч	Хэлбэр /төвөөс зугтах, дүүжин гэх мэт/, тэмдэглэл		
	Хурд хязгаарлагч ажиллах, бүхээг /эсрэг ачаа/-ийн хурд м/с Хамгийн их Хамгийн бага		
Тулгуур зөөлөвч	Хэлбэр /шингэнт, пүршин гэх мэт/		
	Хэвийн үеийн өндөр, мм		
	Тоо ширхэг		

2.10.2. Ослоос хамгаалах хэрэгсэл

Бүхээгний доод давхраас доош шилжихийг хянах	
Бүхээгний дээд давхраас дээш шилжихийг хянах	
Хонгилын хаалганы хаалтын	
Хаалганы хөдөлгүүрийн ремень чангалалтын	
Хонгилын хаалганы автомат түгжээний	
Хонгилын хаалганы автомат бус түгжээний	
Хонгилын аварийн хаалганы	
Хонгилын үйлчилгээний хаалганы	
Хонгилын хяналтын нээлхийн	
Худгийн хаалганы хаалтын	
Бүхээгийн аварийн хаалга, нээлхийн хаалтын	
Бүхээгийн хаалганы хаалтын	
Бүхээгийн даац хэтрэлтийн	
Хурд хязгаарлагчийн	
Хурд хязгаарлагч хэвийн байрлалдаа байгааг хянах	
Лифтийг зогсоох /унтраалга, “зогс” товчлуурууд/	
Баригчийн барилтыг хянах	
Ган татлагын сулралт, суналтын	

Хурд хязгаарлагчийн ган татлагыг чангалах төхөөрөмжийн	
Ган татлагын тэнцвэржүүлэгчийн	
Ган татлагын тэнцвэржүүлэгчийн огцом хөдөлгөөнийг хянах	
Бүхээг шилжүүлэх гар удирдлагын бариулын	
Зөөлөвч тулгуурын хэвийн байрлалд байгааг хянах	
Худагт байрлах удирдлагын хэлхээний унтраалганы	
Блокийн өрөөний удирдлагын хэлхээний унтраалганы	
Засвар үйлчилгээ гүйцэтгэх тавцангийн байрлалын	
Байрлал түгжигчийн байрлалыг хянах	
Бусад таслагчууд	

3 Техникийн бүрэн магадлал хийх үеийн ачаалал

Туршилтын объект	Ачааллын хэмжээ

Лифтийг байрлуулсан газрын нэр

1 хуудас

Лифтийг эзэмшигч байгууллагын нэр	Лифтийг байрлуулсан газар	Лифт байрлуулсан он.сар.өдөр

Лифтийн ашиглалт хариуцагч

2 хуудас

Хариуцагчийг томилсон тушаалын дугаар, он, сар, өдөр	Хариуцагчийн албан тушаал, овог нэр	Гарын үсэг

Лифтийн засвар ба техникийн үйлчилгээний ажил хариуцагч буюу гэрээт мэргэжлийн байгууллага.

2 хуудас

Томилсон тушаалын буюу гэрээний дугаар, он, сар, өдөр	Хариуцагчийн албан тушаал, овог нэр	Гарын үсэг

Лифтэд засвар, шинэчлэл хийсэн тухай

5-аас багагүй хуудас

он, сар, өдөр	Засвар ба шинэчлэлт хийсэн тэмдэглэл	Гүйцэтгэсэн хүний гарын үсэг

Техникийн магадлалын үр дүн

20-иос багагүй хуудас

Магадлал хийсэн он, сар, өдөр	Магадлалын үр дүн	Дараагийн магадлалд орох хугацаа

Лифтийг бүртгэж авсан

(лифтийг бүртгэж авсан хяналтын байгууллагын нэр)

.....

Паспортын дугаартай хуудасны тоо

Паспортын үдэгдсэн хуудасны тоо

Үүнээс зурагтай хуудасны тоо

Бүртгэгчийн албан тушаал, гарын үсэг

Тэмдэг он Сар өдөр

3 дугаар хавсралт

Техникийн магадлалын акт № ...

..... оны сарын-ний өдөр

“Байгууллага”..... -ийн лифтийн байршил
Улсад үйлдвэрлэсэн фирмийн, маркийн,кг
 даацтай,м/с хурдтай, хүн зөөвөр /ачааны/ зориулалттай, зогсоолтой,
 үйлдвэрийн дугаартай лифтэндлифт эзэмшигч.....,“лифт угсралт ба засвар
 үйлчилгээний байгууллага”-ийн нарыг байлцуулан техникийн
ээлжит /ээлжит бус, бүрэн/ магадлалыг хийлээ.

Техникийн магадлалаар статик болон динамик туршилт буюу техникийн бүрэн магадлал үзлэг туршилт хийж дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

1. Лифтэнд бүрэн магадлал хийхэд түүний эд анги механизм дараах байдалтай байв.

№	Шалгагдах зүйлс	Заалт	Зөрчил	Тайлбар
1	Машины өрөө	5.1		
2	Паспорт	1.1		
3	Газардуулгын протокол	26.1		
4	Засвар үйлч. Хариуцагч	27.1		
5	Үндсэн хөдөлгүүр	10.1		
6	Редуктор	10.1		
7	Муфта	10.1		
8	Тоормос	10.1		
9	Дамар /үндсэн ба х. Хязгаарлагч/			
10	Татлага /үндсэн ба х. Хязгаарл./	17.1		
11	Гэрэлтүүлэг	23.1		
12	Цахилгааны самбар	18.1, 19.1, 20.1		
13	Хонгилын хаалга	7.1.		
14	Бүхээгний хаалга	11.1		
15	Хаалганы ролик, зам	7.1.		
16	Хаалга /түгжээ, хөдөлгүүр, ремень/	11.1		
17	Зогсолтын түвшин	хавсралт 8		
18	Тэжээлийн дүүжин утас	22.1		
19	Төгсгөлийн унтраалгууд	21.1		
20	Тэнцвэржүүлэгч /балансир/	12.1		
21	Чиглүүлэгч зам	9.1		
22	Гулгаа /бүхээг эсрэг ачаа/	9.1		
23	Баригч /бүхээг эсрэг ачаа/	13.1		
24	Бүхээг	11.1		

25	Отводка	11.1		
26	Этажник	11.1		
27	Эсрэг ачаа	12.1		
28	Зөөлөвч тулгуур /бүх.эс.ач/	15.1		
29	Хурд хязгаарлагчийн чангалагч, таслагч	21.1		
30	Шалны контакт	21.1		
31	Санамж бичээс	27.6		
32	Хонгилын унтраалга	3.20		
33	Баригчийн таслагч	21.1		
34	Ревиз	20.1		
35	Худаг	4.1.		
37	Оролтын төхөөрөмж	18.1		
38	Хамгаалах хашлага шат	5.1		

2. Лифтэнд статик туршилтыг дүрмийн заалтын дагуу%-ийн нэмэлт ачаалал буюу лифтэндкг /ачааны жин, төрөл/ гүйцэтгэж тоормос алдаагүй, ган татлага дамрын ховил дээр гулгаагүй, цахилгаан шатны даацын хэсгийн металл хийцийн гагнаас бэхэлгээнүүд хэвийн байлаа. Суналтын хэмжээмм хүртэл суусан үр дүнд хүрлээ. Ачааг буулгаж үзэхэд хэвийн байв.

3. Динамик туршилтыг дүрмийн заалтын дагуу%-ийн нэмэлт ачаалал буюу лифтэндкг /ачааны жин, төрөл/ гүйцэтгэж лифтийн хөдөлгөөн хэвийн, дуу чимээ чичиргээ илрээгүй, хурд хязгаарлагч болон баригчийг ажилуулж үзэхэд лифтийг зогсоож чадаж байна.

..... хяналтын

Улсын /ахлах/ байцаагч...../ /

Барилгын зөвлөх

үйлчилгээ үзүүлэгч/...../

Шинжээч...../...../

Шинжээч...../...../

Энэхүү акт лифтийн паспорттай хамт хадгалагдана

4 дүгээр хавсралт

**ЛИФТИЙГ АШИГЛАЛТАНД ХҮЛЭЭН АВАХ
АКТ**

..... оны сарын -ныөдөр хот

Лифтийг ашиглалтанд хүлээн авах комиссын дарга:

Лифтийг ашиглагч-ын төлөөлөгч
(байгууллагын нэр)
..... ажилтай овогтой

Гишүүд: Захиалагч /хөрөнгө оруулагч/-ын
төлөөлөгч
(байгууллагын нэр)
..... ажилтай овогтой

Угсралт, засвар шинэчлэлт хийсэн-ын төлөөлөгч
(байгууллагын нэр)
..... ажилтай овогтой

Барилгын ерөнхий гүйцэтгэгч-ын төлөөлөгч
(байгууллагын нэр)
..... ажилтай овогтой

Эзэмшигчийн лифтийн ашиглалтыг хариуцагч.....
.....ажилтай овогтой

Хяналтын улсын байцаагч-ын
(байгууллагын нэр)
..... ажилтай овогтой

бид хотын дүүргийн хорооны
..... зориулалттай дугаар байранд байрлах
(байрны зориулалт)

лифтийн техникийн бүрэн магадлалын акт, ажиллагаа, ашиглалтыг энэ дүрмийн дагуу зохион байгуулалсан байдлыг үзэж шалгалаа.

ЛИФТИЙГ ХҮЛЭЭН АВСАН ҮР ДҮН:

- 1.Лифт аюулгүй ашиглах нөхцлийг хангасан, бүрэн бүтэн байна гэж үзэв.
- 2.Лифтийн ашиглалт нь “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн зохион байгуулагдсан байна.

Лифтийг хүлээлгэн өгсөн:

Угсралтын байгууллагын төлөөлөгч/ /
Ерөнхий гүйцэтгэгчийн төлөөлөгч/ /
Захиалагчийн төлөөлөгч буюу
Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч
Хувь хүн, хуулийн этгээд/ /

Лифт хүлээн авсан:

Эзэмшигчийн төлөөлөгч.....ажилтай
...../ /

Засвар, үйлчилгээг хариуцагч...../ /
 Комиссийн дарга/ /
 Улсын байцаагч/ /
 Барилгын зөвлөх үйлчилгээ
 үзүүлэгч/ /

Улсын байцаагч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь лифтийн паспортод түүнийг ашиглахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийж, тэмдэг дарна. Энэхүү актыг лифтийн паспортын хамт хадгална

5 дугаар хавсралт

ЛИФТ УГСРАХ АЖЛЫН ЗУРГИЙН БҮТЦЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Угсралтын зурагт лифтийг зөв угсарсан байдлыг дүрмийн дагуу шалгахад шаардагдах хэмжээсүүд тавигдсан байна.

2. Угсралтын зурагт лифтийн тоног төхөөрөмжийн байрлалыг зөв угсарсан байдлыг дүрмийн дагуу шалгахад шаардагдах тоног төхөөрөмж хоорондын харилцан байрлах хэмжээсүүд тавигдан хонгил, машины ба блокын өрөөний зураг зүсэлт, огтлолттойгоор хийгдсэн байна.

3. Угсралтын зурагт:

Лифтийн техникийн товч үзүүлэлт.

Лифтээс барилгад үзүүлэх ачааллын хэмжээ бичигдсэн байна.

4. Зураг төсөл гүйцэтгэсэн мэргэжилтний гарын үсэг, байгууллагын тамгатай байна.

6 дугаар хавсралт

ГАН ТАТЛАГЫН ГОЛОГДОЛ ГАРГАХ НОРМ

1. Томоосны нэг алхмын уртад тасарсан утасны тоогоор ган татлагыг гологдолд гаргах нормыг 3 дугаар хүснэгтийн дагуу гүйцэтгэнэ.

3 дугаар хүснэгт

Дүрмээр тогтоогдсон анхны бат бэхийн нөөцийн илтгэлцүүр D/d харьцаагаар	Ган татлагын хийц			
	6x19=144+1 ос		6x37=222+1 ос	
	Ган татлагын томоосны нэг алхамын урт дахь тасарсан утасны тоогоор гологдол болгох норм			
	Эсрэг томоостой	Дагуу томоостой	Эсрэг томоостой	Дагуу томоостой
9 хүртэл	14	7	23	12
9-10	16	8	26	13
10-12	18	9	29	14
12-14	20	10	32	16
14-16	22	11	35	18
16-с дээш	24	12	38	19

Тайлбар: D – Хүрдний диаметр /мм/, d – Ган татлагын диаметр /мм/, ос – Органик зүрхэвчтэй гэсэн үг.

2.Татлаганы томоосны алхмын уртыг тодорхойлохдоо татлаганы томсон багцны гадна талд тэмдэг тавиад түүнээс татлаганы уртын дагуу томсон багцыг уг

татлаганд байгаа багцын тооны хэмжээгээр тоолоод түүний дараагийн багц дээр тэмдэг тавина. Энэ хоёр тэмдгийн хоорондох зай нь татлаганы алхмын урт болно.

3.Томоосны нэг багцад ижил биш диаметртай утас орсон / $6 \times 19 = 144 + 1$ ос маркийн/ татлагад нарийн утас тасарсныг 1 утас тасарсанд, бүдүүн утас тасарсныг 1,7 утас тасарсанд тооцож бодно.

4. 3 дугаар хүснэгтэд байхгүй татлаганы гологдлын нормыг тодорхойлохдоо түүнтэй багцын тоо, багц доторхи утасны тоогоор хамгийн ойрхон байгаа татлагатай жишиж авна. Жишээ нь нэг зүрхэвчтэй $8 \times 19 = 152$ татлаганы ойролцоо хэмжээтэй татлага нь нэг зүрхэвчтэй $6 \times 19 = 114$ татлага ба гологдолд гаргах тасарсан утасны тоог $96/72$ гэсэн харьцаагаар үржүүлж тодорхойлно. Энд 96 ба 72 нь хоёр татлаганы гадна талын багцнуудын утасны нийт тоо.

5. Гадаргуугийн элэгдэл ба зэврэлтээс хамааруулж алхам дахь тасарсан утасны тооны нормыг тодорхойлохдоо 4 дүгээр хүснэгтэд зааснаар бууруулж тооцно.

4 дүгээр хүснэгт

Өнгөний зэврэлт ба элэгдлийн нөлөөгөөр утасны диаметрийн хорогдол, %	Томоосны алхам дахь тасарсан утасны тоо хүснэгт 3-т заасан нормоос, %
10	85
15	75
20	70
25	60
30 ба түүнээс дээш	50

Утасны анхны диаметр элэгдэл ба зэврэлтээс шалтгаалж 40 хувь ба түүнээс дээш багассан бол уг ган татлагыг гологдол болгоно. Утасны элэгдэл ба зэврэлтийн хэмжээг тодорхойлохдоо түүний тасарсан утасны диаметрыг микрометрээр хэмжиж тодорхойлно.

Ган татлагын аль нэг эрч бүхлээрээ тасарсан байвал түүнийг ашиглахыг хориглоно.

6. Бүхээг 2 тусдаа татлага дээр зүүгдэж байгаа нөхцөлд татлага бүрийг тусад нь гологдолд гаргана. Харин аль их элэгдсэнийг нь дангаар нь сольж болно.

7. Бүхээг 3 ба түүнээс дээш татлага дээр зүүгдэж байгаа үед татлагуудын элэгдлийн дундаж хэмжээгээр гологдолд гаргана. Энэ үед аль нэг татлаганы элэгдэл хүснэгт 1-д заасан нормоос 50 хүртэл хувь хэтрэхийг зөвшөөрнө.

8. Татлага тодорхой хэмжээгээр элэгдсэн боловч гологдол болгох нормд хүрээгүй байгаа татлагыг ашиглахдаа дараахь зүйлсийг анхаарна:

8.1. Үйлчилгээ бүхэндээ татлагыг анхааралтай шалгаж паспортод тэмдэглэж байна;

8.2. Элэгдэл нь гологдол болгох нормд хүрэнгүүт татлагыг солино.

7 дугаар хавсралт

Техникийн оношлол, магадлалын карт

Шалгах зүйл	Гүйцэтгэх технологи	Норм хэмжээ	Бүрэн	Ээлжит	Хэсэгчилсэн
1.Лифт ашиглалтын ажлын зохион байгуулалт 1.1. Бичиг баримтын бүрдэлт.	Лифт эзэмшигч байгууллагын дарга, лифтийн ашиглалт хариуцагчтай уулзана. Лифтийн паспорттай танилцана. Өмнө нь хийлгэсэн техникийн магадлал, туршилтын актыг үзнэ.	Паспортын бичиглэл асуулгын дагуу бүрэн бичигдсэн байх ба лифтэнд хийгдсэн бүх засвар, үйлчилгээ, туршилт гүйцэтгэсэн хүний гарын үсэгний хамт тэмдэглэгдсэн байна. Жил бүр хийлгэсэн магадлалын акт, эсвэл түрүүчийн магадлал тэнцээгүй тухай протокол, түүний дагуу хийгдсэн ажлын тухай материал байна.	+	+	+
1.2 Орон тоо зохион байгуулалтын ажил	Лифтийн ашиглалт хариуцагчийг томилсон тушаалыг шалгана. Лифтийн засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэгчийг томилсон буюу үүнийг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагатай гэрээтэй ажилладаг баримт материалыг, Мэргэжлийн лифтчингээр лифтээ ажиллуулдаг эсэхийг тус тус үзэж шалгана.	Паспорт дээр тэмдэглэл хийж гарын үсэг зуруулсан байна. Засвар үйлчилгээ хийх зөвшөөрөл, лицензийг уг гүйцэтгэгч нь эрх бүхий байгууллагаас авсан байх. Гэрээнд зөвшөөрлийн хуулбарыг хавсаргасан байна. Лифтчин мэргэжлийн үнэмлэхтэй байх ба жил бүр давтан шалгалт өгч үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэсэн байх.	+	+	+
1. Лифтийн үзлэг	Машин зааланд ерөнхий залгуурыг салгаад лифтийг ажиллуулахгүйгээр үзлэг хийнэ		-	+	-
2.1. Үндсэн ба хурд	Ган татлаганы утаснууд тасарсан эсэх,	Тасарсан утасны тоо 7-с багагүй (гологдлын норм үзэх), элэгдэл 40%	-	+	+

хязгаар-лагчийн ган татлага	өнгөн талын гадаргуу нь элэгдсэн, зэвэрсэн, тослогдсон байдлыг үзэж шалгана.	хүртэл. Харин татлаганы нэг бүтэн багц тасарсан бол ашиглахыг хориглоно.			
2.2. Гинж	Элэгдэл, ан цав байгааг үзэж шалгана.	Хөдөлгөөнт холболтууд элэгдээгүй, гагнаасанд ан цав үүсээгүй байна. Холболтууд бат бөх бэхлэгдсэн, утаснуудын холболт дугаар номертой, найдвартай тусгаарлагдсан байна. Контакторууд элэгдээгүй, хайлаагүй байх.	-	+	+
2.3. Цахилгаан тоноглол, шит, газардуулгын байдал.	Цахилгаан аппарат, реле контакторын авалцах хэсгийг шалгах. Релены авалцуурын хөдөлгөөнт хэсэг дээр дарж үзэн хөдөлгөөн гацаагүй эсэх, авалцуурын бохирдол, утасны бүрээс шалбарсан, холболт суларсныг шалгана.	Лебедкийн суурь хөдөлгөөнгүй сулрахааргүй норм хэмжээнд чангалагдсан байна. Редуктороор тос гоожоогүй, тосны түвшин хэвийн хэмжээнд, арааны холхио нь гар удирдлагын хүрдний сул эргэлтээр тодорхойлогдох ба энэ нь бүтэн эргэлтийн 1/10-с хэтрэхгүй байна.	+	+	-
2.4. Лебедкийг шалгах	Лебедкийн бэхэлгээг ганхуулж хөдөлгөж шалгана. Редукторын араануудын сальник, ган таталганы суулт, том арааны холхиог үзнэ.	Накладний элэгдэл анхны зузааны 1/3-с хэтрэхгүй, шкивнээс хөндийрөх хэмжээ нь 0.5-0.8 мм байна. Мөн пүрш хугараагүй, нугасан холбоосууд холхиогүй байна. Муфтны гадаргуу зураас, ан цавгүй байна.	+	+	+
2.5. Тоормосны техникийн байдал.	Пүрш, нугасан холбоосны хугаралт, элэгдлийг үзэх, накладний зузаан түүний муфтнээс хөндийрөх зай, муфтны гадаргуун байдлыг үзнэ.	Татлага дамрын ховлийн ёроолоос 2мм-с багагүй зайтай байх ба ховлийн элэгдэл жигд байх.	-	+	+
2.6. Үндсэн болон, хурд хязгаарлагчийн дамар.	Дамрыг ховлийн элэгдэл, ирмэг, их биений бүтэн ан цавгүй эсэх, гол дээрээ хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байдлыг үзэж		-	+	+

<p>2.7. Лифт ашиглах заавар санамж бичээс хадсан эсэх.</p>	<p>шалгана. Эвдрэхгүй балрахгүй хэмжээнд, уншиж танилцах боломжтойгоор хийснийг шалгана.</p>	<p>Дүрмийн шаардлагы дагуу агуулгатай байх ба үндсэн зогсоолын талбай, бүхээгт байрлуулна.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>
<p>2.8. Машины тасалгаанд лифтийн цахилгааны схем, тосолгооны картыг байрлуулсан эсэх.</p>	<p>Эвдрэхгүй балрахгүй хэмжээнд, уншиж танилцах боломжтойгоор хийснийг шалгана.</p>	<p>Лифтийн паспорт дээрээс авсан байна.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>
<p>3.Лифтийг ачаалалгүй ажиллуулж шалгана.</p>	<p><i>Ерөнхий залгуурыг залгаад сэлгэн залгагчийг "лифтийг машины өрөөнөөс удирдах" байрлалд тавиад дараах ажилбарыг хийнэ.</i></p>	<p>Лебедка сууриараа хөдөлж ганхахгүй байх, редуктор элдэв цохилт, дуугүй ажиллах, тоормос зогсох үер чихраа гулгаагүй барих, муфт савалгаа люфтгүй, татлага шкив дээр гулгахгүй ажиллана.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>
<p>3.1. Лебедканий ажиллагааг шалгана.</p>	<p>Лебедка хэвийн ажиллаж байгаа эсэхийг үзнэ.</p>	<p>Хонгил ба бүхээгний аль нэг хаалгыг онгорхой байлгаж дуудлагын болон тушаалын аль ч товчлуурыг дарахад бүхээг хөдөлгөөнд орохгүй байх.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>
<p>3.2. Хонгилын, бүхээгний хаалганууд</p>	<p>а/ Бүх хаалган дээр хонгил ба бүхээгний хаалганы авалцааг шалгах. б/ Хонгилын хаалганы автомат, автомат биш цоожийг давхар бүрд шалгана.</p>	<p>Бүхээг давхрын талбайгаас дээш доош 200мм-ээс илүү зайд шилжих үед хонгилын хаалга онгойгдохгүй цоожтой байх ба бүхээгийн хаалгыг онгойлгох гэж оролдоход бүхээгийн хаалга онгойгдохгүй байх буюу бүхээгийн хөдөлгөөнийг зогсоож байх.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>

<p>3.3. Хөдөлгөөнт шалтай лифтэнд шалны авалцуурыг шалгана.</p>	<p>Шалан доорх авалцааг дотор нь ачаа байрлуулаад явуулахгүйгээр шалгана.</p> <p>Бүхээгийг дээш доош явуулж үзнэ.</p>	<p>Бүхээгт 15 кг-с дээш ачаа байхад гадны дуудлага авахгүй байх.</p> <p>Ямар нэг дуу чимээ доргио сугсраа чихраа байхгүйгээр ажиллах.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>
<p>3.4. Бүхээг ба түүний явалтыг шалгана.</p>	<p>Ерөнхий залгуурыг залган хүчдэл зөв ирж байгааг шалгана.</p>	<p>Энэ үед ЛСН-1, ЛСН-2 лампа асна. Энэ нь хэлхээн 3 фазад тэжээл байгаа ба дохиоллын хэлхээний буулгах трансформатор ТР3-д хүчдэл өгөгдсөнийг заана.</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>
<p>3.5. Удирдлагын систем</p>	<p>Автомат залгуур ВА-I – г хамгийн дээд байрлалд нь залгаад хүчдэлийн ирэлтийг үзнэ.</p> <p>Автомат залгуур ВА-3 – г залгаж бүхээгний дохиолол гэрэлтүүлгийг шалгана.</p> <p>Сэлгэн залгагч ВР-2 залгуурыг “Нормальная работа” гэдэг дээр байрлуулж лифтийг ажиллуулж үзнэ.</p> <p>Сэлгэн залгагч ВР-2 залгуурыг “Управление из машинного помещения” горим дээр байрлуулж лифтийг гаднаас дуудах буюу дотроос удирдахыг оролдоно.</p> <p>Сэлгэн залгагч ВР-2 залгуурыг “Ревизия” горим дээр байрлуулж лифтийг гаднаас нь ажиллуулахыг оролдох буюу дотроос нь ажиллуулж үзнэ.</p>	<p>Ингэснээр КВ ба КН контакторуудад хүчдэл өгөгдөнө.</p> <p>Ингэснээр бүхээгний гэрэлтүүлэг, дохиоллын бууруулах трансформатор ТР-1 – д хүчдэл очно.</p> <p>Энэ үед тушаах буюу дуудах товчлуурын хэлхээнд хүчдэл очно. Эдгээр товчлуураар дуудлага хэвийн явагдах ёстой.</p> <p>Энэ үед гаднаас буюу дотроос дуудлага авахгүй зөвхөн машин заалнаас ажиллуулах боломжтой болно.</p> <p>Энэ үед бүх дуудлага авахгүй ба бүхээг хаана ч байсан хонгилын хаалга онгойхгүй лифтийг бүхээгний орой дээрээс удирдах боломжтой болно.</p> <p>Суудлын лифтэнд хаалга нь онгорхой ч, хаалттай ч байсан дотроо хүнтэй</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">-</p>

<p>3.6. Дохиолол гэрэлтүүлэг ба</p>	<p>“Занято” гэрлэн дохионы ажиллагааг шалгана. Хонгил, бүхээг, машин заалны гэрэлтүүлгийг шалгана.</p>	<p>байвал “занято” гэдэг дохионы гэрэл асна. Бас бүхээг хөдөлгөөнд байхад мөн адил. Харин ачааны лифтэнд хонгилын хаалга онгорхой үед “занято” гэдэг дохионы гэрэл асна. Хонгил, бүхээг, давхрын талбай, машин заал дүрмийн дагуу гэрэлтэй байх.</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>-</p>
<p>3.7. Зогсолтын түвшин</p>	<p>Давхар бүрд лифтийн бүхээгийг зогсоож зогсолтын төвшинг шалгана. Давхар бүрд шалгаж үзнэ.</p>	<p>Бүхээг зогсож байхад бүхээгийн ба хонгилын босгоны төвшингийн зөрүү нь 35мм-с илүүгүй байна.</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>+</p>
<p>4.Лифтийг хонгил дотроос нь үзлэг хийх</p>	<p><i>Сэлгэн залгагчийг “лифтийг бүхээгийн оройгоос удирдах” байрлалд тавиад бүхээгний орой дээр гарч дотроос нь үзлэг хийнэ.</i></p>	<p>Хаалганы самбар нь нэгэн хавтгайд байх ба гацаагүй зөөлөн нээгдэж хаагдана.</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>+</p>
<p>4.1. Бүхээгний хаалганы цоож, түгжээ, самбарын хааж нээгдэх ажиллагаа.</p>	<p>Хаалгыг автоматаар онгойлгож хаалгах мөн түгжээнүүдийг гараар мулталж хаалгыг нээж, хааж үзнэ. Автомат цоожны тээглүүрүүд нь төгөгсгөлийн унтраалгыг бүрэн дардаг байх,төгөгсгөлийн унтраалга нь ажиллагаатай байх. Хаалганы хөдөлгүүрийн ажиллагаа төгөгсгөлийн унтраалгаа бүрэн дарж байгаа байдал.</p>	<p>Автомат түгжээний роликийг гараараа мултлахад түгжээний механизм ямар нэг гацаагүй эхний байрлалдаа очно. Автомат ба автомат бус түгжээний хөдөлгөөнт хэсгийн зай завсар норм хэмжээнд байгааг шалгах. Автомат биш цоож ямар нэг гацаагүй ажиллаж байна. Автомат цоожны тээглүүрийг мултлаад бүхээгийг доош явуулах товчлуурыг дарахад бүхээг доош явахгүй харин тээглүүрийг буцаахад</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>-</p>

		хуучин байрандаа ямар нэг гацаагүй очих ёстой. Түгжээтэй нөхцөлд татуурга тээглүүрийн хоорондох зай 1-1.5 мм байна.			
4.2. Отводкын ажиллагаа ховил роликын байдал.	Ролик отводкийн ховилоор явж өнгөрөхийг үзэх , завсар зайг нь хэмжиж хавиралт, шүргэлт байгааг шалгах.	Отводкын ховил автомат түгжээний ролик хоёрын завсар 4-5мм байхыг шалгана. Энэ алдагдвал лифтийн ажиллагаанд цохилт ажиглагдана.			
4.3. Чиглүүлэгч зам.	Чиглүүлэгч зам төмрийн муруй тахирыг нүдээр, штихмасс-аар тавилтыг үзэж бэхэлгээний боолтуудыг суларсан эсэхийг шалгана.	Чиглүүлэгч зам тэгш шулуун, гулгагчтай шүргэлцэх хэсэг нь өө сэвгүй, завсар нь жигд байна.	+	+	-
4.4. Балансир	Үүнд рам дээр гишгэж салгуур ажиллаж байгаа эсэхийг, балансирын хэвтээ байдлын байрлалыг шалгана.	Балансирын салгагч дээр дарахад бүхээгний хөдөлгөөн зогсож байх ёстой. Балансирын рам бүхээгний шалтай параллель байна.	+	+	-
4.5.Эсрэг ачаа	Энд түүний бэхэлгээ, пүрш, гулгаа, пальцны түгжээ, татлага хавчигдсан эсэх зэргийг үзнэ.	Пүрш хугараагүй, бэхэлгээ найдвартай байна.	+	+	-
4.6.Тэжээлийн дүүжин утас	Тэжээлийн дүүжин утасны бэхэлгээ, аюулгүй байдлыг шалгана.	Дүүжин утас шалбараагүй, хөдөлгөөний үед ямар нэг зүйлд тээглэхээргүй байна.	+	+	-
4.7.Аваарын баригч.	Баригч, түүний ажиллагааг гараар хөдөлгөн холхиулж үзнэ.	Баригч гацаагүй, эмтэрч хугараагүй байна. Пүрш хугараагүй, шингэний	+	+	-

4.8.Буферийн төхөөрөмж	Худагт орж буферийн төхөөрөмжийг үзэж шалгана.	тулгууртай лифтэнд шингэн алдаагүй байна.	+	+	+
4.9.Бүхээгний гулгаа.	Гулгааг үзэж, завсруудыг шалгана.	Гулгаа чиглүүлэгчийн нийлбэр завсар 5мм-с, дагуу гүйлтийн завсар 8 мм-с ихгүй байна	+	+	-
4.10.Хурд хязгаарлагчийн чангалагч түүний таслагч.	Хурд хязгаарлагчийн чангалагчийг хөдөлгөж, таслагчийг дарж шалгана.	Гацаагүй ажилладаг байна. Таслагчийг дарахад лифт зогсдог байна.	+	+	-
4.11.Эсрэг ачааны буфер	Бүхээгийг хамгийн дээд байрлалд зогсоож эсрэг ачааны зөөлөвч тулгуурыг зайг шалгана.	Энэ нь 100-200мм байх ба 100мм-с бага байвал татлагыг хасна. Пүрш хугараагүй байна.	+	+	-
4.12.Хонгил худгийн байдал	Хонгилд орж худгийн байдлыг үзнэ.	Худаг хоггүй цэвэр байна.	+	+	-
4.13. Дээд доод төгсгөлийн унтраалга.	Лифтийг эцсийн зогсоолуудаас цааш албадан явуулж дээд доод төгсгөлийн унтраалганы ажиллагааг шалгана.	Энэ нь бүхээг төгсгөлийн буудлаас 100мм өнгөрөхөд ажиллах ёстой.	+	+	-
4. Туршилт		Энэ үед баригч барьж байгаа эсэхийг шалгаж үзнэ.	+	+	-
4.1. Хурд хязгаарлагч	Хурд хязгаарлагчийг туршихдаа түүний хурдыг энэ дүрэмд заасан хэмжээгээр ихэсгээд хурдыг хязгаарлаж байгааг		+	+	-
4.2. Баригч	Баригчийг туршихдаа баригч ажиллаад бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/ -ийг чиглүүлэгч дээр зогсоон барьж чадаж	Ээлжит магадлалын үед бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн баригчийг бүхээгт ачаа /бүрэн ба хэсэгчилсэн магадллын үед 110% ачаатай/-гүйгээр шилжүүлж гүйцэтгэнэ. Бүхээгийг ажлын хурдаар шилжиж	+	+	+

<p>4.3. Зөөлөвч тулгуур.</p>	<p>байгааг шалгана. Баригчийг мэдэрч ажиллах ёстой нөхцөл бүр дээр нь тусад нь туршиж үзнэ.</p> <p>Пүрштэй тулгуурыг турших шаардлагагүй түүний байдал, байх ёстой хэмжээсийг үзэж, хэмжиж шалгана. Цохилтыг сааруулах материалаар хийгдсэн зөөлөвч тулгуурын хувьд хоосон бүхээгийг 0.71 м/с хурдаар шилжүүлж тулгуур дээр буулгаж туршина.</p> <p>Зөөлөвч тулгуурын ажиллагааг шалгах үед дээд ба доод давхрын салгуурыг ажиллахгүй болгох ба бүхээг, эсрэг ачаа тулгуур дээр суух үед цахилгаан хөдөлгүүрийн хүчдэлийг төгсгөлийн салгуураар салгана.</p>	<p>байх үед баригчийг турших ба 1 м/с-ээс их хурдтай лифтэнд ажлын хурднаас бага хурдаар туршиж болох боловч энэ хурд нь 1 м/с-ээс багагүй байна.</p> <p>Пүршин тулгуурын хувьд бүхээг эсрэг ачаа пүрш дээр суух үед хүчтэй доргио үүсэх, пүрш бүрэн шахагдах буюу хугарах үзэгдэл байж болохгүй.</p> <p>Шингэн шахуургат тулгуурын хувьд бүхээг эсрэг ачаа бүлүүр дээр суухад бүлүүр хэт шахагдаж гацах, суларсан үедээ эхний байдалд буцахгүй байж болохгүй.</p>	<p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>+</p>	<p>+</p> <p>-</p>
<p>4.4. Тоормос.</p>	<p>Бүхээгийг ачаагүйгээр дээш шилжүүлж байх үед хөдөлгүүрийг зогсооход тоормос барьж байгааг шалгаж туршина.</p> <p>Ган татлага түүний бэхэлгээг нүдээр үзнэ.</p>	<p>Тоормос найдвартай, гулгаагүй барина</p> <p>Татлаганы суналт, сүлжээс утаснаас тасарч байгаа эсэх, бэхэлгээнүүдийн найдвартай байдал.</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>+</p>
<p>4.5. Баригч, эсрэг ачаа, зөөлөвч тулгуурыг туршисны дараа лифтийн татлага түүнд хамаарах эд ангид ямар нэг гэмтэл илэрсэн</p>		<p>Бүхээгийг шилжүүлээд түүнийг</p>	<p>+</p>	<p>+</p>	<p>+</p>

<p>эсэхийг үзэж шалгана.</p> <p>4.6. Удирдлагат хувьсгуур бүхий хөдөлгүүртэй лифтийн хөдөлгүүрийг паспортад нь зааж өгсөн бол түүний цахилгаан тоормослох чадварыг туршина.</p> <p>4.7. Татлага, дамрын /хүрд/ барьцалдах хэмжээг турших.</p> <p>4.8. Эсрэг ачаа тулгуур дээр бүрэн суусан үед бүхээг дээш шилжихгүй байхыг</p> <p>4.9. Газардуулга, дамжуулагч, тусгаарлагчийн эсэргүүцэл, хэлхээний хамгаалах тоноглолыг шалгана</p>	<p>Цахилгаан хөдөлгүүрийн тоормослох чадварыг шалгахдаа бүхээгийг хамгийн дээд давхарт байхад тоормны колодкийг гар удирдлагаар нь тэлж 3 минут байлгаж үзнэ.</p> <p>Үрэлтийн дамар буюу хүрдтэй лифтны татлага дамар /хүрд/-тай барьцалдах хэмжээг туршихдаа хоосон бүхээгийг хонгилын дээд хэсгээс дээш шилжүүлж бүхээгийг дээд давхарт бүрэн зогсож байгааг шалгана.</p> <p>Бүхээгийг дээш гар удирдлагаар буюу эсвэл хөдөлгүүрийн бага хурдаар шилжүүлэх гэж оролдоно.</p> <p>Дүрмийн шаардлагын дагуу.</p>	<p>давхарт зогсох нарийвчлалыг шалгана.</p> <p>Давхартаа зогсох нарийвчлал дүрмийн дагуу байгааг шалгана.</p> <p>Энэ үед бүхээг дээш шилжихгүй байх ёстой.</p>	<p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">+</p>	<p style="text-align: center;">+</p> <p style="text-align: center;">-</p> <p style="text-align: center;">-</p> <p style="text-align: center;">-</p> <p style="text-align: center;">-</p> <p style="text-align: center;">+</p>
--	---	--	--	---	---